

# ДЭЛХИЙН БАНК

## МОНГОЛЫН ОЙ МОДНЫ САЛБАРЫН ТОЙМ

(Хэлэлцэх бичиг баримт)

Жон Дик, Ойн менежментийн мэргэжилтэн

Николас Крист, Ойн бүтээгдэхүүн боловсруулалтын мэргэжилтэн

Майкл Муллинс, Ойн бодлого, эдийн засгийн мэргэжилтэн

Викториа, Бритиш Коламбия,

Канад улс

2004 оны 4-р сар

## ТАЛАРХАЛ

Дэлхийн банкнаас Монголд хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд нь Монголын ой модны салбарын асуудлыг зохих ёсоор анхаараагүйг анзаарч энэхүү бичиг баримтыг<sup>1</sup> боловсруулах ажлыг эхлүүлсэн Дэлхийн банкны Зүүн Ази, Номхон далайн бүсийг хариуцсан Байгаль орчин, нийгмийн хөгжлийн газрын биологийн төрөл зүйлийн ахлах мэргэжилтэн Доктор Тони Виттен, энэхүү ажлыг гүйцэтгэхэд зохион байгуулалтын туслалцаа үзүүлсэн Дэлхийн банкны Монгол дахь төлөөлөгчийн газрын Хөтөлбөрийн туслах ажилтан Нэргүйн Сэлэнгэ, Гуржавын Болормаа нарт гүн талархал дэвшүүлье.

Монголын төрийн байгууллагын удирдах албан тушаалтнуудтай хийх уулзалтыг хуваарийн дагуу хурдан шуурхай зохион байгуулж туслалцаа үзүүлсэн Монгол улсын Байгаль орчны яамны хамтын ажиллагааны хэлтсийн ахлах мэргэжилтэн Раднаарагчаагийн Сарангоо, энэхүү бичиг баримтыг Монгол хэлнээ хөрвүүлэхэд мэдлэг оюунаа дайчлан ажилласан Мишиграгчаагийн Бадамлянхуа нарт гялайлаа.

Монголын ой модны салбарт хуримтлуулсан арвин туршлагаа хуваалцаж, Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн номын санг ашиглуулах боломж олгон, Сэлэнгэ аймаг дахь тайгын ойн бүсэд хийх аялалыг зохион байгуулахад туслалцаа үзүүлсэн Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн Байгалийн унаган төрхийг хадгалах, байгалийн нөөцийн тогтвортой менежмент төслийн зөвлөх Ханс Хоффман, тайлангийн эхний төслийг хянан үзэж тодорхой санал зөвлөмж өгсөн Билл Маграф, Крис Финч, Робин Меарнс, Салвадор Ривера, Роберт ван дер Плас нарт баярлалаа.

Энэхүү тайлангийн төгсгөлд нэрийг нь жагсаасан Монголын ой модны салбарын талаар хуримтлуулсан мэдээлэл, туршлага, санал бодлоо хуваалцсан Монголын төрийн болон төрийн бус байгууллагууд, хандивлагч байгууллагуудын мэргэжилтэн, ажилтан нарт гүнээ талархалаа илэрхийлж байна.

Зохиогчид

---

Монголын ой модны салбарын талаарх энэхүү тайланд дурдсан зүйл нь зөвхөн зохиогчдын үзэл бодол бөгөөд тэдний зөвшөөрөлгүйгээр ишлэл татан хэрэглэж үл болно. Энэ нь Дэлхийн банк түүний Гүйцэтгэх захирлууд болон тэднийг төлөөлж буй хүний үзэл бодол, байр суурийг илэрхийлэхгүй. Энэхүү тайланг бэлтгэхэд ашигласан материалыг найдвартай гэж үзсэн эх сурвалжаас авч хэрэглэсэн хэдий ч бүрэн төгс гэж үзэх үндэслэл байхгүй бөгөөд баталгаа гаргаж өгөх боломжгүйг анхаарна уу.

## АГУУЛГА

Талархал	2
Агуулга	3-4
Товчлол	5-6
Хуурангуй	<b>7-9</b>
<b>I. ТАНИЛЦУУЛГА</b> .....	10
1.1 Тойм илтгэлтэй холбоотой урьдчилсан мэдээлэл.....	10
1.2. Газар зүйн байдал .....	11
1.3. Нийгэм эдийн засгийн байдал .....	12
<b>II. ОЙН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ОЙ АШИГЛАЛТЫН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ</b> .....	16
2.1 Монгол улсын ой: Ойн төрөл, тархалт болон төлөв байдал.....	16
2.2 Ойн нөөц ашиглалт.....	17
<b>III. ОЙН МЕНЕЖМЕНТИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЭРХ ЗҮЙН БОЛОН БОДЛОГО ЗОХИЦУУЛАЛТ</b> .....	20
3.1 Ой модны салбар дахь Монгол улсын засгийн газрын байгууллагууд .....	20
3.2 Ойн бодлого, зохицуулалтын арга хэрэгслэлүүд .....	22
3.3 Ойн менежменттэй холбоотой зарим нэн тэргүүний асуудлууд.....	28
<b>IV. МОНГОЛ УЛСЫН ОЙ МОДНЫ АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР</b> .....	34
4.1 Ой модны аж үйлдвэрийн салбарын түүхэн хөгжил .....	34
4.2 Монголын ой модны аж үйлдвэрийн салбарын одоогийн бүтэц.....	35
4.3 Ой модны аж үйлдвэрийн салбарын эдийн засагт оруулж буй хувь нэмэр ..	37
<b>V. ОЙ МОДНЫ АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ШИНЭЧЛЭЛ, БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ГОЛ АСУУДЛУУД БОЛОН БЭРХШЭЭЛҮҮД</b> .....	38
5.1 Модны тогтвортой нийлүүлэлт .....	38
5.2 Хууль тогтоомжийг сахиж мөрдөх, хууль бус үйл ажиллагаа.....	41
5.3 Ой ашиглах зөвшөөрөл болон орон нутгийнхан .....	42
5.4 Нэмүү өртөг буй болгох зорилгоор ойг үр ашигтайгаар боловсруулах.....	47
5.5 Дотоодын түлшний үр ашгийг дээшлүүлэх.....	48
<b>VI. САНАЛ ЗӨВЛӨМЖ</b> .....	51
6.1 Ойн менежмент болон хууль хэрэгжүүлэх үйл ажиллагааг сайжруулах.....	52

6.2	Модны аж ахуй эрхлэх боломж, ойн бүсчлэлийн асуудал.....	52
6.3	Орон нутгийнханд түшиглэсэн ойн нөөцийн менежмент .....	52
6.4	Ойн нөөцийн бүртгэл тооллого, мэдээллийн менежментийг боловсронгуй болгох .....	53
6.5	Модны нөөцийг илүү үр ашигтай ашиглах, модноос өөр төрлийн эх үүсвэрийг ашиглах явдлыг дэмжихэд зах зээлийн арга хэрэгслийг хэрэглэх нь..	53
6.6	Зүсмэл материал, түлээний мод болон ойн модны бус бүтээгдэхүүнийг боловсруулах, өөрчлөн зохион байгуулагдсан салбарт зохих хөрөнгө оруулалт хийх .....	53
<b>VII. ОЙН МОДНЫ САЛБАРТ ДЭЛХИЙН БАНКНААС ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЖ БОЛОХ ЧИГЛЭЛҮҮД.....</b>		
7.1	Ой модны салбарт хандивлагчдаас үзүүлэх тусламжийг зохицуулах.....	54
7.2	Эрх зүйн зохицуулалтын хяналт, хууль сахиулах болон хэрэгжүүлэх асуудлаар чадавхи буй болгох.....	54
7.3	Орон нутгийнхан ойн нөөц баялгийн менежментийг эрхэлсэн туршилтын төслүүд.....	55
7.4	Үр ашиг өндөртэй зуух ба шахмал түлш.....	56

## АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Судалгааны үеэр уулзсан хүмүүс

### ХАВСРАЛТ

1. Хуулийн дагуу болон хууль бус мод бэлтгэл
2. Ойн бодлого, эрх зүй
3. Орон нутгийн тухай ойлголт
4. Ойн модны үйлдвэрлэл: Өнгөрсөн- Өнөөдөр- Ирээдүй

## Товчлол

АХБ	Азийн хөгжлийн банк
БОХА	Байгаль орчныг хамгаалах агентлаг
БОХТМУХ	Байгаль орчныг хамгаалах тухай Монгол Улсын хууль
БОЯ	Байгаль орчны яам
БОУНА	Байгаль, ой, усны нөөцийн агентлаг
БУТМУХ	Байгалийн ургамлын тухай Монгол Улсын хууль
ГТМУХ	Газрын тухай Монгол Улсын хууль
ГТХААН	Германы техникийн хамтын ажиллагааны нийгэмлэг
ДБ	Дэлхийн банк
ДБХС	Дэлхийн байгаль хамгаалах сан
ДДБОС	Даян дэлхийн байгаль орчны сан
ЖЗМБХ	Жилд зөвшөөрөгдөх мод бэлтгэлийн хэмжээ
ЖДӨ	жилийн дундаж өсөлт
ТХХ-21	21-р зууны Тогтвортой хөгжлийн хөтөлбөр
МШУА	Монголын Шинжлэх ухааны академи
МОМУХ	Монголын ой модны үйлдвэрийн холбоо
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МУИС	Монгол Улсын их сургууль
МБНБ	Мод бэлтгэлийн нөлөөг багасгах
НҮБХХ	Нэгдсэн үндэстний байгууллагын Хөгжлийн хөтөлбөр
НҮББОХ	Нэгдсэн үндэстний байгууллагын Байгаль орчны хөтөлбөр
НҮБХХААБ	Нэгдсэн үндэстний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага
ФОУХА	Финландын олон улсын хөгжлийн агентлаг
ТХГ	Тусгай хамгаалалттай газар
ТХБТМУХ	Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай Монгол Улсын хууль
ТХГТМУХ	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай Монгол Улсын хууль

ТББ	Төрийн бус байгууллага
ОТМУХ	Ойн тухай Монгол Улсын хууль (1995)
ОҮЗ	Ойн үндэсний зөвлөл
ОХТТ	Ойн хайгуул төслийн төв
ОҮХ	Ойн үндэсний хөтөлбөр
ОДБ	Ойн дагалт баялаг
ОТМ	Ойн тогтвортой менежмент
УМХГ	Улсын мэргэжлийн хяналтын алба
ҮХЯ	Үйлдвэр худалдааны яам
ҮСГ	Үндэсний статистикийн газар
ЭЗХТЗ	Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөл
ЯОУХАА	Японы олон улсын хамтын ажиллагааны агентлаг
ЯОТА	Японы ойн техникийн агентлаг
Ам.доллар	АНУ-ын доллар
₮	Төгрөг (Монголын мөнгөний нэгж 2003 оны байдлаар 1 ам.доллар 1100 төгрөгтэй тэнцэнэ)
км	километр
км <sup>2</sup>	квадрат километр
м	метр
м <sup>3</sup>	куб метр
Га	гектар

## ХУРААНГУЙ

Энэхүү тайланд Монгол улсад ойн менежментийн талаар баримталж буй өнөөгийн үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийсний дээр, ой модны салбарт гарч болох өөрчлөлтүүд нь тус улсын хөдөөгийн орлого багатай иргэдэд хэрхэн нэмэр болох боломжтойг судалж үзсэн юм. Ойн нөөц, түүний ашиглалтын түвшний талаарх одоо байгаа мэдээлэл нь янз бүр байгаа учраас ойн төлөв байдалд тодорхой үнэлгээ өгөхөд хүндрэл тулгарч байна. Хэдийгээр тоо баримтууд дутагдалтай байгаа ч Монголын ой модны салбар хямралд орж байгаа ба уг хямралыг даван туулахад бэлтгэл хангалтгүй байгаа нь тодорхой байна. Энэхүү тайлангийн үндсэн дүгнэлтүүд нь:

- **Ойн ашиглалтын өнөөгийн тооцоологдсон хэмжээ тогтвортой бус байдал;** ашиглалтын хэмээн нэрлэгдэх бүсүүдэд зөвшөөрөгдсөн жилийн хамгийн дээд хэмжээнээс дор хаяж 4 дахин их, хэрэв хамгаалалттай бүсүүдийн 25 орчим хувийг арилжааны ойн ашиглалтад зөвшөөрсөн бол жилийн зөвшөөрөгдсөн дээд хэмжээнээс дор хаяж 1,75 дахин их байна.
- Ашиглалтад зориулагдсан ойн бүс нь дотоодын бие даасан модны үйлдвэрлэлийн хэрэгцээг хангахад хүрэлцээгүйгээс гадна уг үйлдвэрлэлийг илүү үр ашигтай болгохын тулд тус салбарыг шинэчлэхэд шаардлагатай хөрөнгийг татахад хангалтгүй байна.
- **Жилд бэлтгэж буй нийт модны 36-80 хувийг хууль бусаар бэлтгэж байгаа** ба үүнээс Засгийн газар ямар нэгэн төлбөр, татвар авдаггүй. Энэ байдал нь хэрэглээний болон түлээний модны дотоодын үнийг маш ихээр гажуудуулахад хүргэж байна.
- Мод бэлтгэлийн ажлын дээд хэмжээг тогтоох, мод бэлтгэлийн хураамжийг тогтооход зах зээлийн хүчин зүйлс болон **зах зээлийн үнийн байдлыг тооцоогүй байна.**
- **Одоогоор жилд нийт бэлтгэж буй модны 65-80 хувийг түлээнд ашиглаж байгаа** ба үүнийг хөдөөгийн болон хотын олон ядуу айл өрхийн ахуйн хэрэглээ болон халаалтын зориулалтаар ашиглаж байна.
- Хэрэв өрхийн хэрэгцээнд ашиглах түлшний бусад хэлбэрүүдийг нэвтрүүлэхгүй, ойн хорогдлын одоогийн түвшинг бууруулахгүй бол ирэх арван жилийн эцсээр хот суурин газруудад **түлшний модны асар их хомсдол үүсч эхлэнэ.**
- Засгийн газраас, ойн нөөц хэт их хэмжээгээр ашиглагдаж байгаа үндсэн асуудлыг шийдэхийн оронд ойн хайгуул судалгааны систем, гал түймрийн хяналтын систем, шавьж, өвчний хяналтын зэрэг хоцрогдсон системүүд, мөн ойжуулалт зэрэг төдийлөн ач холбогдолгүй, экологийн болон эдийн засгийн хувьд үндэслэл муутай асуудлуудад анхаарлаа төвлөрүүлж иржээ.
- Дээрээс доош чиглэсэн **журам дүрмүүдийн хэрэгжилт үр дүнгүй** байгаа бөгөөд, хамтын эзэмшлийн ойн менежментийг аажмаар өргөжүүлж, төрийн хуулийн хэрэгжилтийн одоогийн системийг бэхжүүлэх зэргээр хоёр талаас нь ажиллах стратеги нь хууль бус мод бэлтгэлийг багасгахад хамгийн их үр дүнтэй байх төлөвтэй юм.

Уг тайланд, ойн нөөц ихээхэн доройтож, сонголт үгүй болохоос өмнө одоогийн хүндрэлүүдийг шийдэхийн тулд дараах зургаан чиглэлд арга хэмжээ авахыг зөвлөж байна. Нөхцөл байдлыг улам доройтуулахаас зайлсхийхийн тулд эдгээр арга хэмжээг хооронд нь сайн зохицуулж, оновчтой дэс дараатай авч хэрэгжүүлэх шаардлагатай.

- *Ойн бүсчлэл* - (а) одоогийн хамгаалалттай бүс хэмээгдэж буй талбайд багтаж буй ойн экологи болон эдийн засгийн ашиглалтын боломжийг шинжилж, улмаар энэ талбайн зарим хэсгүүдийг тогтвортой менежментийн нөхцөлтэйгээр ашиглалтын бүсэд шилжүүлж болох эсэхийг тогтооно, (б) үүний дараа ашиглалтын бүс дэх ойн орчин үеийн хайгуул судалгаа хийж одоогийн ойн нөөц болон төлөв байдлыг тогтооно. Энэ нь дунд болон урт хугацааны турш жил бүр мод бэлтгэх тогтвортой хэмжээг тооцох үндэс нь болж өгөх юм.
- *Орон нутгийн иргэдэд тулгуурласан ойн нөөцийн менежмент* - Ойн нөөцийг түлшний болон ахуйн зорилгоор тогтвортой ашиглах асуудлыг тусгасан ойн менежментийн илүү хөнгөлөлттэй, шинэ нөхцөлүүдийг орон нутгийн иргэдтэй хэлэлцэх. Эдгээр хөнгөлөлтүүд нь засгийн газар болон орон нутгийн иргэдийн хоорондох түншлэл хэлбэрээр хэрэгжих ёстой ба үүнд засгийн газрын зүгээс сургалт, төлөвлөлтийг хийхэд туслалцаа үзүүлэх ба удирдлагаар хангах зэрэг үүргийг хүлээж, харин орон нутгийн иргэд нь ойн менежментийг хэрэгжүүлэн, мод бэлтгэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүргийг хүлээн, үр шимийг нь хүртэх юм.
- *Ойн менежмент болон зохицуулалтын хэрэгжилт* - Ойн менежментийн төлөвлөгөө болон мод бэлтгэлийн ажлын зөвшөөрлийг Ойн тухай хууль, ойн менежментийн урт хугацааны зорилтууд болон ойн шинжлэх ухааны заалтуудтай нийцүүлэх шаардлагатай. Зохицуулалтын хэрэгжилтийг хангахад бодлогын хүчин чарийлт, мөн байгаль орчны хяналт болон байгаль хамгаалах чиглэлийн сургалт, дэмжлэгийг нэмэгдүүлэх шаардлагатай.
- *Нөөцийн үнэлэлт ба мэдээллийн менежмент* - Ой хайгуул судалгааны системийг сайжруулан, ашиглалтын бүсэд чиглэсэн тооллогын системийг орчин үеийнхэд нийцүүлэх. Түүнчлэн Газар зүйн мэдээллийн систем/компьютерт суурилсан байгаль орчны нөөцийн мэдээллийн менежментийн дэлгэрэнгүй систем, үүний дотор ойн нөөцийн мэдээллийн системийг хөгжүүлэх шаардлагатай.
- *Зах зээлд суурилсан арга хэрэгслүүд* - Модны нөөцийг илүү үр ашигтайгаар ашиглаж, модыг орлох материалын хэрэглээг урамшуулахын тулд зах зээлд суурилсан арга хэрэгслүүдийг нэвтрүүлэх. Үүнд орон нутгийн иргэдэд өгч буй хөнгөлөлтүүдээр үйлдвэрлэсэн модыг худалдах дуудлага худалдаа, мод бэлтгэлийн өнөөгийн системийг эргэж хянах зэрэг арга хэмжээ авах шаардлагатай.
- *Модон болон модон бус ойн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх* - Модны гарц болон чанарыг нэмэгдүүлэхийн тулд жижиг оврын, зөөврийн, туузан хөрөөг ашигласан боловсруулалтын орчин үеийн технологийг нэвтрүүлсэн стратегиудыг нэвтрүүлэн дэмжих. Дотоодын түлшний үр ашгийг нэмэгдүүлэн, боловсруулсан шахмал түлш зэрэг модон бус арилжаалагдах материалуудыг бий болгоход чиглэсэн одоогийн стратегиудыг бэхжүүлж, өргөжүүлэх. Орон нутгийн иргэдэд ойн дагалт баялагийг борлуулснаар илүү их нэмүү өртөг бий болгоход тус болох энгийн технологиудыг ашиглах боломжийн судалгаа болон үлгэр жишээ төслүүдийг дэмжих.

Түүнчлэн уг тайланд, Дэлхийн банкнаас Монгол Улсын ойн салбарт нэлээд хувь нэмэр оруулж болох дөрвөн үндсэн чиглэлийг тодорхойлсон байна. Үүнд:

- *Хандивлагчдыг зохицуулах* - Ойн асуудлаарх зөвлөлдөх бүлгийг сурталчлан, зохион байгуулж, дэмжих ба уг бүлэг нь арга хэмжээг ач холбогдлоор нь эрэмблэсэн ажлын төлөвлөгөө боловсруулах болон зохих техникийн туслалцааг зохицуулахаар засгийн газрын холбогдох агентлагуудтай хамтран ажиллах.
- *Зохицуулалтын хяналт, хэрэгжилтийг хангах чиглэлээр чадавхийг бэхжүүлэх* - Ойн хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавих засгийн газрын чадавхийг бэхжүүлэхийн тулд техникийн туслалцааны төсөл боловсруулан хэрэгжүүлэх. Уг төслийн хүрээнд хэрэгжилтийн үр дүнтэй хөтөлбөрүүдэд зориулсан тоног төхөөрөмжийг хангах (тухайлбал, холбооны тоног төхөөрөмж, тээвэр болон ажлын хувцас зэрэг), сургалтын хоёр хөтөлбөрийг боловсруулах зэрэг ажлууд хийгдэх юм. Үүний эхний сургалтын хөтөлбөр нь ойн хууль тогтоомж, ойн тогтвортой менежментийг нарийвчлан судлахаас гадна, төлөвлөгөөний зүйл ангиудыг хэрэгжилтийн хяналт, хангалтыг нэмэгдүүлэх зөвшөөрлийн нөхцөлүүдэд шилжүүлэх, ойн нөөцийн тооллого ба хяналт, хууль тогтоомжийн хэрэгжилт, хангалт зэрэгт чиглэгдэх юм. Сургалтын хоёр дахь хөтөлбөр нь хууль, журмын хэрэгжилтийн хяналтын ажлын горим болон хэрэгжилтийн арга хэрэгслүүдийг зөв зүйтэй хэрэглэх зэрэг асуудлуудад чиглэгдэх юм.
- *Орон нутгийн ойн менежментийн туршилтууд* - Үйлдвэрлэлд ашиглагдах ойн менежментэд засгийн газар ба орон нутгийн иргэдийн хоорондох гэрээт түншлэлийн үндсэн дээр бий болох ойн менежментийн тогтвортой, оролцооны хөтөлбөрүүдийг туршилтын журмаар хэрэгжүүлэн, дэмжих. Үүний тулд орон нутгийн засаг захиргааны ажилтнууд болон орон нутгийн иргэдийг урьдчилан сургах, ойн менежментийн ажлыг гардан хариуцах орон нутгийн байгууллагуудыг байгуулан, ойн менежментийг үр дүнтэйгээр хэрэгжүүлэхийн тулд чадавхийг байнга бэхжүүлэх зэрэг ажлууд хийгдэх шаардлагатай юм.
- *Хэмнэлтэт зуух ба шахмал тули* - гэрийн сайжруулсан зуухын хэрэглээг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөтөлбөрийг өргөжүүлэх, шахмал түлшийг арилжаанд зориулан үйлдвэрлэх зэргээр түлээний модноос бусад түлшний эх үүсвэрүүдийг үнэлж, дэмжих.

# МОНГОЛЫН ОЙ МОДНЫ САЛБАРЫН ТАЙЛАН

## I. ТАНИЛЦУУЛГА

### 1.1 Тойм илтгэлтэй холбоотой урьдчилсан мэдээлэл

1. 1980 оны эцсээр ЗХУ задрасны дараа Монгол улс нь хуучин социалист улсуудтай харьцуулахад маш эрчимтэйгээр зах зээлийн эдийн засагт шилжиж эхэлсэн байна. Мэдээж энэхүү шилжилт нь аливаа бэрхшээлгүйгээр хийгдээгүй бөгөөд байгаль орчинд ноцтой сөрөг нөлөө үзүүлсэн нийгэм эдийн засгийн үр дагавар авчирсан ба энэ нь түр зуурынх болов уу гэж найдаж байгаа болно. 1990-ээд оны турш хөгжиж буй орнуудад туслалцаа дэмжлэг үзүүлэх үндсэн гол ач холбогдол бүхий:

- ядуурлыг бууруулах, нийгмийн тэгш байдал, тогтвортой амьжиргааг бий болгох,
- хувийн хэвшлийн салбарыг хөгжүүлэх,
- засаглал, хууль захирагдах ёсыг бий болгох,
- санхүүгийн салбарын шинэчлэлийг явуулах
- тогтвортой хөгжил, байгаль орчны унаган төрхийг хадгалах зэрэг асуудлыг харгалзан үзэх замаар Дэлхийн Банкнаас Монгол улсад дэмжлэг туслалцаа үзүүлж ирсэн байна.

Дэлхийн банкнаас Монгол улсад хэрэгжүүлж буй өнөөгийн хөтөлбөрүүд нь дэд бүтцийн хөгжил, санхүүгийн салбарын шинэчлэл, улсын секторын шинэчлэл, эрх зүй, шүүхийн байгууллагын шинэчлэл, хувийн хэвшлийн салбарыг дэмжихэд чиглэгдсэн билээ. Дэлхийн Банк дээр дурдсан асуудлын эхний дөрөвт нь голлон анхаарч ирснээс гадна ядуурлыг арилгах, хөгжлийн эрх тэгш байдлыг хангахад хүч чармайлт тавьсан.

2. Дэлхийн банк нь өнөөг хүртэл байгаль орчин, байгалын нөөц баялгийн салбартай холбоотой асуудалд хязгаарлагдмал байдлаар оролцож ирсэн ба боломжтой туслалцаа дэмжлэгийг мал аж ахуй, бэлчээрийн менежмент болон тусгай хамгаалалттай газрын менежментийн асуудалд голлон зориулсан байна. Гол хандивлагчид болох НҮБХХ, НҮБХХААБ, АХБ, ЯОУХА, ФОУХА болон ГТХАН үйл ажиллагаа явуулж байсан ой модны салбарт Дэлхийн банк идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаагүй. Монголын ойн экологийн ач холбогдол, эмзэг байдал, хотын зах, хөдөө орон нутаг дахь эрчим хүчний найдвартай байдлыг хангахад гүйцэтгэж буй үүрэг ролийг нь харгалзан үзсэний үндсэн дээр Дэлхийн банк энэхүү салбарт үйл ажиллагаа явуулах боломжийг судлан үзэж байгаа болно. Тус Банк ойн тогтвортой менежментийг дэмжин хөхүүлэх, ойгоос хараат, ядуу амьдралтай хөдөө орон нутгийнхны амьжиргааг дээшлүүлэх чиглэлээр энэхүү салбарт одоо үйл ажиллагаа явуулж буй хандивлагчидтай хамтран ажиллахыг эрмэлзэж байна. Ой модны салбарын тойм тайлангийн гол зорилго нь:

- Ойн нөөц баялгийн үнэлгээг хийх, түүний төлөв байдал, ашиглалтын өнөөгийн чиглэл хандлагыг нь тодорхойлох,
- Ой модны салбарын үндэсний болон орон нутгийн эдийн засагт оруулж байсан буюу одоо оруулж буй хувь нэмэр хандивыг тодорхойлох, цаашдын хандлагыг тооцоолон гаргах,

- Ойг хууль бусаар ашигласны улмаас Засгийн газрын алдаж буй орлогыг тооцоолон гаргах,
- Ой модны салбарын бодлого, зохицуулалт, байгууллагын үндсэн үүрэг хариуцлага, эдгээрээс онцлог ойн тогтвортой менежментийг дэмжих эсвэл хязгаарлах магадлалтай эсэхийг үнэлэх,
- Эрчим хүчний хэрэгцээ шаардлагыг хангахад модны гүйцэтгэж буй үүргийг тодорхойлох, үүнийг тогтвортой менежментийн хүрээнд хянах боломжтой эсэхийг судлах,
- Жижиг, дунд хэмжээний модны үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжийг судлах,
- Ой модны салбарыг хөгжүүлэх боломжийн хувилбаруудыг боловсруулах, нийгэм, байгаль орчин, эдийн засагт үзүүлэх нөлөөллийн үнэлгээг хийх,
- Чадавхийг бэхжүүлэх, сургалт явуулах шаардлагыг судлан үзэх,
- Шаардагдаж буй бодлогын шинэчлэл, хөрөнгө оруулалтын үндсэн гол бүрдлүүдийг санал болгох,
- Ирээдүйд Дэлхийн банкнаас туслалцаа үзүүлж болох чиглэлийг санал болгох зэрэг болно.

## 1.2. Газар зүйн байдал

3. Монгол улс төв Азид оршдог, хойд хэсгээрээ Оросын Сибирийн нутаг, зүүн болон урд хэсгээрээ Хятадын Өвөр Монголын нутаг, баруун хэсгээрээ Хятадын Шинжан мужтай хил залгаа. Өргөрөгийн 41°-52° (ойролцоогоор 1200 км), уртрагийн 88°-120° (ойролцоогоор 2400 км)-д байрладаг. Далайн түвшнээс дээших дундаж түвшин нь 1580 м, гэхдээ нийт нутгийн 80 хувь нь 1000 м-ээс дээш өндөрт байрладаг. Хамгийн намхан цэг нь Дорнодын талаас зүүн тийш 518 м-д орших Хөх нуур, хамгийн өндөр цэг нь Монгол Алтайн 4374м-г орших Хүйтэн уул юм. Монгол улс нь зүүнээс баруун зүгт тогтсон эх газрын томоохон усан хагалбар ай сав дээр байрладаг. Энэхүү хагалбар шугамын хойно орших голууд Хойд мөсөн далай (Орхон, Сэлэнгэ) буюу Номхон далайд (Онон, Хэрлэн, Халхын гол) цутгадаг. Хагалбар шугамын өмнө хэсэгт орших голууд ямарч ч гарцгүй Төв Азийн хотгорт цутгадаг. Эх газрын эрс тэс, хуурай уур амьсгалтай, улирлын болон гэрэлтэй байх үеийн температур нь эрс хэлбэлзэлтэй. Температурын эрс тэс ялгааг харуулахын тулд Баянхонгор аймгийн нутаг дахь Их говийн захад орших баянбүрд болох Эгийн гол, Хөвсгөл аймгийн хойд хэсэгт орших Рэнчинлхүмбийн сүм хийд орчмын нутгийн цаг агаарын байдлыг харьцуулан үзүүлье. Сүүлийн 30 жилд Эгийн гол орчмын нутгаар сарын дундаж температур нь 1-р сард -11,8°, 7-р сард 25,2°, Рэнчинлхүмбэ орчмын нутгаар 1-р сард -32°, 7-р сард 12,8° ажээ. Жилд унах хур тунадасны хэмжээ Эгийн гол орчмын нутгаар 38.4 мм, Хэнтий аймгийн Дадал сумын нутаг орчмоор 389,3 мм орчим ажээ. Хур тунадасны ихэнх нь зуны сар буюу 6-р сараас 8-р сарын хооронд унадаг (Байгаль орчны яам, НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, 2002).

4. Монгол улс 1.565 сая хавтгай дөрвөлжин км газар нутагтай нь Их Британиас 6 дахин их бөгөөд АНУ-ын Аляскийн газар нутагтай хэмжээгээрээ адил ажээ. Тус улс Төв Азийн цөл, Сибирийн хөвч тайгын хоорондох дамжин өнгөрөх бүсийг холбодог, 6 том байгалийн бүсээс бүрддэг ба урд хэсгийн нам дор цэгтээ гол төлөв хуурай дулаан, хойд хэсэг болон өндөрлөг газруудаар чийглэг, хүйтэн цаг ууртай. Нам дор цэгээс өндөрлөг цэг хүртэлх энэхүү 6 бүс нь:

- Цөл (ургамал бараг байхгүй)

- Цөлөрхөг хээр (намхан өвстэй, модгүй, тармаг буттай, давжаа модтой)
- Хээр (өргөн навчит өвслөг ургамал бүхий өндөр өвс, модтой,)
- Ойт хээр (хойд налуу хэсгээр холимог ой модтой, урд налуу хэсгээр бэлчээрийн газартай)
- Тайгын ой (хуш, шинэс, нарс бүхий шилмүүст ой)
- Уул (шилмүүст ой, крумхолц, тагийн бүсийн ургамал, тундр зэргээс тогтсон тагийн бүсийн доод хэсэг)

Сүүлийн 3 бүс нь мөнх цэвдэгийн гүн, тархалтаараа (үргэлжилсэн, тасарсан гэх мэт) янз бүр ажээ. Энэхүү 6 бүсийн хамрах газрыг 1-р хүснэгтээр үзүүлэв.

### Хүснэгт 1. Байгалийн бүс бүслүүр

Бүс	Хамрах нутаг (сая хавтгай дөрвөлжин км)	Нийт газар нутгийн хувь хэмжээ
Цөл	0.297	19
Цөлөрхөг	0.329	21
Хээр	0.407	26
Ойт хээр	0.125	8
Тайгын ой	0.063	4
Уул	0.344	22

Эх сурвалж: НУБ-ын Байгаль орчны хөтөлбөр, Байгаль орчны яам (2002)

### 1.3. Нийгэм эдийн засгийн байдал

5. Монгол Улс 2,65 сая орчим хүн амтай. Нийт хүн амын 80 хувь нь Халх Монгол хэдий ч Засгийн газраас гол төлөв Монгол үндэстэн болох турк хэлний ангид багтах Монголын баруун хэсэгт амьдрах казах, хотон, цаатан зэрэг өөр 20 гаруй үндэстэн ястан байдаг гэж үздэг ажээ. 1.5 хүнд нэг хавтгай дөрвөлжин км газар ногдох Монгол Улс нь дэлхий дээр хүн амын нягтаршил хамгийн багатай орон хэдий ч хот суурин газрын төвд нийт хүн амын 57 хувь нь амьдарч буйг харгалзан үзвэл энэ нь зарим байдлаар төөрөгдүүлсэн тоо баримт байж болох талтай. 1960, 1970-аад оны үед Засгийн газраас гэр бүлд зориулж үлэмж хэмжээний татаас олгож байсан учир хүн ам нь бүтцийн хувьд маш залуу, нийт хүн амын бараг 70 хувийг 35 хүртэлх насны залуучууд эзэлдэг. Тухайн үед өсөлтийн коэффициент нь 2,9 хувь (Азид хамгийн өндөр үзүүлэлт) байсан ба 25 жилийн хугацаанд хүн амын тоо хоёр дахин нэмэгдсэн байна. 1980-аад оны сүүлчээс эхлэн өсөлтийн коэффициент буурч 2001 оны байдлаар ойролцоогоор 1,4 хувь болсон байна. Нийт хүн амын 40 хувь ядуурлын доод түвшингээс дор амьдардаг гэж үздэг хэдий ч хүн амын дундаж наслалт 64 нас, 15 нас хүртэлх насны хүмүүсийн 97 хувь нь бичиг үсэгт тайлагдсан нь хөгжиж буй орны хувьд харьцангуй өндөр үзүүлэлт юм.

6. Дотоодын нийт бүтээгдхүүний эзлэх хувь нь 2000 оны байдлаар хөдөө аж ахуйн салбарт 36 хувь, үйлдвэрлэлийн салбарт 22 хувь, үйлчилгээний салбарт 42 хувь байжээ. Нийт хүн амын 900.000 нь ажил эрхэлж байснаас 40 хувь нь хөдөө аж ахуйн, 12 хувь үйлдвэрлэлийн, 48 хувь нь бусад салбарт ажиллаж байжээ. Хагас

нүүдлийн чанартай мал аж ахуйн үйлдвэрлэл нь хөдөө аж ахуйн салбарын нийт орлогын 70 гаруй хувийг, үлдсэн хувийг тариалан эрхлэх боломж бүхий багахан газарт тарьж ургуулсан, хүйтэн цаг агаарт зохицсон үр тариа, буудай, төмс, өвс гэжээл бүрдүүлдэг байна. Эдийн засгийн хамгийн хурдацтай өсөж буй салбар нь уул уурхайн салбар юм. Монгол Улс нь нүүрсний үлэмж нөөцтэй, газрын тос, байгалийн хийн зохих ордтой, металл үйлдвэрлэх (зэс, молибден, алт, мөнгө, хайлуур жонш, гянт, цайр, тугалга, уран, никель гэх мэт) боломжтой. (БОЯ, НҮББОХ 2002).

7. 1980-аад оны эцсээс эхэлсэн эдийн засгийн шилжилтийн үед нийгэм, эдийн засгийн зарим нэг ерөнхий хандлага, чиг баримжаа бий болсон нь Монголын ой мод, байгалийн нөөц баялгийг хамгаалах, хадгалах, ашиглах явцад мэдэгдэхүйц нөлөөлсөн байна. Эдгээр үр нөлөө нь тус улсын байгалийн нөөц баялагт учирсан ерөнхий дарамтыг ойлгож мэдэх, боломжит бодлогын хувилбаруудыг үнэлж үзэхэд чухал ач холбогдолтой юм. Түүнчлэн Дэлхийн банк (2000 б), Рузика (2001), Статистикийн үндэсний төв (2002)-өөс тоймлон гаргасан тодорхой хамаарал бүхий зарим нэг үр дагаврыг дараагийн хэсгүүдэд товчхон дурдсан болно.

8. *Нэг хүнд ногдох орлогын бууралт.* 1990-ээд оны эхээр хийгдэж эхэлсэн эдийн засгийн шинэчлэл, хувьчлалын үйл явц нь Монгол Улсын эдийн засагт үлэмж хэмжээгээр нөлөөлсөн ажээ. 1990 оноос 2002 оны хугацаанд Монголын дундаж иргэний амьжиргааны түвшин дордсон ба нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдхүүн 1989 онд 1645 ам. доллар байсан бол 2002 онд 450 ам.доллар болж буурчээ. Идэвхтэй ажиллах хүчний бараг хагас нь хөдөө аж ахуйн салбарт буюу гол төлөв мал аж ахуйн салбар, мод бэлтгэх, ан агнах, алт олборлох зэрэг албан болон албан бус замаар нөөц баялаг ашиглах үйл ажиллагаанд татагдан орсон байна. Грэйсоны тайланд дурдсанаар өвлийн турш гар аргаар алт олборлох ажиллагааг ядаж наад захын хэмжээнд байлгахын тулд голын хөлдсөн элсийг угаах усыг гэгсгээх зорилгоор хойд талын аймгуудад түлшний модыг ихээхэн хэмжээгээр ашигласан ажээ.

9. *Хот руу шилжих хөдөлгөөн үргэлжилсээр байгаа нь.* Монголын хүн ам 2001 онд 2.44 сая болсон нь 30 жилийн өмнөх хүн амын тоотой харьцуулахад хоёр дахин нэмэгдсэн байна. Хүн амын өсөлт үргэлжилсээр байгаа хэдий ч өсөлтийн түвшин нь буурсан. Хот руу эрчимтэй шилжих хөдөлгөөн 1960-аад оны үеэс эхлэн 1990 онд 57 хувьд хүрсэн нь оргил үе байжээ. 1990-ээд оны дундуур эдийн засгийн хүндрэл бэрхшээлтэй үе байсан тул шилжих хөдөлгөөн түр зуур зогссон хэдий ч 2001 оны байдлаар нийт хүн амын дотор хот суурин газарт суурьшин амьдарч буй хүмүүсийн тоо нь 1990 оны оргил хувь хэмжээнд эргэн хүрсэн байна. Улаанбаатар хотын хүн ам хурдан явцтайгаар үргэлжлэн нэмэгдсээр байгаа бөгөөд 2001 оны байдлаар нийт хүн амын гуравны нэг нь Улаанбаатар хотод төвлөрсөн байна. Хот руу шилжих хөдөлгөөн нь эдийн засаг (ажлын байр гэх мэт) нийгмийн (эрүүл мэнд, боловсрол) учир шалтгаантай ажээ. Хот руу шилжих хөдөлгөөн, тээвэрлэлтийн татаасыг зогсоосон зэрэг шалтгааны улмаас орон гэрээ халаах, хоол унд хийх хэрэгцээ шаардлагыг хангахын тулд хот суурин газрын ойролцоох ой бүхий газарт хэрээс хэтэрсэн ачаалал үүсэн байна.

10. *Өрхийн ядуурал, эмзэг байдал нэмэгдэж байгаа нь.* Ядуурлыг бууруулах нь Монгол Улсад учирч буй хөгжлийн хамгийн бэрхшээлтэй асуудал юм. 1998 онд хийгдсэн амьжиргааны түвшинг хэмжих судалгаагаар нийт хүн амын гуравны нэг нь ядуурлын доод түвшингээс доогуур амьдарч байгааг тогтоожээ. Макро эдийн засгийн нөхцөл байдал доройтож байгаа болон 1998 оноос хойш 2 жил дараалан ган гачиг болсон нь ядуурлын хэмжээг улам нэмэгдүүлсэн байх магадлалтай. 2000 онд хийгдсэн амьжиргааны түвшинг оролцооны аргаар үнэлэх үнэлгээгээр Монголын айл өрхөд байгаль орчин, эрүүл мэнд, нийгмийн аюулгүй байдал, эмзэг байдалтай холбоотой өөр бусад бэрхшээлүүд учирч байгааг олж тогтоосон байна. Ган, хатуу ширүүн өвөл, бэлчээрийн даац хэтрүүлэлт улам бүр нэмэгдэж байгаа

болон байгалын нөөц, баялгийн менежментийн арга барил хоцрогдонгуй байгаа зэрэг нь эдийн засгийг хүндрүүлж байгалийн гамшгийг даван туулах хот суурин газар, хөдөө орон нутгийн хүн амын чадавхийг сулруулж байна.

11. *Төр засгийн байгууллагуудаас үзүүлэх мэргэжлийн шинж чанар бүхий, эцсийн үр дүнд үндэслэсэн үйлчилгээ дутагдаж байгаа нь.* Төрийн секторыг зах зээлд хандсан байгууллага болгон өөрчлөх талаарх Монгол Улсын Засгийн газрын оролдлого нь ололт, бэрхшээл аль алиныг авчирсан байна. Тухайлбал, 1995 оноос хойш төрийн зардал эрчимтэйгээр өсөж ирсэн бөгөөд өрийн нөхцөл байдалд улам бүр хүндрэл учруулж байна. Энэхүү өсөлтийг бүрдүүлж буй гол зүйл нь төрийн албан хаагчдад олгож буй цалин бөгөөд 1995 оноос 2000 оны хооронд 60 хувиар нэмэгдсэн ажээ. Түүнээс гадна одоогийн байдлаар төрийн алба нь сул орон тоогоо зарлаж, мэргэшил ур чадварыг нь харгалзан сонгон шалгаруулж авдаг, тодорхой хугацаагаар ажилладаг мэргэжлийн байгууллагын чанарыг агуулаагүй байна. Төрийн албанд ажиллаж буй олонхи ажилтан нь улс төрийн томилолтоор ажиллаж буй бөгөөд томилогдон очсон ажил, албан тушаалд тохирсон туршлага хуримтлуулаагүй, мэргэшил эзэмшээгүй байдаг ажээ. Энэ нь төр, засгийн газрын бүтээлч, үр дүнтэй ажиллах чадавхид нь сөрөг үр нөлөө үзүүлж байгаа бөгөөд, нэн ялангуяа байгалийн нөөц баялаг, байгаль орчны менежменттэй холбоотой салбарт энэ нь нэн хамааралтай юм.

12. *Бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх орон нутгийн чадавхи шаардлага хангахгүй байгаа нь.* Монгол Улсын Засгийн газар засаглалыг хэрэгжүүлэх, үйлчилгээ хүргэхтэй холбоотой үлэмж үүргийг аймаг, сумдад хариуцуулах замаар төвлөрлийг сааруулах арга хэмжээ авсан нь холимог үр дүнд хүрсэн байна. Ихэнх албан тушаалтнууд олон нийтэд зөвлөлгөө өгөх асуудлаар туршлага багатай төдийгүй сонгуулиас бусад үед орон нутгийнхны санал, үзэл бодлыг сонсож мэдэх албан ёсны механизм хомс байдаг ажээ. Төр, засгийн газрын хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбоотой орон нутгийн засаг захиргааны хүлээх хариуцлагыг нэмэгдүүлсэн хэдий ч бодлого, дүрэм журам гаргах, зааварчлага өгөх замаар удирдан чиглүүлэх, хүний болон санхүүгийн нөөц бололцоогоор хангах явдал байнга дутагдаж байгаа учраас хүссэн үр дүнд хүрч чадахгүй байгаа ажээ.

13. *Тээвэрлэлтийн нэгжийн өртөг өндөр байгаа нь.* Хөдөө орон нутгийн эдийн засгийг хөгжүүлэх, ядуурлыг бууруулахад тулгарч буй томоохон бэрхшээл нь тус улсын өнцөг булан бүрд хүрэхэд бэрхшээлтэй өргөн уудам газар нутаг, хүн амын нягтаршил бага байгаагаас тээвэрлэлтийн өртөг өндөр байдаг явдал юм. 1990 оноос тээвэрлэлтэд үлэмж хэмжээний татаас өгөх замаар уг асуудлыг шийдвэрлэж байжээ. Тээвэрлэлтийн татаасыг байхгүй болгох нь эдийн засгийн шилжилтийн зайлшгүй нэг шинж чанар мөн хэдий ч үүнийг шат дараалалтайгаар авч хэрэгжүүлж хөдөөгийн ард иргэдэд дасан зохицох бололцоо олгож болох байсан хэмээн маргаж болох юм. Тээвэрлэлтэд татаас олгож байсан нь улс даяар нөөц баялгийг тэгш хуваарилж, хэрэглээний дарамтыг хөнгөвчлөх боломжийг олгож байжээ. Татаасгүй болгосон нь хэрэглээний дарамтын урсгалыг хот суурин газарт төвлөрүүлэн шилжүүлэх шалтгаан болсон ба хүн ам төвлөрсөн газрын ойролцоох хээрийн бэлчээр, ойн нөөц баялгийг зохистой хэмжээнээс нь хэтрүүлэн хэрэглэхэд хүргэсэн байна. Нөөц баялгийг боломжийн өртгөөр ашиглах нь ядуурлыг арилгах алс хэтийн стратегийн төлөвлөлт, орон нутагт түшиглэсэн арилжааны үйл ажиллагааны оршин тогтнох чадвар, нөөц баялгийн тогтвортой менежментийн хөтөлбөрийн томоохон бүрэлдэхүүн хэсэг болох хүчин зүйл юм.

14. Дээр дурдсан бүх бэршээл нь тус улсын эмзэг, онгон байгаль орчин, ойн доройтолд үзүүлэх дарамтыг улам бүр нэмэгдүүлж байна. Нэг талаар ядуу, эмзэг айл өрх нь амьжиргаагаа залгуулахын тулд өөрсдийн хийж чадах ямарч хамаагүй аргаар байгалын нөөц баялгийг ашиглан зөвхөн өнөөгийн хэрэгцээгээ хангахыг голлон анхаарч байна. Нөгөө талаар төр, засгийн байгууллагуудаас үзүүлж буй үйлчилгээ нь үр бүтээмж багатай, санхүүжилт дутагдаж буйгаас байгалийн нөөц

баялагтай холбоотой үйл ажиллагааг зохицуулах төр, засгийн газрын чадавхи сул байна.

## **II. ОЙН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ОЙ АШИГЛАЛТЫН ТҮҮХЭН УЛАМЖЛАЛ**

### **2.1 Монгол улсын ой: Ойн төрөл, тархалт болон төлөв байдал**

15. Монгол улсын ой бүхий нутаг дэвсгэрийг хоёр ерөнхий хэлбэрт хувааж болно: ойт хээрийн шилмүүст ой, уулархаг нутгийн тайгын ой (эдгээр нь Сибирийн тайга болон Төв Азийн тал хээр нутгийн дунд шилжилтийн экологийн бүс бий болгодог), хоёр дахь хэлбэр нь нутгийн өмнөд хэсэг буюу говь цөлийн бүсэд орших заган ой болно.

16. Нутгийн хойд хэсэгт орших тайгын ой буюу ойт хээрийн бүсийн шилмүүст ойд Сибирийн шинэс, Эгэл Сибирийн нарс, гол төлөв хус, улиас, улиангар зэргээс бүрдсэн мод голлодог байна. Навчит модны энэхүү төрөл нь Орхон голын хөндийгөөс зүүн тийш элбэг тааралдах ба харин баруун тийш нутаг дэвсгэр нь далайн төвшнөөс өндөр өргөгдсөн байдаг тул бараг тааралддаггүй байна. Уулархаг бүс нутгийн ой нь тайгын буюу ойт хээрийн ой болох шинэс болон нарнаас аажимдаа дэд Альпийн бүсийн ой болох Сибирийн гацуур, хуш болон жодоо болж хувирдаг байна. Нутгийн хойт хэсгийн ойн 80 хувь нь 7 аймаг тухайлбал, Хөвсгөл (29 хувь), Сэлэнгэ (16 хувь), Булган (14 хувь), Хэнтий (11 хувь), Төв (10 хувь), Архангай (8,5хувь) болон Завхан (5 хувь) зэрэг аймгуудад байна. (Үндэсний статистикийн газар болон Байгаль орчны яамны 2000 онд гаргасан мэдээлэл).

17. Хуурай уур амьсгалтай өмнө болон баруун өмнөд зүгийн нутагт чийг түр зуур тогтдог хонхор газар болон голын сав газарт заг болон хоёрдогч төрөл болох сухай, жигд, тоорой, заг зэрэг ургамалаас бүрдсэн дутуу ургац бүхий ой нэлээд хэсэг газар нутагт тархсан байна. Заган ойн ихэнх хэсэг нь 5 аймагт тухайлбал, Өмнөговь (46 хувь), Говь-Алтай (27 хувь), Ховд (12 хувь) болон Баянхонгор (8 хувь), Дорноговь (6 хувь) тус тус байдаг байна. (Үндэсний статистийн газар болон Байгаль орчны яамны 2000 оны мэдээлэл).

18. Сүйтгэгдсэн ой болон ойн нөөцийн хомсдолын талаарх статистик мэдээлэл нь хоорондоо зөрчилтэй будлиантай боловч Дэлхийн банкны 2002 оны тооцоогоор Монгол улс нь 1950-1980 оны хооронд 1,6 сая га ой болон 1990-2000 оны хооронд 660 мянган га ой сүйтгэгдсэн байна. Ой устгасан гол шалтгаанд ойг тогтворгүй хэлбэрээр модон материал болон гал түлэхэд зориулж зөвшөөрөлтэй болон хууль бусаар ашигласан, ойн түймэр, уул уурхайн үйл ажиллагаа, хөнөөлт шавьж болон модны халдварт өвчний тархалт, хараа хяналтгүй мал бэлчээх болон цаг уурын хэлбэлзэлээс болсон гэж үздэг байна. Дээрх тоо баримтаас үзвэл өнгөрсөн зууны дунд үед Монгол улсад нийт ой бүхий газрын хэмжээ 18,226 сая га байжээ. Үүний дараагийн 50 жилийн дотор энэ нь 12,431 сая га ашиглагдаагүй ой (ихэнх нь хүрч очиход төвөгтэй уул толгод бүхий газар) мөн 3,604 сая га талбай бүхий мод бэлтгэсэн ой болтол буурсан байна. (Мод бэлтгэсэн газар нь гол төлөв томоохон тээврийн зам маршрутын дагуу байгаа ажээ).

19. Ойн тухай хуульд тодорхойлсон "ой бүхий газар" нь 17,852 сая га байгаа ажээ. (Бусад улсад "ой бүхий үл хөдлөх хөрөнгө" гэдэгтэй энэ нь үндсэндээ ижил юм). Энэхүү газар нутгийг ойн болон ойгүй бүсээр нь ялгаж үзүүлсэн 1997 оны мэдээг хүснэгт 2-г харуулсан байна. "Ой бүхий газар" гэдэг нь үндсэндээ газар нутгийг зохион байгуулалтын хувьд хуваарилсан хэрэг юм. Ийм газар нутгийн хил хязгаарыг аль болох их хэмжээгээр ойг хамааруулж тогтоох нь зүйн хэрэг боловч үүнийг бас удирдлага зохион байгуулалтын хувьд хялбар байх үүднээс бодож тогтоодог. Ялангуяа Монгол улс шиг шилжилтийн зурвас бүс ихтэй цогцолбор газар нутгийн хувьд ой бүхий газар нь ойгүй зарим газрыг тухайлбал бэлчээр, бут сөөг бүхий газар, намаг, хөдөө аж ахуйн тариалангийн болон суурин газруудыг багтаадаг байна.

## Хүснэгт 2. Монгол улсын ой сан бүхий газар

Ойн төрөл	Гар хүрээгүй ой (га-гаар) (30%-аас дээш хувийн "титэм нь хаалттай")	Нөөц нь шавхагдсан ой (га-гаар) (30%-аас доош хувийн "титэм нь хаалттай")	Ойн бус талбай	Нийт
Шилмүүст ой	10,402,599	1,121,025	1,816,430	13,340,054
Заган ой	2,028,823	2,483,364	0	4,512,187
Нийт	12,431,422	3,604,389	1,816,430	17,852,241

Эх үүсвэр: Ойн менежментийн төслийн төв (1997)-ийн мэдээг Теусан ашигласнаас авав (2000).

20. Хүснэгт 3-аас үзэхэд хүний гар хүрээгүй буюу "хаалттай" ойн бүсэд байгаа талбайн хэмжээгээр болон нийт тоогоороо хамгийн ихэд тооцогдох мод нь шинэ юм.

## Хүснэгт 3. Гар хүрээгүй ой дахь модны төрлийг талбай болон хэмжээгээр харуулбал:

Модны төрөл	Талбай (га-гаар)	Талбай (%)	Хэмжээ (м <sup>3</sup> )	Хэмжээ (%)
<i>Larix sibirica</i>	7,526,899	61	1,017,149,100	75
<i>Pinus sylvestris</i>	662,113	5	90,463,600	5.7
<i>Pinus sibirica</i>	984,658	8	163,498,400	12
<i>Picea obovata</i>	27,872	<1	3,633,200	<1
<i>Abies sibirica</i>	2,337	<1	375,500	<1
Навчит модны төрлүүд ( <i>Betula</i> , <i>Populus</i> and <i>Salix</i> )	1,198,720	10	86,254,400	6
<i>Haloxylon ammodendron</i>	2,028,823	16	1,400,100	<1
TOTAL	12,431,422	100	1,362,774,300	100

Эх үүсвэр: Ойн менежментийн төслийн төв (1997)-ийн мэдээг Теусан ашигласнаас авав (2000).

21. Үндэсний статистикийн газар болон Байгаль орчны яамнаас гаргасан мэдээлэлтэй харьцуулахад энд дурьдсан тоо баримт нь хэдийгээр их биш боловч бага зэрэг зөрүүтэй байгаа. Доор 3.2 дахь хэсэгт дурьдсан ойн бүсийн тоо баримттай уялдуулах зорилгоор энд хуучин тоо баримтыг хэрэглэсэн болно.

22. Ой модны насны бүтэц мөн тодорхой бус байна. Жишээлбэл, нийт модны 72 хувийг нас гүйцсэн буюу хөгшөрсөн, 11 хувийг нас гүйцэж байгаа, 15 хувийг дундаж насны ба үлдсэн 2 хувийг зулзган /залуу/ ой гэж хуваасан байна. (Энхбат ба Цогбаатар 1997 он).

### 2.2 Ойн нөөц ашиглалт

23. Монголын ой мод нь аж ахуйн болон өрхийн амьжиргаанд ашиг тустай хэд хэдэн чиглэлээр ашиглагддаг бөгөөд үүнийг дараах 2 ерөнхий ангилалд хувааж болох юм Үүнд:

- Модны аж ахуйн зориулалтаар хэрэглэх бөгөөд энэ нь гол төлөв түлээний болон хэрэглээний зориулалтаар гуалин бэлтгэх ажиллагааг хамрана.
- Ургамал болон амьтны гаралтай ойн бусад дагалт баялагийг өрхийн хэмжээнд хэрэглэх, өрхийн орлогыг нэмэгдүүлэх зорилгоор цуглуулах.

Орон нутгийн иргэд ойн нэлээд олон төрлийн экологийн бүтээгдэхүүнийг хэрэглэж амьдардаг байна.

24. Монгол улсын төр, засгийн газар 1995 онд батлагдсан Ойн тухай хууль Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиудаар хөдөөгийн хүн амын хувьд ойн дагалт баялаг болон бусад үр ашгийг хүртэхийг хүлээн зөвшөөрсөн байдаг. Жишээлбэл, заг нь зөвхөн хээрийн болон цөлөрхөг бүсэд оршин суух иргэдийн хувьд чухал түлш болоод зогсохгүй өвлийн улирал болон гантай үед малд маш чухал ач холбогдолтой тэжээл болдог ажээ. Ургамалын гаралтай баялаг нь орон нутгийнхны өөрсдийн хэрэгцээ болон өрхийн орлогыг нэмэгдүүлэхэд чухал үүрэгтэй байдаг ба үүнд малын тэжээл, самар, мөөг, эмийн болон үнэртний чанартай ургамлууд, түүнчлэн хүнсэнд хэрэглэдэг жимс, сонгино болон бусад ногоонууд ордог байна. Амьтны гаралтай ойн дагалт бүтээгдэхүүнд булга, чоно, үнэг, шилүүсний арьс, эмнэлгийн зориулалтаар хэрэглэх бугын эвэр, түүнчлэн тарваганы тос болон бусад ан агнуурын мах ордог байна. Дээрх төрлийн шууд бэлэн бүтээгдэхүүнээс гадна ойгоос экологийн чиглэлийн төрөл бүрийн үйлчилгээг нь авч ашиглаж болдог. Тухайлбал хөрс хадгалах, усны эх үүсвэрийг хамгаалах, мал сүргээ салхи, шуурганаас хамгаалах, түүнчлэн зэрлэг амьтадыг үржүүлэх нөөц газар болохоос гадна онгон хээр байгальд аялал зохион явуулах чиглэлээр ашиглаж болдог байна.

25. Ойн нөөцийг ашиглах чиглэлийн үйл ажиллагааг тухайн ойн бүс болон явуулах үйл ажиллагааны зорилт чиглэлээс хамаарч зөвшөөрч эсвэл үл зөвшөөрч болохуйц байдлаар үздэг "нөхцөлтэй" үйл ажиллагаа гэж үздэг байна. Ийм нөхцөлтэй үйл ажиллагаанд өвс хадах, мод бэлтгэх, түлшний модыг (аж ахуйн болон өрхийн зориулалттай) бэлдэх, ойн бусад дагалт баялгийг ашиглах явдал ордог байна. Эдгээр үйл ажиллагааг явуулахын тулд эхлээд зөвшөөрөл авах ёстой бөгөөд тухайн үйл ажиллагаанд тохирсон нөхцлийн дагуу зохих хураамж төлдөг байна.

26. Аж ахуйн зориулалтаар болон өрхийн хэлбэрээр ашиглаж буй модны нөөцийг гол төлөв гуалин хийх болон түлшний мод бэлтгэхэд чиглүүлж байгаа гэх боловч энэ талаарх тоо баримт нь зөвхөн албан ёсны зөвшөөрөл өгсөн хүрээнд байгаа тул найдвартай гэж үзэх үндэслэлгүй юм. Ургамлын чанартай болон амьтны гаралтай дайвар бүтээгдэхүүний талаарх тоо мэдээлэл тэр болгон олдох боломжгүй ажээ.

27. Байгаль орчны яамны мэдээ баримтаас үзэхэд 1990 оноос мод бэлтгэл эрс буурсан байна. 1980-аад оны үед жилд 1,8 сая куб метр мод бэлтгэдэг байсан бол энэ нь 2002 онд 620 мянган куб метр болж буурчээ. 2002 онд төлөвлөснөөр 40 мянган куб метр гуалин, 580 мянган куб метр түлээний мод бэлтгэх ёстой юм байна. 1995 оныг хүртэл үйлдвэрлэлийн хэрэглээний мод бэлтгэх болон түлээний мод бэлтгэх хэмжээ үндсэндээ ижилхэн байж иржээ. Харин 1995 оноос хойш үйлдвэрлэлийн хэрэглээний мод бэлтгэх явдал нийт мод бэлтгэлийн хэмжээнд нэлээд буурч ирсэн байна. Энэ нь зөвхөн албан ёсны болон хууль ёсоор зөвшөөрөл өгсөн мод бэлтгэх хэмжээнд хамаарах юм. Хэдийгээр өгч буй үнэлгээ нь өөр боловч ямар ч гэсэн нийт мод бэлтгэлийн хэмжээнд зөвшөөрөлтэй мод бэлтгэх явдал зөвхөн багаахан хэсгийг эзэлж байгаа ажээ.<sup>1</sup>

<sup>1</sup> Хавсралт 1-д хууль ёсоор болон хууль бусаар мод бэлтгэх явдлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг оруулсан болно.

28. Дотоодын зүсмэл материалын хэрэглээ жилд 340 мянгаас 1 сая куб метр гэж үздэг. Харин дотоодын түлээний хэрэглээ 625000-2.3 сая куб метр хүртэлх хэмжээнд байгаа гэж дүгнэдэг ажээ /Хүснэгт 7, хуудас 49/. Мод бэлтгэснээс гарч буй бүтээгдэхүүнийг экспортлосон буюу эсвэл модны хэрэглээний нэлээд хэсгийг импортоор хангаж байгаа талаар ямар нэг мэдээлэл байхгүй байна. Эндээс үзвэл жилд мод бэлтгэх хэмжээ 965 мянгаас 3 сая куб метрийн хооронд хэлбэлзэж байгаа ажээ.<sup>2</sup>

Эндээс үзэхэд хууль бусаар мод бэлтгэх хэмжээ үндсэндээ 345 мянгаас 2,38 сая куб метр байгаа гэсэн тооцоо байдаг байна.

29. Тус улсын томоохон хот суурин газрын дотоодын эрэлт хэрэгцээг хангахын тулд орон нутгийнхан үндсэндээ мод бэлтгэх ажлын эх үүсвэр болж байгаа ажээ. Жилд зөвшөөрөгдсөн мод бэлтгэх хэмжээг бууруулснаар хөдөө орон нутгийнхан хууль бусаар олж байсан орлогынхоо чухал эх үүсвэрийг алдсан байна. Аж ахуйн шинэ үйл ажиллагааны эх үүсвэрийг хэрэгжүүлэх явдал удааширч, төр захиргааны байгууллагаас санхүүгийн хувьд туслалцаа үзүүлэх явдал ч хамгийн доор түвшинд байж иржээ. Өөр амьжиргааны эх үүсвэргүй болоод ирэхийн хамт хүмүүс урьд нь ой модны салбарт ажиллаж байсан туршлага, ур чадвараа ашиглан цаашид амьжиргаагаа залгуулахаар шийдсэн байна. Хуучин модны чиглэлийн үйлдвэр, компанийн менежер болон ажилчин байсан хүмүүс өнөөдөр хууль бусаар мод бэлтгэх ажилд гол хувь нэмрээ оруулж буй хүмүүс ажээ. Тэд мөн өөрсдийн гэр бүлийн гишүүд болон тухайн нутагт оршин сууж буй хүмүүсийг мод бэлтгэх, боловсруулах ажилд хамруулдаг байна. Зарим нутагт орон нутгийнхан хууль бусаар үйл ажиллагаа явуулах явдалд өргөн оролцдог ажээ. Модыг хууль бусаар огтолж ашигласнаас орж буй орлогыг хэрхэн хуваадаг талаар мэдээлэл байхгүй боловч тухайн орон нутагт орлогыг тэгш бус хувааж, ихэнх хэсгийг цөөн хэдэн хүн авдаг бололтой. Модыг тээвэрлэх, худалдах, борлуулах үйл ажиллагааг хот суурин газарт оршин суудаг хүмүүс зохион байгуулж хяналтандаа байлгадаг байна. Энэхүү бүх тогтолцоо нь янз бүрийн түвшинд ажилладаг засгийн газрын байгууллагын хүмүүстэй "харилцан тохиролцсоны" үндсэн дээр хэрэгждэг гэж хүмүүс ойлгодог.

30. Модны хууль бус бизнес нь хэд хэдэн чиглэлээр сөрөг нөлөө үзүүлж байна. Нэгдүгээрт, хот суурин газрын зах зээл дээр чанар муутай модон бүтээгдэхүүн хэт их хэмжээгээр орж ирж, улмаар зах зээлийн үнээс доогуур үнээр борлуулагдаж байна. Ийнхүү бага үнэтэй байгаа явдал нь дотоодын модны бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээг хэт өндөр болгож, улмаар хүмүүс модон бүтээгдэхүүнийг илүү үр ашигтайгаар хэрэглэх, гадаадаас импортлож оруулж ирсэн модон бүтээгдэхүүнийг ашиглах болон модоор хийгээгүй бусад бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээг нэмэгдүүлэхэд сөрөг нөлөө үзүүлж байна. Ингэснээрээ эргээд Монгол улсын ойн нөөцөд цаашид тогтвортой байлгахад нь сөрөг нөлөөлсөн дарамт шахалт учруулж байна. Хоёрдугаарт, энэ нь төр захиргааны байгууллагуудын хувьд олж болох ашиг орлогыг үлэмж хэмжээгээр бууруулж байна. Дээрх жишээнээс үзвэл зөвхөн гуалин хууль бусаар борлуулах үйл ажиллагаанаас Монгол улсын засгийн газарт 540 мянгаас 1 сая ам.долларын хураамжийн хохирол учирч байгаа бололтой. Үүний дээрээс түлшний мод бэлтгэхээс хураах хураамж, мод бэлтгэх боловсруулах зэрэг аж ахуйн үйл ажиллагаанаас хурааж болох НӨТ болон аж ахуйн нэгжийн албан татвар зэргийг оролцуулан тооцвол нийт алдагдал нь жилд хэдэн сая ам.долларт хүрч болох юм.

<sup>2</sup> Мод бэлтгэх, мод ашиглах үйл явдал хангалтгүй, төр захиргааны байгууллагад хууль хэрэгжүүлэх явдал үр дүнгүй байгаа учраас унагасан боловч ашиглахгүй орхисон модыг оруулдаггүй учраас дээрх тоо нь жинхэнэ нөхцөл байдалд хүрэхгүй байгаа гэж Монголын ойн аж ахуйн холбоо үзэж байгаа ажээ.

### **III. ОЙН МЕНЕЖМЕНТИЙН БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЭРХ ЗҮЙН БОЛОН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТ**

#### **3.1 Ой модны салбар дахь Монгол улсын засгийн газрын байгууллагууд**

31. Ой модны салбараас тус улсын эдийн засагт оруулах хувь нэмэр багасахын хэрээр сүүлийн 30 жилийн дотор ойн нөөц баялгийг захиран зарцуулах төрийн захиргааны үйл ажиллагаа нэлээд хэдэн удаа өөрчлөгдөж ирэв. (Хельми 2001 он) 1974 оноос өмнө Хөдөө аж ахуйн яамны дэргэд ойн асуудлыг хариуцсан бүхэл бүтэн газар байжээ. 1970 оны эхээс эхлээд 1980 оны дунд үе хүртэл ойн ашиглалт нэлээд эрчимтэй нэмэгдсэн ба 1970-аад оны сүүлээс 1988 он хүртэл жилд 1,8-2,8 сая куб метр хүртэл мод бэлтгэсэн нь хамгийн их хэмжээндээ хүрчээ. Ийнхүү ойн нөөц баялгийг бүрэн хэмжээгээр ашиглаж байх үед тус салбар нь 20000 хүнийг ажиллуулж нийт үйлдвэрийн бүтээгдэхүүний 18 хувь буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 6 хувийг үйлдвэрлэж байв. Ийнхүү ашиг, төрөл нь өндөржсөн учраас 1974 онд Ой модны аж үйлдвэрийн яамыг тусад нь байгуулж байжээ.

32. 1987 онд ойн нөөц баялгийг үлэмж хэмжээгээр ашиглаж байгаатай холбогдон гарсан санал шүүмжлэлийн үр дүнд үндэсний хэмжээнд байгалийн нөөц баялгийг ашиглах болон байгаль орчны бодлого боловсруулах явдлыг уялдуулан зохицуулах үүднээс нэг яам байгуулах шийдвэр гарсан байна. Ийнхүү тус онд Ой модны аж үйлдвэрийн яамыг Ус цаг уурын газартай нийлүүлж Байгаль орчныг хамгаалах яамыг байгуулжээ. Ойн асуудлыг ой, агнуурын удирдах газарт хариуцуулсан байна. 1990 онд тус яамыг Байгаль орчныг хянах улсын хороонд бусад байгууллага, агентлагуудтай нэгтгэсэн бөгөөд харин ой модны аж үйлдвэрийн асуудлыг Худалдаа, аж үйлдвэрийн яаманд шилжүүлсэн байна.

33. 1992 онд Байгаль орчныг хянах улсын хороог дахин Байгаль орчны яам болгож өөрчлөн зохион байгуулжээ. Энэхүү шинээр байгуулагдсан яам нь байгалийн нөөцийн менежмент, газар зохион байгуулалт, байгаль орчны хяналт, нөөц баялгийн мониторинг болон тусгай хамгаалалттай газрын менежментийг хариуцсан 5 газар, түүнчлэн олон улсын хамтын ажиллагаа, хөтөлбөр программын үнэлгээ, бодлого хэрэгжүүлэх, зохицуулах болон захиргаа санхүү эрхэлсэн 4 захиргаа, бодлогын чиглэлийн байгууллагуудаас бүрддэг болсон байна. Түүнчлэн ой хайгуул судалгааны төслийн төв зэрэг хэд хэдэн хүрээлэн, судалгааны академи, төвүүд байгуулагдсан ба тэдгээр нь яамтай ямар нэгэн хэлбэрээр уялдаатай ажиллах болжээ.

34. 2000 онд Байгаль орчны яамыг удирдлагын хувьд зохион байгуулж, сайдын үйл ажиллагааг дэмжих үүрэг бүхий дэд сайдын орон тоог буй болгосон байна. Мөн төрийн нарийн бичгийн даргын албан тушаалыг буй болгожээ. Төрийн нарийн бичгийн даргад 4 газар болон 1 хэлтэс үйл ажиллагаагаа тайлагнаж харьяалагдах болсон байна. Үүнд:

- Стратеги төлөвлөлт, удирдлагын газар,
- Төрийн захиргаа, санхүүгийн газар,
- Мэдээлэл, хяналт шинжилгээний газар,
- Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (үүнд тусгай хамгаалалттай газрын менежмент орох болсон байна) болон
- Хамтын ажиллагааны хэлтэс

1 газар болон 4 агентлаг шууд сайд болон дэд сайдад харъяалагдах болсон байна. Үүнд:

- Байгалийн нөөцийн газар,
- Байгаль орчныг хамгаалах алба,
- Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний газар,
- Газрын хэрэг эрхлэх газар

35. Байгаль орчны нөөцийн менежментийг хэрэгжүүлэх ажлыг Байгаль орчны ямаас тавьсан техникийн хязгаарлалтын хүрээнд орон нутгийн түүний дотор аймаг, сумын засаг дарга нар хэрэгжүүлэх болсон байна. Үүнд мөн тусгай зөвшөөрөл олгох асуудал хамрагддаг. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явдал аймгийн түвшинд байгаль орчны байцаагч нар, сумын түвшинд байгаль хамгаалагч нарын үүрэг хариуцлагад багтаж байсан бөгөөд саяхан болтол тэд тухайн аймгийнхаа засаг даргын тамгын газарт харъяалагдаж байжээ. Энэхүү судалгаатай холбогдон дээрх хүмүүсийн эрх үүргийн талаар авсан мэдээлэл зарим талаар зөрүүтэй байсан боловч байгаль хамгаалагчдыг бодвол байгаль орчны байцаагч нар нь нэгжлэг хийх, хураах зэрэг томоохон эрх эдэлдэг бололтой байна.

36. Тус салбарын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх энэхүү судалгааны үеэр Байгаль Орчны Яам мөн дахин зохион байгуулалтын өөрчлөлтөнд хамрагдаж байв. Хэдийгээр энэ өөрчлөн зохион байгуулах үйл ажиллагаа дуусаагүй байгаа боловч дараах чиглэлээр тодорхой шийдвэр гарсан бололтой байна. Үүнд:

- Байгаль орчны яамны бүх газрууд болон агентлагууд шууд сайдад харъяалагдана;
- Газар зохион байгуулалтын алба нь тус яамны харъяалалаас гарна;
- Байгаль хамгаалах алба нь Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэргэд байгуулагдах Мэргэжлийн хяналтын улсын албатай нэгдэнэ;
- Байгалийн нөөцийн газар нь шинээр Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болж улмаар Байгаль, ой, усны нөөцийн агентлаг гэсэн шинэ нэртэй болно;
- Ой модны боловсруулах аж үйлдвэрийн салбарыг хариуцах үүргийг Худалдаа үйлдвэрийн яамнаас Байгаль, ой болон усны нөөцийн агентлагт шилжүүлсэн;
- Ус цаг уур, хүрээлэн буй орчны хяналтын агентлаг нь өргөжиж Ус цаг уур, орчны шинжилгээний газар болсон;
- Аймгийн түвшинд ажиллах байгаль орчны байцаагч нар нь Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэргэд байгуулагдсан Улсын мэргэжлийн хяналтын албанд шууд харъяалагдах бөгөөд байгаль хамгаалагч нар нь сумын захиргаанд үйл ажиллагаагаа тайлагнасан хэвээр байна.

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага нь Үндэсний ойн хөтөлбөрт туслах төслөөр дамжуулан Байгаль, ой болон усны нөөцийн агентлагт байгууллагын хувьд өөрчлөгдөн зохион байгуулагдахад нь техникийн туслалцаа үзүүлж байгаа ажээ. Ингэснээр тус хөтөлбөрийн зорилго, чиглэлийг тодорхойлох мөн улсын болон аймаг, сумын хэмжээнд байгууллагуудын хүлээх үүрэг ролийг тодорхойлоход туслалцаа үзүүлэх явдал орж байгаа юм байна. Ойн менежментийн

төслийн төв болон Монгол улсын Шинжлэх ухааны академийн дэргэдэх олон төрлийн судалгааны байгууллага, хүрээлэнгийн цаашдын хувь заяа одоогоор тодорхойгүй боловч яваандаа Байгаль орчны яамтай урьд урьдахаас илүү их уялдаатай ажиллах бололтой ажээ.

37. 1990 он хүртэл ой модны салбарын мэргэжилтнүүдийг Орос, Польш, Болгар болон Румын улсад бэлтгэдэг байв. Монгол улс 1985 оноос эхлэн дотоодын ойн мэргэжилтнүүдийг бэлтгэж эхэлсэн ба Монгол улсын их сургуулийн дэргэд 4-5 жилийн хугацаатай диплом, 6 жилийн хугацаатай мастерийн курсуудыг буй болгосон ба Монгол улсын Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн дэргэд ой модны аж үйлдвэрийн чиглэлээр сургах болсон байна. Дархан хот дахь коллежи нь цөөн тооны оюутнуудад байгаль хамгаалалын мэргэжлээр диплом олгох сургалт явуулдаг байна. Монгол улсын их сургууль нь жилд 20-30 ойн инженерийн мэргэжилтнүүдийг бэлтгэдэг боловч ажлын байр хязгаарлагдмал учраас тэдний зөвхөн 3-ны 1 нь ой болон байгалийн нөөц баялгийг хамгаалах салбарт ажилд ордог байна. Түүнээс гадна 4 техник мэргэжлийн болон 5 техникийн сургуульд 3 жилийн хугацаатай дипломын сургалтыг явуулдаг байжээ. 1985 оноос эхлэн эдгээр сургуулиуд нь жилд 20 шахам оюутнуудыг төгсгөж гаргадаг байсан боловч 1994 онд хаагдсан байна. Иймээс байгаль орчны байцаагч нар болон байгаль хамгаалагч зэрэг хүмүүст мэргэжлээ дээшлүүлэхэд нь тус болох, эсвэл анхан шатны сургуульд шинээр хамрагдах бололцоо олгохуйц ямарваа нэгэн сургалт байхгүй байгаа бөгөөд байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагч нар нь аймаг, сумын төвшинд хууль тогтоомж хэрэгжүүлэх үүрэгтэй байгаа билээ.

### **3.2 Ойн бодлого, зохицуулалтын арга хэрэгслэлүүд**

38. 1994 оноос эхлэн Монгол улсын Засгийн газар нь тус улсыг зах зээлийн эдийн засагт шилжүүлэх шилжилтийн үйл ажиллагааг удирдан зохицуулах зорилгоор зохих бодлого, хууль тогтоомж боловсруулахын тулд нэлээд их хүч чармайлт гаргаж ирлээ. Энэхүү хэсгийг 2 дэд сэдэвт хувааж бичсэн болно. Үүнд эхний хэсэг нь ойтой холбоотой хууль тогтоомж, бодлогыг хянаж үзсэн бөгөөд хоёрдугаар хэсэгт Монгол улсын хойд хэсгийн бүс нутагт чухал ач холбогдолтой байж болох ойтой холбоотой үйл ажиллагаа явуулах талаар дурьдсан ядуурлыг бууруулах, хөдөөг хөгжүүлэх стратегийн талаар бичсэн болно. Эдгээр бодлого болон хууль тогтоомжийн тоймыг хавсралт 2-оос харна уу.

#### *Ойн бодлого*

39. Монгол улсын ойн нөөц баялгийг хамгаалах, хадгалах, ашиглах асуудлыг зохицуулж байдаг бодлогын хэрэгсэл нь нэг талаас олон улсын гэрээ, хэлэлцээр болон байгаль орчин хөгжлийн талаарх дотоодын бодлогоос бүрддэг байна. Ойн менежментэд чухал ач холбогдолтой хэд хэдэн олон улсын гэрээ, хэлэлцээрт Монгол улс нь гарын үсгээ зурж нэгджээ. Эдгээрээс хамгийн чухал нь Биологийн төрөл зүйлийг хамгаалах тухай, Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлүүдийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай болон Цөлжилттэй тэмцэх олон улсын конвенци болно. Биологийн төрөл зүйлийг хамгаалах тухай конвенцийн хүрээнд Монгол улс тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ байгуулах үүрэг хүлээсэн. Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлүүдийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн хүрээнд Монгол улсаас ховордсон ургамал болон амьтны төрөл зүйлийг худалдахтай холбоотой асуудлыг зохицуулах арга хэмжээг авах үүрэг хүлээсэн. Цөлжилттэй тэмцэх олон улсын конвенцийн хүрээнд орон нутгийн иргэд болон бусад талуудтай хамтран цөлжилттэй тэмцэх цогц арга хэмжээ авах үүрэгтэй ажиллаж байна.

40. Монгол улсын их хурал нь эдгээр олон улсын конвенцид түшиглэн тус улсын байгалийн нөөц баялгийг хамгаалах асуудлаар хэд хэдэн хөтөлбөр, бодлогын баримт бичгийг боловсруулсан байна. Ойн менежменттэй шууд

холбоотой баримт бичгүүдээс гадна нэлээд хэдэн баримт бичгүүд үүнтэй шууд бус байдлаар ч холбогдож байна. Үүний дотор байгалийн нөөц баялгийг хамгаалах талаар ерөнхий зарчмуудыг тодорхойлсон бодлогоос гадна тус улсад тусгай хамгаалалттай газрын тогтолцоо буй болгох талаар баримтлах бодлогын үзэл баримтлалыг дурьдсан бичиг баримтууд орж байна.

41. Ойн тухай үндэсний хөтөлбөрийг 1998 онд боловсруулжээ. Энэ бодлогын хүрээнд ойг ашиглах, ойн нөөц баялаг, түүнийг хамгаалах болон нийгмийн хамгаалалттай холбоотой асуудлууд орсон байна. Тус баримт бичгийн зарчмын ач холбогдолтой 7 зорилтын 3 нь ойг ашиглахтай холбоотой байх бөгөөд энэ нь тухайн үед Засгийн газрын баримталж байсан бодлогын нэг илэрхийлэл юм. Ойн тухай үндэсний хөтөлбөрийг 2001 онд дахин шинэчилж боловсруулсан. Энэ баримт бичгийн хүрээнд Засгийн газрын нэн тэргүүний тавих зорилт нь ашиглалтаасаа илүү хадгалалт хамгаалалт руу чиглэсэн байна. Ойн тухай үндэсний хөтөлбөрийн 5 зорилтын 2 нь нөөц баялгийн менежментийг сайжруулах, 2 нь хадгалалттай холбоотой бөгөөд зөвхөн 1 зорилго нь ашиглалтад чиглэгдсэн байна. Тус бодлогын нэн тэргүүний ач холбогдолтой зорилтуудад байгууллагын бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт, ойн түймэр болон хөнөөлт шавьжийн менежмент, ойжуулах ажиллагаа болон ой модны боловсруулах үйлдвэрийн чанар, үр ашгийг дээшлүүлэх явдал тус тус багтаж байна.

42. Харин ойн үндэсний хөтөлбөрт **төр захиргаанаас ойн талаар баримтлах нэн тэргүүний зорилт яагаад ийнхүү өөрчлөгдсөн тухай ямарваа нэгэн анализ, дүн шинжилгээ өгөгдөөгүй байна.** Жишээлбэл, ойн түймэр болон хөнөөлт шавьжийн тархалтын гол шалтгааны талаар ямарваа нэгэн тайлбар гаргахыг оролдоогүй байх бөгөөд энэ талаарх зорилтыг тэргүүн ээлжинд тавьсныг эдийн засгийн хувьд буюу экологийн хувьд дэмжих тодорхой хүчин зүйлүүдийг гаргаж өгөөгүй байна. **Ой модны салбарын цаашдын хандлагын учир шалтгааны талаар тайлбар хийх гэж оролдсон нь ерөнхийдөө хэтэрхий энгийн байр сууринаас ханджээ.** 1989 оноос хойш ойн аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн буурсан нь сонин сэтгэгдэл төрүүлж байна. Энэ бууралтыг хоцрогдсон бөгөөд хуучин машин техник технологи, эрчим хүч, тээврийн дэд бүтцийн чанар муудсантай холбож үзсэн байна. Сүүлийн 30 жилийн хугацаанд ойн модны нөөц багассан, мод бэлтгэлд зориулсан талбайг хууль тогтоомжоор хориглож багасгасан, түүнчлэн дахин ойжуулах тогтолцооны хүрээнд ойг бүрэн цэвэрлэж мод тарихыг хориглосон талаар огт дурьдаагүй байна. Тус хөтөлбөрт модыг хууль бусаар бэлтгэх талаар товчхон дурьдаад өнгөрснөөс биш энэ талаар арга хэмжээ авах стратегийг санал болгоогүй байна. Энэхүү асуудал нь наад зах нь 1990-ээд оны эцсээс анхаарал татаж эхэлсэн бөгөөд Байгаль хамгаалах албаны албан тушаалтнуудын үзэж байгаагаар өнөөдөр Монгол улсын ойд учруулж байгаа хамгийн том аюул заналхийлэл ажээ. Түүнчлэн ойн үндэсний хөтөлбөрт дурьдсан 62 үйл ажиллагааны дараалал буюу нэн тэргүүний ээлжинд аль нь байх талаар ямарваа нэг зүйлийг тодруулаагүй байна. Эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүгийн нөөц бололцооны талаар тооцоо хийгээгүй, харин санхүүгийн ямар эх үүсвэрүүд байж болох тухай дурьджээ.

*Ойн талаарх хууль тогтоомж*

43. Монгол улсын байгаль орчны талаарх хэд хэдэн хууль тогтоомж ойн менежментэд тодорхой нөлөө үзүүлэх юм. Эдгээрээс хамгийн чухал нь Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Газрын тухай хууль, Тусгай хамгаалалттай газар Нутгийн тухай хууль, ТХГН-ийн Орчны бүсийн тухай хууль болон ургамлын тухай хууль юм. Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар байгаль орчны байцаагч нар болон байгаль орчинтой холбоотой үйл ажиллагаанд хяналт тавих механизмыг бүрдүүлж өгчээ. Ойн санг эзэмших, ашиглах эрхийн тухай Монгол улсын Газрын хуулиар зааж өгсөн байна. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль болон Байгалийн ургамлын тухай хууль тогтоомжоор аж үйлдвэрийн

зорилгоор ойн бүсийг ашиглаж болохгүй тухай хориг тавих эсвэл Орчны бүсийн тухай хуулиар ойн менежменттэй холбоотой зарим арга ажиллагааг хориглосон байна.

44. 1995 онд батлагдаж улмаар 2000 он болон 2002 онд нэмэлт өөрчлөлт оруулсан Ойн тухай хууль нь Монгол улсын ойг хамгаалах, зохистой ашиглах нөхөн сэргээх тогтолцоог хуульчилж өгчээ. Байгаль орчныг хамгаалахтай холбоотой бусад хууль тогтоомжийн нэгэн адил энэ нь удирдлага, менежментийн суурь болсон 3 бүсийг бий болгосон байна . 3

- Онцгой бүс. Энэ бүсэд "тайгын бүсээс дооших бүс нутаг" орно гэж тодорхойлсон байх бөгөөд одоогийн байгаа 48 тусгай хамгаалалттай газар, дархан цаазат газар болон соёлын өвд хамаарагдах газар багтах бөгөөд нийтдээ 20530590 га буюу Монголын нийт газар нутгийн 13 хувийг эзлэхээр заажээ. Энэхүү онцгой хамгаалалттай газар нутагт 8,44 сая га ой буюу нийт ой бүхий газар нутгийн 47 хувь нь хамрагдаж байна. Ойн тухай хуульд зааснаар онцгой хамгаалалттай бүсийн хил хязгаар болон түүний доторх хамгаалалтын арга хэмжээг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар зохицуулна гэжээ. Онцгой бүс дэхь ойг түүний байгалийн унаган төрх, цаашид экологийн тэнцвэрт байдлыг хадгалах чиглэлээр удирдах ёстой гэсэн боловч, тайгын бүсийн байгалийн нөхөн сэргэлт, ойжуулалтад чухал ач холбогдол бүхий ойн түймэр болон хөнөөлт шавьжны эсрэг хамгаалах, тэмцэх арга хэмжээг заасан байна. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар тодорхой заасан газраас зөвхөн орон нутгийн түлшний хэрэгцээг хангах, тусгайлан заасан нэр төрлийн ойн дагалт баялаг жишээлбэл самар болон унасан бугын эвэр зэргийг түүхийг зөвшөөрсөнөөс бусад хэлбэрээр ашиглах явдлыг хоригложээ.
- Хамгаалалттай бүс. Уг бүсийг томоохон нуур болон голын эхээс 5 км-ийн орчим мөн төв голын хоёр талаар 3 км зай газар эсвэл томоохон замын буюу төмөр замаас хоёр талаар 1 км зай газар түүнчлэн томоохон хотоос 80 км-ийн радиустай, жижиг суурин газраас 30 км-ийн радиустай газар ногоон бүс байхаар тогтоосон байна. Түүнчлэн 30-аас дээш хэмийн налуутай газар болон 100 га-гаас доош хэмжээтэй ой, эсвэл хадлангийн газрын захаас 50 метр орших ой болон заган ойд мод бэлтгэхыг хориглосон байна. Хамгаалалттай бүсэд 8,22 сая га ой буюу нийт ой бүхий газрын 46 хувь хамрагдаж байгаа юм байна. Хамгаалалттай бүсийн ойг түүнийг хамгаалах, хэвийн хэмжээгээр ургуулах нөхөн үржихэд нь зориулж цэвэрлэж болох ажээ. Зохицуулалттайгаар өрхийн түлшний мод бэлдэх эсвэл тодорхой хэмжээний дайвар бүтээгдэхүүнийг цуглуулах нь зөвхөн зөвшөөрөгдсөн зүйлүүд ажээ.
- Ашиглалтын бүс. Онцгой бүс болон хамгаалалттай бүсэд ороогүй бусад бүх ойг үүнд оруулах ажээ. Ашиглалтын бүсэд байгаа ойд тодорхой зөвшөөрөл болон Засгийн газрын байгууллагуудад тодорхой хураамж төлсний үндсэн дээр ашиглаж, мод бэлдэж болох юм байна. Ашиглалтын бүсэд 1,19 сая га ой буюу нийт ой бүхий газрын 7 хувь багтдаг ажээ.

<sup>3</sup> Энэхүү илтгэлд зориулан дурьдсан ой бүхий газар нутгийн талаарх тоо баримтыг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс 2001 онд гаргасан бичиг баримтанд дурьдсанаас иш татсан болно. Үүнийг мөн Ойн менежментийн төслийн төвийн захирал батлан тэмдэглэсэн. Одоогийн ойн бүсчлэл нь үнэн хэрэгтээ Монгол улсын Засгийн газраас байгалийн нөөц баялгийг хамгаалахтай холбоотой тавьсан зорилттой уялдаж байгаа бололтой:

45. Ойн тухай хуулиар төрийн захиргааны төв байгууллага болон орон нутгийн захиргааны байгууллагууд, ой ашиглагчдад тус тусад нь ойн менежмент болон түүнтэй холбоотой санхүүжүүлэлтийн өөр өөр үүрэг хариуцлагыг ноогдуулсан байна. Мөн энэ хуулиар иргэд, бүлэг хүмүүс, аж ахуйн нэгж байгууллагууд ойн нөөц баялгийг хэрхэн ашиглах тухай үйл явц, нөхцлийг тодорхойлжээ.

46. Ойтой холбоотой өөр хоёр чухал хууль тогтоомж бол Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх тухай хууль болон Ойгоос хэрэглээний мод, түлээ ашигласны төлбөрийн тухай хууль. Эхний хуулиар галаас урьдчилан сэргийлэх, галтай тэмцэх, унтраах мөн галын дараа нөхөн сэргээх үйл ажиллагааг зохицуулна. Харин дараагийн хуулиар модыг аж ахуйн зориулалтаар буюу түлшний зориулалтаар ашиглахтай холбогдсон хураамжийг тогтоожээ.

47. Ой модны салбарт чухал ач холбогдолтой хэд хэдэн цогц хууль тогтоомж, бодлогыг Монгол улс боловсруулж гаргасан байна:

- Ойн маш бага хэсгийг (7 хувь орчим) өнөөдөр аж ахуйн зориулалтаар ашиглах бололцоотой байгаа бөгөөд үүнээс үүдэн ойн аж үйлдвэрийн салбар цаашид хөгжих, хөрөнгө оруулалт хийх бололцоо хязгаарлагдмал байна.
- Ойд мод бэлтгэх зөвшөөрөл авсан байгууллагууд нь мод бэлтгэл хийсэн газартаа ойжуулах үүрэгтэй бөгөөд Байгаль орчны яамнаас захиран зарцуулдаг сан буй болгож үүгээр урьд өмнө огтлолт хийгдсэн газарт ойжуулалт хийх эсвэл урьд өмнө ойтой гэж үздэг байсан газар шинээр ойжуулах ажлыг санхүүжүүлдэг байна.
- Модыг түүвэрлэж огтлох аргаар бэлтгэж, нөхөн сэргээхийг хуульд заасан байдаг. (Гэвч энэ аргыг хэрхэн ямар байдлаар хэрэглэх талаар тодорхой чиг зааврыг одоо болтол боловсруулаагүй байна)
- Мод ашиглах эрхийг өрсөлдөөнт тендерийн журмаар хуваарилдаггүй байна. Сонирхсон аж ахуйн нэгж байгууллагуудаас ирсэн жил бүрийн хүсэлт дээр тулгуурлан сумын засаг дарга нар үүнийг захиргааны журмаар шийддэг ажээ. Мод бэлтгэх хураамжийг хүртэл захиргааны журмаар шийдвэрлэж байна. Хураамжийг арилжааны зориулалтаар огтолж буй эсвэл түлээний модны экологийн болон эдийн засгийн үнэлгээний зохих хувь маягаар тооцдог ажээ. Хураамжийн тогтоосон хувь хэмжээ нь байнга өөрчлөгдөж байдаггүй бөгөөд зах зээлийн өөрчлөлт шинэчлэлтийг харгалзаж үздэггүй байна. Ийнхүү хураамжийн үнийг захиргааны журмаар тогтоож жил бүрийн зөвшөөрөгдсөн мод бэлтгэх хэмжээг өрсөлдөөнт бус зарчмаар тодорхойлж байгаагаас модон бүтээгдэхүүний бодит эрэлт, хэрэгцээг илэрхийлж чадахуйц зах зээлийн үнэ үйлчлэхэд саад тотгор учруулж байна. Мод ашиглах эрхийг илүү өрсөлдөөнтэйгөөр хуваарилах зарчимд шилжсэнээр модны ашиглалтын үр ашгийг дээшлүүлж, модныхоо нөөц бололцоог ашиглуулсныхаа төлөө улсад орох ашиг орлогыг шударгаар нэмэгдүүлж, цаашид модыг орлох бусад хувилбарыг санахыг хөхүүлэн дэмжих нь зүйтэй.
- Одоогийн хууль тогтоомжоор үйл ажиллагаагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, эсвэл хэсэг бүлэг хүмүүст тодорхой хэмжээний газар нутагт мод бөөнөөр ашиглах эрхийг удаан хугацаар олгож байна. Ингэснээр мод ашиглагчид үйл ажиллагаагаа урт хугацаагаар төлөвлөж цаашид ойд мөн төдий хэмжээгээр хөрөнгө оруулах бололцоо буй болгох ёстой ажээ. Гэвч ийнхүү гэрээгээр ажиллах явдал нь гэрээний хэрэгжилтэнд хяналт тавихын

тулд засгийн газрын байгууллагуудын хүн хүчний болон санхүүжилтын хувьд асар их ачаалал нөгөө талаас учруулж болохоор байна.

- Ойн менежментийн талаарх үүрэг хариуцлагын ихэнхийг нь орон нутгийн төр захиргааны байгууллагуудад даалгасан байна. Төрийн болон хувийн хэвшлийн албан тушаалтан хүмүүстэй уулзаж байхад орон нутагт энэ үүрэг хариуцлагыг хэрэгжүүлэх ур чадавхи хязгаарлагдмал ажээ. Энэ үйл ажиллагааг хэрэгжүүлэх санхүүжилт дутагдалтай, ажилтнуудын ур чадвар, сургалт хангалтгүй, уг ажлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэгсэл, журам боловсронгуй болоогүй байна.
- Ойн хууль тогтоомжийг зөрчсөний төлөө ногдуулах торгуулийн хэмжээ бага бөгөөд хууль тогтоомжийн хэрэгжилтэнд тавих хяналт шаардлагад нийцэхгүй учраас хууль тогтоомж зөрчигчид тэр болгон илэрдэггүй, тэдэнд хариуцлага хүлээлгэж, тооцдоггүй байна.

48. *Дүгнэлт.* Өнөөдөр Монгол улсын ойн талаар баримтлах бодлогын нэн тэргүүний ээлжинд тавих зорилтууд нь гол төлөв ойн түймэр, хөнөөлт шавьжийн тархалттай тэмцэх, урьд нь мод бэлтгэсэн буюу ойгүй байсан газар мод шинээр тарих, түүнчлэн мод боловсруулах үйл ажиллагааг илүү үр ашигтай болгоход чиглэж байна. Бүтэц зохион байгуулалтын шинэчлэлээс бусдаар өнөөдөр санал болгож буй стратеги нь голдуу техникийн шинж чанартай, дээрээс доошоо хандсан хандлагатай байна. Ой модны салбарын үндсэн бэрхшээлийн талаар шүүмжлэлтэй хандаж, дүн шинжилгээ хийсэн зүйл алга байна. Ойн менежментийг зохицуулах талаар гаргасан хууль тогтоомж нь өргөн хүрээг хамарч чадсан байна. Гэвч ашиглаж болох ойн талбайг энэ нь маш бага хэмжээнд хүртэл хязгаарлаж нөгөөтэйгүүр мод бэлтгэх олон төрлийн тогтолцоо ашиглах явдалд саад учруулж байна. Мөн энэ хууль тогтоомжийн дагуу хууль тогтоомжийг хэрэгжүүлэх нөөц бололцоо туршлага байхгүй орон нутгийн захиргаанд ихээхэн хэмжээний хариуцлага ногдуулжээ.

**Хөдөөгийн хөгжил ба ойгоос хамааралтай орон нутгийнхны дунд ядуурлыг бууруулахад чиглэсэн стратеги бодлого.**

49. Монгол улсын Засгийн газар өнөөдөр Ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг дахин хянаж үзэх шатандаа явж байна. Үүнийг мөн тусад нь бөгөөд бие даасан байдлаар хөдөөгийн сонирхогч талуудын оролцоотойгоор боловсруулсан Хөдөөгийн хөгжлийн стратеги хэмээх баримт бичгээр бас дэмжиж өгчээ. Ядуурлыг бууруулах стратеги нь үндсэндээ улсын хэмжээнд ядуурлыг бууруулах асуудалд анхаарлаа хандуулсан байхад хөдөөг хөгжүүлэх стратеги нь түүний хөдөө орон нутгийн салбарын асуудлыг хөндсөн байна. Дээрх бичиг баримтууд тус тусын зорилт болон түүнд хүрэх стратегтай байхаас гадна ой модны салбартай нягт холбоотой болно.

50. *Ядуурлыг бууруулах стратегийн баримт бичиг (ЯБСББ).* 2003 оны 2-р сард ЯБС хараахан боловсруулагдаагүй байсан. Хөтөлбөрийн гол зорилго нь Монгол улсад ядуурлыг тохиолдол бүрийг бууруулах юм. Энэхүү зорилтод хүрэхэд хамгийн гол ач холбогдолтой зүйл нь хувийн хэвшлээр удирдлуулсан эдийн засгийн өсөлт байх ажээ. Үүний дагуу макро эдийн засгийн тогтвортой байдал, зах зээлд хүрэх гарцыг сайжруулах, улмаар бизнесийн хөрөнгө оруулалт хийхэд таатай орчинг бүрдүүлэхэд гол анхаарлаа хандуулахаар заасан байна. Ерөнхий стратегийн хүрээнд газар эзэмших эрхийг баталгаатай, урт хугацаатай болгож улмаар ядуучуудад зориулсан нүүрсэнд түшиглэсэн эрчим хүчний хувилбарыг илүү хүртээлтэй болгохоор заажээ. Энэ 2 стратеги нь шууд бус утгаараа ой модны салбарт ашиг тусаа өгч болох юм. Ядуурлыг бууруулах стратегийн хөтөлбөрт тус улсад тулгарч байгаа байгаль орчны шинжтэй 6 хурцадмал асуудлын нэгэнд ойн нөөц бололцоо хомсдож байгааг дурьдсан байна. Ийнхүү хомсдож байгаа

шалтгааныг гал түймэр, хөнөөлт шавьжийн тархалт, ойжуулах явдал хангалтгүй байгаа, хууль бусаар мод бэлтгэх явдалтай холбож үзжээ.

51. *Хөдөөгийн хөгжлийн стратеги.* ХХС нь ЯБСББ нэгэн адил эцсийн байдлаар боловсрогдож гараагүй байна. Энэ 2 баримт бичиг нь хоорондоо харилцан уялдаатай байх ёстой ажээ. ХХС ой модны салбарыг цаашид эдийн засгийн хөгжлийн нэг хувилбар гэхээсээ илүү байгаль хамгаалах явдалтай уялдуулан дурьдсан байна. ХХС ой модны салбартай холбогдуулан авах арга хэмжээнд дараах зүйлийг оруулжээ. Үүнд, эрх зүйн болон бүтэц зохион байгуулалтын шинэчлэл, дахин болон шинээр ойжуулах үйл явдалтай холбогдуулан техникийн чадавхийг сайжруулах, гал түймрээс урьдчилан сэргийлэх болон гал түймэртэй тэмцэх, түүнчлэн хөнөөлт шавьжийн тархалттай тэмцэх, эцэст нь цаашид ойн нөөц баялгийг илүү үр ашигтай ашиглах явдал тус тус орж байна.

52. *Ойн үндэсний хөтөлбөртэй харьцуулах нь.* ЯБСББ болон ХХС нь үндсэндээ Ойн үндэсний хөтөлбөрт дурьдсан нэн тэргүүний ээлжинд тавих зорилтуудыг мөн анхааралдаа авчээ. Үүнд, бүтэц зохион байгуулалтын болон эрх зүйн шинэчлэл, ойг түймэр болон хөнөөлт шавьжны тархалтаас хамгаалах, мөн ойн аж үйлдвэрийн салбарыг орчин үеийн түвшинд хүргэж, шинэчлэх явдал тус тус орж байна. Ойн үндэсний хөтөлбөрийн нэгэн адил гол анхаарлаа техникийн шийдэлд хандуулсан байна. Тухайлбал, хөнөөлт шавьжтай тэмцэх арга хэмжээнүүд, ойжуулах арга техник, түүнчлэн мод боловсруулах чадавхийг орчин үеийн түвшинд хүргэж сайжруулах явдал үүнд хамрагдаж байна. ЯБСББ болон ХХС аль аль нь хууль бусаар мод бэлтгэх явдлыг газар авсан үзэгдэл гэж хүлээн зөвшөөрсөн байна. Гэвч энэхүү асуудал ямар цар хүрээтэй байгаа талаар тодорхой зааж өгсөнгүй. Хууль бусаар мод огтолж байгаа явдлын шалтгааныг ядуурал, байгаль орчны хууль тогтоомжийн талаар мэдлэг сул, урьдчилан сэргийлэх үр бүтээлтэй арга хэмжээ байхгүй байгаа, байгаль орчныг хамгаалах талаар орон нутгийнхнаас гаргаж байгаа санаачилга дорой байгаатай холбож үзсэн байна.

53. Хууль бусаар мод бэлтгэх асуудалтай тэмцэх талаар гаргаж тавьсан стратеги нь хоорондоо мэдэгдэхүйц ялгаатай байна. Ойн үндэсний хөтөлбөрт санал болгосон арга хэмжээ нь дээрээс доошоо хандсан чиглэлтэй. Өөрөөр хэлбэл ойн хууль тогтоомжийг нарийвчлан боловсруулж, улмаар байгаль хамгаалагчдад уг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар хяналт тавих бололцоо чадавхи буй болгох асуудлыг дурьдсан байна. Харин үүний ялгаатай Хөдөөгийн хөгжлийн стратегид орон нутгийнханд тухайн ой бүхий газар нутагт урт удаан хугацаагаар эзэмших эрх олгож, улмаар тэндхийн нөөц баялгийг ашиглахыг зөвшөөрснөөр нэг талаас ядуурлыг бууруулах стратегийг дэмжих нөгөө талаас хууль бусаар мод бэлтгэх асуудлыг шийдэхээр дороос дээшээ хандах хандлагыг санал болгосон байна. Мөн ийм хандлагыг хөдөө аж ахуйг болон мал аж ахуйг хөгжүүлэх стратегид тусгалаа олжээ. Гэвч энэхүү санаагаа цаашид хэрхэн ой модны салбарын хувьд ашиглах талаар ХХС тодорхой дурьдаагүй байна. 4 ЯБСББ заган ойд тулгарч буй дарамтыг багасгах замаар өөр төрлийн түлш буй болгоход анхаарлаа хандуулж байна. Харин тайгын ойгоос түлшний мод цуглуулахтай холбогдсон дарамтыг бууруулах талаар ямарваа нэгэн стратегийг санал болгож тавиагүй байна.

<sup>4</sup> Ийнхүү хоорондоо зөрчилдөж учир шалтгаан нь тодорхой бус байна. Энэ нь нэгдүгээрт тус баримт бичгийг бэлтгэхэд зарцуулах цаг нь бага байсантай холбоотой байж болох юм. Нөгөөтэйгүүр энэ нь Байгаль орчны яамны байр суурь ч байж болох юм. Хөдөөг хөгжүүлэх стратегийн баримт бичгийг эцэслэн боловсруулах явдлыг хандивлагчидын дэмжлэгтэйгээр шийдэх ажээ. Хөдөөг хөгжүүлэх стратегийн баримт бичгийг хэдийд дуусах талаар одоогоор тогтоогүй байгаа юм байна.

### 3.3 Ойн менежментийн нэн тэргүүний асуудлууд

54. Монгол улсын ойг шинжлэх ухаанд тулгуурласан тогтвортой ойн менежментийн хүрээнд (энэхүү нэр томъёоны өргөн утгаар нь ойлгож) ашиглаж байсан тухай ямарваа нэгэн баримт алга байна. Жил бүр 2,812-оос 0,854 сая куб метр мод бэлтгэж байсан 1970-1994 оны үеийг ойг бүрэн сүйтгэж байсан үе гэж хэлэхээс аргагүй. Мод бэлтгэлийн жилийн дундаж хэмжээ 0,593 сая куб метр хүрч байсан сүүлийн 8 жилийн хугацаанд ч мод бэлтгэх зөвшөөрөл хэмжээг орон нутгийн аж ахуйн зориулалттай мод болон түлээний мод, түүнчлэн орон нутгийн засаг захиргааны орлогод буюу эрэлт хэрэгцээнд нийцүүлэн тогтоож байлаа. Өнөөдөр жилд зөвшөөрвөл зохих мод бэлтгэлийн тогтвортой хэмжээг бодож гаргахад жил бүрийн дундаж өсөлтийн хэмжээ, ойн өнөөгийн төлөв байдал түүнчлэн бүсчлэлийн байдал, аж ахуйн үйл ажиллагааны эдийн засаг, экологийн боломжтой байдал зэрэг нь гол үндсэн шалгуурууд болдог гэдгийг Засгийн газрын болон тус аж үйлдвэрийн салбарын дээгүүр түвшинд ойлгож байгаа байдал тун бага байна. Зөвшөөрөгдсөн мод бэлтгэл нь цаашид тогтвортой биш байдлаар хэрэгжиж байгаагаас гадна дээр 2.2 хэсэгт дурьдсанаар хууль бус ашиглалт ямарваа нэгэн байдлаар мэдэгдэхгүй өнгөрч байгаа бөгөөд энэ нь жилд 0,345-2,38 сая куб метр буюу нийт мод бэлтгэлийн 36-80 хувьд хүрч байгаа гэсэн тооцоо бий.

55. Өнөөдөр аймаг болон сумын түвшинд ойн менежментийн тогтвортой төлөвлөгөөг харилцан тохиролцож, хэрэгжүүлж байгаа явдал огт алга байна. Аж үйлдвэрийн зориулалтаар мод бэлтгэх явдлыг тогтвортой зарчимд тулгуурлалгүй харин хамгийн их лоббидож чадаж байгаа улсуудад нь, захиргааны түр шийдвэрээр олгож байна. Засгийн газар болон тус аж үйлдвэрийн салбарын түвшний аль алинд нь хэтрүүлэн ашиглах, эсвэл ойн нөөц баялгийг бууруулахаас зайлсхийхийн тулд ойн тогтвортой менежментийг хэрэглэх, түүний үндсэн зарчмын асуудлаар туйлын бага мэдэж байгаа буюу огт ойлгохгүй байна. Ойн үндэсний хөтөлбөрт заасан зорилго, чиглэлийг дунд хугацаанд хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө одоогоор үгүй байна.

56. Сөрөг нөлөө бага үзүүлэх мод бэлтгэх стратегийг одоогоор хэрэглэхгүй байна. Хавтгайруулан огтлох аргыг хориголсон бөгөөд түүвэрлэж огтлох зарим аргыг ашиглах шаардлагатай байна. Гэхдээ модыг түүвэрлэж огтлох нь нэг модыг сонгох эсвэл бүлэг модыг сонгох, үрийн модыг үлдээх, салхинаас хамгаалах зурвас үлдээх зэрэг арга техникээс бүрдэж байх ёстой байдаг. Мод цаашдаа байгалиасаа нөхөн үржих, модны байгалиас тогтсон бүтцийг хэвээр хадгалахын тулд тухайн ой бүрд дээрх хувилбаруудыг аль тохирохыг нь сонгон хэрэглэж байх ёстой. Үүнийг одоогоор хийхгүй байгаа бөгөөд хууль тогтоомж ч бүрэн дүүрэн хэрэгжихгүй байгаа ажээ. НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллагын тусламжтайгаар тус салбарт төлөвлөлт хийх, мод бэлтгэх зөвшөөрөл олж авах, мод бэлтгэх, ашиглах, тээвэрлэх болон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн талаарх стандартыг тодорхойлсон мод бэлтгэх үндэсний кодексийг саяхан боловсруулж гаргасан байна. Энэхүү кодексийг одоогоор хуульчлан батлаагүй байгаа бөгөөд хэдийгээр үүнийг хуульчлан баталсан ч гэсэн цаашид үр бүтээлтэйгээр хянаж хэрэгжүүлэх дүрэм журам, урамшуулал байх эсэх нь эргэлзээтэй байна. Нөгөөтэйгүүр тус кодекс нь ойн өнөөгийн нөөц бололцоог харгалзаж үзвэл цаашдаа хэрэгжих үндэслэлгүй хөрөнгө оруулалт болон мод бэлтгэлийн түвшинд илүү анхаарлаа хандуулсан байна.

57. Ойд бие даасан хэмжилт хийх ямарваа нэгэн заалт, авч буй арга хэмжээ байхгүй учраас мод бэлтгэхэд хог хаягдал маш их хэмжээгээр гарч байна. Мод бэлтгэлийн хураамжийг бэлтгээд, тээвэрлээд, очих газраа очсон хойно нь байгаль хамгаалагч, мод боловсруулагч, бэлтгэгч нарын хооронд хэлэлцэн тохирч тогтоож байна. Хэмжилт хийх, модны төрөл зүйлийг тогтооход гажуудал гарч

байгаагаас бэлтгэсэн модны хэмжээ болон үнэ цэнийг дутуу үнэлж байна. Мод бэлтгэлийн хураамж бага, ой модонд гарч байгаа хаягдал их, мөн хууль бусаар мод бэлтгэх явдал их хэмжээгээр явагдаж байгаа учраас Монгол улсын Засгийн газарт ой модны үйл ажиллагаанаас олох орлогыг үгүйсгэж, улмаар нуугдмал байдлаар татаас буй болгож байгаа учраас нийт модны аж үйлдвэрийн салбарын үр ашгийг доройтуулж байна.

58. Эцэст нь тэмдэглэж хэлэхэд Монгол улсад өнөөдөр ой модны талаар хууль, дүрэм журам, бодлого, хөтөлбөрүүд нэлээд хэмжээгээр байгаа боловч **газар дээр нь эдгээрийг төлөвлөх, удирдан зохион байгуулах, хянах систем бүрэлдээгүй байна.** Үүний улмаас хууль ёсоор болон хууль бус байдлаар тогтвортой биш хэлбэрээр модыг ашиглаж байгаагаас өнөөдөр модны нөөц сэтгэл түгшээм хурдацтайгаар барагдаж, ой мод устаж байна. Модны нөөц баялгийн үндсэн асуудалтай бүтээлчээр ажиллахын оронд Монгол улсын Засгийн газар өнөөдөр хоёрдогч асуудалд гол анхаарлаа хандуулснаараа зарим нэг арга хэмжээ авч байгаа мэт дүр үзүүлж байх бөгөөд энэ нь үр бүтээлтэй эсэх нь эргэлзэл төрүүлж байна. Ийм хоёрдогч асуудлуудад ойн модны бүртгэл, тооллого, гал түймрийг хяналтанд авах, хөнөөлт шавьж болон модны өвчний хяналт, мөн дахин ойжуулах асуудлууд орж байна.

59. Ойн тооллого. 1975 онд ойн тооллогыг 1 удаа хийснээс хойш дахин хийгдээгүй. Ой менежментийн төслийн төвөөс орон нутгийн захиргаатай хийсэн гэрээний дагуу сумын түвшинд ойн тооллогыг 1998 оноос эхэлж хийсэн байна. Жил бүр 800 мянган га газарт тооллого хийхдээ газрын гадаргын аргачлалыг хэрэглэдэг бөгөөд энэхүү аргачлал 1950-аад оноос хойш өөрчлөгдөөгүй байна. Нөөц баялгийн менежментийн байгууллагууд нь өнөөдөр байгалийн нөөц баялгийг бүртгэхдээ орчин үеийн хиймэл дагуулын дүрс зургийг ашигладаггүй бололтой бөгөөд 1990 оноос хойш агаарын зураг авалтыг шинээр хийгээгүй байна. Тооллогод ойн бүтэц, газрын ангилалт, модны өндөр, диаметр, нас, төрөл, ойн хэв шинж, хөрсний төрөл болон гал түймрийн түүх зэргийг шалгуур болгон ашигладаг байна. Энэ нь хэдийгээр модны тооллогын арга боловч үүнийг онцгой хамгаалалттай бүс, хамгаалалттай бүс болон ашиглалтын бүсэд ямарваа нэг ялгаваргүйгээр хэрэглэж байна. Ойн нөөцийн хайгуул судалгааг 8-10 жилийн хугацаанд дахин давтаж хийхээр эхэндээ төлөвлөсөн боловч одоогийн байдлаар санхүүжилт, хүн хүчний дутагдалын улмаас үүнийг 20-иос дээш жилийн давтамжтайгаар хийх болжээ. Судалгаа тооллогын үр дүнг компьютерт оруулаагүй байх бөгөөд зөвхөн цаасан дээр хэвлэсэн илтгэл маягаар тарааж байна. Энэхүү илтгэлд мод бэлтгэх тогтолцоо, жилд бэлтгэх модны хэмжээ, хяналт тавих хуваарь болон бусад нөхөн үржүүлэх чиглэлийн зааврыг багтаадаг байна. Гэвч энэхүү бүртгэл тооллогын дүн болон жил бүрийн зөвшөөрөгдөх огтлолтын хэмжээ хоёрын хооронд ямарваа нэгэн тодорхой уялдаа холбоо харагдахгүй байгаа ба гаргасан зөвлөмжийг ч ховорхон мөрддөг ажээ (НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр 2001 он). Хандивлагчид энэ чиглэлээр техникийн туслалцаа үзүүлж Сэлэнгэ аймагт орчин үеийн ойн нөөцийн хайгуул судалгааны техникийг дасгал сургуулилт маягаар үзүүлсэн ба мөн орчин үеийн ойн нөөцийн судалгаа болон төлөвлөлтийн эрэлт хэрэгцээний талаар танилцуулсан (ЖФТА 1998 он, Теусан 2000 он) боловч энэ нь одоогийн ойн нөөцийн хайгуул судалгааны хөтөлбөрт ямарваа нэгэн нөлөө үзүүлээгүй байна.

60. *Ойн түймрээс урьдчилан сэргийлэх ба түймэр унтраах арга хэмжээ.* Ойн түймрийг хяналтанд авах түймэр унтраах асуудлаар ГТХАНийгэмлэг, НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага болон, Европын холбооноос техникийн туслалцаа үзүүлжээ. Эдгээр бүх хөтөлбөрүүд нь Засгийн газрын гал түймэртэй тэмцэх үүрэг бүхий байгууллагуудын хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоо, зохицуулалт, олон нийтийг сургах, гэгээрүүлэх, гал түймрийг урьдаас илрүүлэх, түүнчлэн практикийн шинжтэй харилцаа холбоо тогтоох, гал унтраах сайжруулсан, сүүлийн үеийн арга барилын талаар сурталчилж таниулсан байна.

Гэвч галын менежментийн эдгээр хөтөлбөрүүдэд экологийн утга агуулга дутагдаж байна. Хүний амь, өмч, болон аж ахуйн зориулалттай нөөц бололцоог хамгаалах нь мэдээжийн хэрэг чухал боловч нөгөө талаар тайгын бүсийн ойг цаашид сэргээх нөхөн үржүлэхэд гал түймэр нь байгалийн нэг чухал хэрэгсэл болдгийг хүлээн зөвшөөрч байх хэрэгтэй. Дэлхий нийтээр өнөөдөр ойг хуурай болон чийгтэй уур амьсгалаас нь шалтгаалан өөрчлөлтөд хэрхэн автдагаар нь тодорхойлох болсон байна. Үүнд "өөрчлөлтөд хүчтэй нэрвэгдсэн", "өөрчлөлтөд орсон ойн байдал" ба эсвэл "бага зэргийн өөрчлөлтөд орсон" гэж хуваадаг ажээ (Хүснэгт 4). Монголын хойд нутгийн бүс нь хээр, ойт хээр, тайгын ой болон уулын ойн бүстэй учраас дээрх гадны нөлөөнд автагдах ойн бүх хэлбэрүүд байгаа болов уу. Ойт хээрийн болон тайгын бүсэд түргэн устгах нөлөө бүхий гал түймэр 50-200 жилийн хугацаатай давтагдаж явдаг бол чийгтэй сэрүүвтэр уулын бүсийн ойд ойн түймэр нь 500 жилийн давтамжтай явагддаг байна. Ойт хээрийн болон хуурай уур амьсгалтай тайгын бүсэд томоохон гал түймрийн хооронд жижиг гал түймэр ойр ойрхон хугацаатай үүсдэгээс эдгээр ойд төрөл бүрийн нас, бүтэцтэй ой модны бүлэглэлүүд буй болж улмаар гал түймрийн идэш болох "түлшний нөөцийг" буй болгох үр дагавартай байдаг байна. Цаашид гал түймрийн үйл ажиллагаанд удирдлага болгохын тулд байгалийн ойн бүс, түүний тогтолцооны гал түймрийн экологийг бүрэн ойлгох явдал үнэхээр шаардлагатай байна. Монголын хойд бүс нутгийн ойд нас гүйцсэн буюу хөгширсөн мод зонхилох явдал нь (2-р абзацийг үзнэ үү) эдгээр ойг гал түймэрт өртөх боломжийг нэмэгдүүлж байгаа ба улмаар гал түймрийг хяналтандаа авах, унтраах буруу хандлага бүхий арга барил нь яваандаа эдгээр ойг ирээдүйн томоохон маш хурц үр дагавартай гал түймрийн түлш болгож бэлтгэх хугацааг нэмэгдүүлж байгаа хэрэг юм. Иймд гадны нөлөөллийн экологийг улам сайн ойлгосноор цаашид галын менежментийн үр бүтээлтэй хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх, улмаар дэвшилттэй, экологид түшиглэсэн нөхөн үржихүйн арга ажиллагаанд түшиглэсэн зааварчилга гаргахад хэрэг болж болох юм.

61. *Хөнөөлт шавьж ба өвчнийг хяналтанд авах.* Хойд бүсийн ойд ойг шинээр үржүүлэхэд гал түймрийн дараа орох чухал ач холбогдолтой хэрэгсэл бол хөнөөлт шавьж өвчнийг хяналтанд авах явдал юм. Энэ нь ялангуяа сэрүүн буюу чийгтэй бүсэд буй хөгшин модтой ойд ач холбогдолтой байдаг. Гал түймэртэй нэгэн адил хөнөөлт шавьж болон модны өвчний ойд үзүүлэх нөлөө, экологийн үр дагаварыг сайн ойлгох хэрэгтэй бөгөөд ингэснээрээ эдгээрийг дарах, тэмцэх үйл ажиллагааны талаар илүү мэдээлэлд түшиглэсэн экологийн болон эдийн засгийн үндэслэл бүхий шийдвэр гаргахад ашиг тустай байж болох юм. Алс холын ойн бүсэд өндөр өртөгтэй химийн бодис цацах арга хэмжээ авах нь ялангуяа тусгай хамгаалалттай газрын хувьд, эдийн засгийн хувьд ашиггүй, экологийн хувьд ч зохисгүй байж болох юм.

62. *Ойжуулах ба шинээр ойжуулах арга хэмжээнүүд.* Монгол улсын Засгийн газар одоогийн байдлаар 400 мянгаас 600 мянган долларын хөрөнгийг дахин ойжуулах буюу шинээр ойжуулахад зарцуулдаг ажээ.<sup>1 5</sup> Энэхүү төсвийг Байгаль орчны яам хяналтандаа байлгадаг бөгөөд урьдчилан баталсан төлөвлөгөөний дагуу аймгуудад хуваарилдаг байна. Төлбөрийг ойгүй газар шинээр мод суулгасны төлөө гэрээлэгчдэд төлдөг байна. Мод бэлтгэх зөвшөөрөл авсан гэрээлэгчид зөвшөөрөлтэйгөө хамт уг газарт мод суулгах шаардлагыг хүлээн авдаг ба тэд хэдийгээр дахин шинээр мод тариагүй ч ойлгомжгүй шалтгаанаар зөвшөөрлөө үргэлжлүүлэн авдаг байна. Шинээр мод тарьсан 1 га тусам 100 доллар, үр суулгасан 1 га тутамд 91 доллар, харин тодорхой биш "үржүүлгийн

---

<sup>5</sup> Энэхүү хэлэлцүүлэгт ойлгомжтой байх зорилгоор дахин ойжуулах гэдэгт сүүлийн, жишээлбэл 20 жилийн дотор модтой байсан газар нутагт дахин шинээр мод суулгахыг хэлэх бөгөөд харин шинээр мод суулгах гэдэг нь хэдэн арван жилийн өмнө ойг нь устгасан буюу зарим онцгой тохиолдолд огт ойгүй байсан газар шинээр мод суулгах ажлыг хэлдэг ажээ.

ажил" гэгчид 1 га тутамд нь 51 доллар төлдөг ажээ. Төлбөрийн 50 хувийг урьдчилгаа болгон өгдөг ба үлдсэнийг амьдралтыг тогтоосны дараа төлдөг байна.

Энэхүү сүүлчийн мөнгийг дараах томъёоллоор тооцож төлдөг ажээ. Хэрэв бүх тарьсан модны 40-өөс дээш хувь нь ургасан бол бүх мөнгийг төлнө. Хэрэв 25-40 хувь нь ургасан бол төлбөрийг 50-100 хувийн хооронд хийдэг ба харин 25-аас доош хувь нь ургасан бол өмнө төлсөн урьдчилгаа мөнгийг гэрээлэгч эргэж төлөх ёстой ажээ. Энд нэг бэрхшээлтэй асуудал нь энэхүү амьдралтыг тогтоох ямарваа нэгэн дүрэм журам байдаггүй бөгөөд (ялангуяа үрээр тарьсан нөхцөлд) улмаар албан тушаалтнууд зөвхөн гэрээлэгчдийн үрээр тарьсан талбай болон амьдралтын түвшинг тогтоодог байна. Ер нь амьдралтын түвшин голдуу нь 20-40 хувьтай байдаг бөгөөд цөөн хэдэн газар 50-аас дээш хувьтай байдаг ажээ (Брэтэнкс 2001 он).

**Хүснэгт 4** Ойн санд гарсан гол өөрчлөлтүүд тэдгээрийн төрөл : Экологийн онцлог шинж тэмдэг ба менежмент

1.Өөрчлөлтөд орсон ойн төлөв байдал: цаг уурын хуурайшилттай нөхцөлд ойн түймрийн улмаас бүтэц нь алдагдсан янз бүрийн насны модод бүхий ой,

**Шинж тэмдэг нь:**

- Өвслөг болон бутлаг ургамал бүхий ойн цоорхой ба янз бүрийн насны ой
- Байнгын гадаргуугийн түймэр нь модон түлшийг шатааж, ургамал ургах бололцоог нээдэг
- Түймэр нь ургамлын зүйлийн бүрэлдэхүүн, ойн бүтцийг өөрчилж, түлшний нөөцийг зохицуулдаг
- Түймрийн давтамж нь хамгийн чухал: хэт их түймэр нь ойн нөхөн сэргээлтэд ноцтой үр дагвартай, давтамж бага байх нь ойн өсөлтийг болон шатах материалын нөөцийг ихээр хуримталж үүний улмаас ойн түймрийн аюул нэмэгдэнэ.
- Ерөнхийдөө биологийн төрөл зүйл хувьд хомс боловч заримдаа нутгийн уугуул ургамлын төрөл зүйл байх нь элбэг. Махчин болон салаа туурайтан амьтад нь ч ойн төрөл зүйлийн нэг чухал хэсэг нь болдог.
- Төрөл зүйлийн тоо хэмжээ нь гол, булаг болон ус намгархаг газрын орчинтой холбоотой.

Өөрчлөлтөд орсон ойн насны ангилал

ЗАЛУУ (<40 жил)	ДУНД (40-70 жил)	НАС ГҮЙЦСЭН (70-120 жил)	ХӨГШИН (>120 жил)
25%	30%	25%	20%

**Санал болгож буй ойн аж ахуйн арга хэмжээ:**

Ганц нэгээр эсвэл хэсэг бүлгээр сонгон огтлох, бага хэмжээний (<10 га) талбайд нилэнхүйд нь огтлолт явуулах

**2. Өөрчлөлтөд хүчтэй нэрвэгдсэн ой:** Ерөнхийдөө гэнэтийн хүчтэй өөрчлөлтийн улмаас үүссэн ижил насны ой

**Шинж тэмдэг:**

- Ерөнхийдөө ижил насны ой, заримдаа хүчтэй нөлөөлөлийн дараа үлдсэн нас гүйцсэн ой
- Ойн түймэр нь гол хүчин зүйл болдог бөгөөд, хөгшин ой хортон, иш холтосны шавьж болон модны үндэсний өвчлөлд нэрвэгддэг
- Ойн өөрчлөлтийн давтамж нь 100- 150 жил байдаг
- Биологийн төрөл зүйл нь ойн экосистемийн өөрчлөлт ба ойн нас гүйцэх үйл явцтай холбоотой.
- Ойн биологийн төрөл зүйл нь " ойн захаас үзүүлэх нөлөөлөл" нэмэгдсэнтэй шууд холбоотой байж болно.

Өөрчлөлтөд орсон ойн насны ангилал

Залуу (<40 жил)	ДУНД (40-70 жил)	НАС ГҮЙЦСЭН (70-120 жил)	ХӨГШИН (>120 жил)
<40%	>30%	>20%	>10%

**Санал болгож буй ойн аж ахуйн арга хэмжээ:**

Хэсэг ой сонгох, үрийн болон зурвас мод үлдээх, мөн жижиг эсвэл дунд хэмжээний (10 – 40 га ) нилэнхүйд нь огтлох

**3. Бага зэргийн өөрчлөлтөд орсон ой:** Чийглэг уур амьсгал дахь янз бүрийн настай, ганц нэгээрээ эсвэл хэсэг бүлгээрээ хүчтэй өөрчлөлтөд нэрвэгдсэн ой  
**Хэв шинж:**

- Янз бүрийн настай, биологийн төрөл зүйлээр баялаг байх
- Хэсэглэл эсвэл ганц нэг үхсэн модны орон зай сүүдэр ургасан өсвөр залуу модтой
- Сөрөг нөлөөлөл байхгүйн улмаас амьтан ургамлын төрөл зүйл олон
- Өөрчлөлтийн дараа ургаж буй ой нь биологийн төрөл зүйлээр баялаг
- Ойн захын нөөлөөл нь маш онцгой байдаг, тухайлбал төрөл зүйлийн орчинг өөрчилж, түймэрт нэрвэмтгий болгодог..
- Уламжлалт ойн арга ажиллагаагаар менежмент хийхэд бэрх
- Нэлэнхүйд нь огтлох арга нь биологийн төрөл зүйлд ноцтой хохирол учруулна

Өөрчлөлтөд орсон ойн насны ангилал

ЗАЛУУ (<40 жил)	ДУНД (40-90 жил)	НАС ГҮЙЦСЭН (90-150 жил)	ХӨГШИН (>150 жил)
20%	>25%	>40%	15%

**Санал болгож буй ойн аж ахуйн арга хэмжээ:**

Ой тус бүрт судалгаа хийх

Хэсэг бүлэг эсвэл бага хэмжээгээр (<1-2 га) нилэнхүйд нь огтлолт явуулах

Үүнээс гадна ойжуулалтын үр дүнгийн судалгааг болон сүүлчийн төлбөрийг намар хийж байгаа. Гэтэл Монголын зун нь чийгшилтэй байдаг уур амьсгалд шинээр тарьсан мод хамгийн их эндэх тохиолдол нь намраас хавар хүртэлх хуурай хугацаанд гардаг байна. Шинээр мод тарих ажилд саад болж байгаа хамгийн сөрөг нөлөө бүхий хүчин зүйлүүд гэвэл, мод үржүүлгийн чанар тааруу, ойжуулах талбайгаа буруу сонгодог, тарьц болон талбай нь тохирдоггүй, тарилтын хугацаа алдаатай ба ойжуулалт хийсний дараа хамгаалах, арчлах явдал огт хийгддэггүй байна. Ойжуулах талбайг сонгохоос өмнө байгалийн нөхөн сэргээлтийн дэмжих бололцоо байгаа эсэхийг тооцоолдоггүй байна. Брэтэноукс /2001/ иш татсанаар байгалийн нөхөн сэргээлт хийж болох тайлбайг ойжуулах талбай бэлтгэх үедээ эсвэл ойжуулалтын явцад эвдэх, бүр цаашилбал ургаж буй зулзган модыг шинээр ухаж авдаг тохиолдол ажиглагджээ. Ургалтын түвшин сайн байсан ч ойжуулах ажлын экологи, эдийн засгийн үндэслэлүүд эргэлзээтэй хэвээр байна. Ойжуулах талбайг гол төлөв хүрч очиход дөхөм байдлыг харгалзан зардал хэмнэх зорилгоор сонгосон байх бөгөөд ингэснээр ойн захад буюу хуурай, задгай талбайг сонгож авдаг. Ийм талбайд ургах нь байтугай цаашид мод ургах төлөв байдал тун муу бөгөөд ялангуяа байнга өөрчлөгдөн хуурайшиж буй уур амьсгалд яваандаа найдваргүй байж болох юм (Дэлхийн банк 2002 он). Нөгөөтэйгүүр 130-150 жилийн дараа л зах зээлд гаргаж болох тийм нөхцөл байдалд аж ахуйн зориулалтаар мод тарих эдийн засгийн болон санхүүгийн ямар ч аргыг өнөөгийн цэвэр өртгийг үндэслэн хэрэглээд үндэслэлийг нь гаргаж ирэх боломжгүй юм.

63. Энэхүү эргэлзээтэй 4 хөтөлбөрт анхаарлаа тавьж санхүүжилт хийж байгаа нь Монгол улсын засгийн газар, Байгаль орчны яамны цаашид байгалийн нөөц баялгийн хөтөлбөрүүдийг хөгжүүлэх, төлөвлөх, нэн тэргүүний ач холбогдолтойг нь тодорхойлох чадавхитай эсэхийг эргэлзээтэй болгож байна. Түүнээс гадна хандивлагчдын төслүүд ч байдлыг сайжруулах талаар чамалмаар арга хэмжээ авсан байна:

- Ямарваа нэгэн стратегийн уялдаа холбоо байхгүйгээр бие биеэсээ тусдаа техникийн туслалцааны хөтөлбөрүүд хэрэгжүүлсэн байна.
- Нэн тэргүүний ач холбогдолтойг нь тодорхойлохгүйгээр өргөн хүрээтэй стратеги зорилтуудыг зааж өгсөн байна. Ингэснээрээ нэгэн зэрэг хэрэгжүүлж болох арга хэмжээний тоонд хязгаар байхгүй мэт ойлголт төрүүлжээ.
- Одоогийн байгаа, цаашид тогтвортойгоор ашиглаж болох модны нийлүүлэлтэнд огт таарахгүй хөрөнгө оруулалтын талаарх зөвлөмжийг өгч байжээ.

#### IV. МОНГОЛ УЛСЫН ОЙ МОДНЫ АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАР

##### 4.1 Ой модны аж үйлдвэрийн салбарын түүхэн хөгжил

64. Монгол улсын ой модны аж үйлдвэрийн салбар 1926 онд Ерөө болон Бугантад модны 2 үйлдвэрийг ЗХУ-д үйлдвэрлэсэн хөрөө рамд түшиглэн байгуулснаар эхэлжээ. Дараа нь Сүхбаатар, Дулаанхан болон Улаанбаатарт 1937 онд шинэ боловсруулах үйлдвэр байгуулсан ба Тосонцэнгэлд 1959 онд, Хялганатад 1970 онд, Зүүнцэнгэлд 1980 онд ийм үйлдвэрүүдийг байгуулсан байна (НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр 2001 он). Энэхүү ой модны аж үйлдвэрийн салбарыг ирээдүйн нийлүүлэлтийн тогтвортой байдалд огт анхаарал тавихгүйгээр зөвхөн эрэлт хэрэгцээнд түшиглэн зохих хэмжээгээр болон байрлалтайгаар буй болгосон байна. 1980 онд мод боловсруулах үйлдвэрийн тоо оргилдоо хүрсэн бөгөөд тухайн үед мэдэгдэж байснаар 60 үйлдвэрийг байгуулжээ. Үүнд:

• Гуалин, банз бэлтгэх том жижиг үйлдвэр	53
• Зоргодос хавтангийн үйлдвэр	2
• Фанер зүсэх үйлдвэр	1
• Фанерийн үйлдвэр	1
• Картоны үйлдвэр	1
• Чүдэнзний үйлдвэр	1
• Зөөлөн салфетка цаасны үйлдвэр (хаягдал цаас ашиглан)	1

Мод боловсруулах үйлдвэрийн хүчин чадалд хөрөнгө оруулах явдал 1980-1985 оны хооронд оргилдоо хүрсэн бөгөөд 1980-аад оны дунд үед ой модны аж үйлдвэрийн салбар 20000 хүнийг ажиллуулж нийт аж үйлдвэрийн бүтээгдэхүүний 18 хувийг үйлдвэрлэж байлаа. Энэ үед ой модны аж үйлдвэрийн салбарт ажиллаж байсан бүх үйлдвэрүүд нь төрийн өмчит буюу бусад ЭЗХТЗ-ийн орнуудтай (тухайлбал Румын болон Орос) хамтарсан үйлдвэр байлаа.

65. ЗХУ-ыг задарснаас буюу 1990 оноос хойш Монгол улс эдийн засгийн өргөн хүрээтэй реформийг хэрэгжүүлж эхэлсэн билээ. Дээрх шинэчлэл нь төвлөрсөн төлөвлөгөөт болон хяналтанд байсан эдийн засгаас өрсөлдөөн, хувийн хөрөнгө оруулалт болон Монголд үйлдвэрлэгдсэн бүх бараа үйлчилгээг зах зээлд суурилсан үнэтэй болгоход чиглэгдсэн зах зээлийн эдийн засаг руу шилжихийн тулд явагдсан. Энэхүү эдийн засгийн шинэчлэлтийн үр дүнд мод бэлтгэх, боловсруулах зэрэг олон үйл ажиллагааг нэг доор явуулдаг төрийн өмчийн бүх ойн үйлдвэрүүдийг хувьчилсан. Хувьчлалын үр дүнд эдгээр томоохон үйлдвэрүүд нь олон жижигхэн нэгжүүдэд хуваагдсан. 1996 он гэхэд нийт аж үйлдвэрийн салбарын бүтэц хоорондоо уялдаа холбоогүй 54 томоохон аж ахуйн нэгж, дээрээс нь 500 гаруй орон нутгийн чанартай хөрөө рам, цехүүдэд хуваагдаж ажиллах болсон байна. 1990 оноос эхлэн нийт зах зээлд эрэлт хэрэгцээ хэтэрсэн учраас мод боловсруулах салбар үндсэндээ уналтанд орсон. 1990 онд байсан ой модны боловсруулах үйлдвэрийн салбарын хэмжээ нь орон нутгийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан оршин тогтнох аргагүй болсон бөгөөд энэ нь сүүлийн 30 жилийн туршид тус улсын хүрч болох модны нөөц баялгийг шавхсаны үр дүнд модны хангамжийн ноцтой бэрхшээл урган гарсантай холбоотой.

## 4.2 Монголын ой модны аж үйлдвэрийн салбарын одоогийн бүтэц

66. Монголын ой модны аж үйлдвэрийн салбар уналтанд орсон хэвээр байгаа гэдгийг нотлох нэлээд хэмжээний баримт байгаа ба сүүлийн 5-10 жилийн дотор үйлдвэр болон боловсруулах тоног төхөөрөмжинд хийсэн хөрөнгө оруулалт нь тун хязгаарлагдмал хэмжээнд байна. Энэ нь нэгдүгээрт, урьд өмнө ой модны нөөц бололцоог шавхсан, хоёрдугаарт, сүүлийн үед ой бүхий газар нутгийг шинээр бүсчлэн хуваарилсантай холбоотой байж болох юм. Өнөөдөр тус салбар нь түр зуур ч гэсэн хууль бус мод бэлтгэх явдалд түшиглэн үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд энэхүү хууль бус мод бэлтгэх явдлыг шилжилтийн үзэгдэл гэж үзэж байгаа учраас цаашид шинээр хөрөнгө оруулах явдалд урамшуулал болж чадахгүй байгаа бололтой.

67. Монголын ойн модны үйлдвэрүүдийн холбоо нь өнөөдөр 24 идэвхитэй гишүүдээс бүрдэж байгаа бөгөөд эдгээр гишүүд нь дараах 3 хэлбэрт хуваагдаж байна. Үүнд: 100 буюу түүнээс дээш хүмүүс ажиллуулж буй хуучин төрийн мэдэлд байсан том хэмжээний хувьчлагдсан мод боловсруулах үйлдвэр, 10-80 хүн ажиллуулж буй дунд хэмжээний хувийн үйлдвэр, 3-5 хүн ажиллуулж буй жижиг хувийн үйлдвэрүүд болно. Нийт ажиллагсадын тоо 3000 хүн байгаа гэж тооцож байна. Монголын ой модны үйлдвэрүүдийн холбооны гишүүд нь нийтдээ 120 мянган куб метр эцсийн буюу хагас боловсруулсан модон бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүч чадавхитай бөгөөд энэ нь ойролцоогоор жилд 300-аад мянган куб метр гуалинг шаардана гэсэн үг юм.

68. *Зах зээл.* 1990 оноос өмнө ЗХУ нь Монголын модон бүтээгдэхүүний гол зах зээл байжээ. 1990-ээд оноос Орост эхэлсэн эдийн засгийн шинэчлэлийн үр дүнд Монголын модон бүтээгдэхүүний зах зээл үндсэндээ нурсан байна. Монголын ой модны бүтээгдэхүүний ЗХУ дахь хэрэглээг орлохуйц нь 1990-ээд оны эхээр Хятад экспортын томоохон зах зээл болж тодорч гарч иржээ. 1999 онд УИХ, Монгол улсын Засгийн газар ойн татварын хууль баталж 1 куб метр модонд 150 ам.долларын экспортын татвар ногдуулсан бөгөөд энэ нь үндсэндээ гуалин экспортлохыг хориглосон хэрэг болсон юм. Саяхан энэхүү экспортын тарифыг шинэчлэн, мөн хагас боловсруулсан бүтээгдэхүүн тухайлбал төмөр замын дэр мод банз болон балк моднуудыг үүнд оруулах болжээ. Одоо зөвхөн хоёрдогч буюу эцсийн модон бүтээгдэхүүнийг энэ татвараас чөлөөлж байна (тухайлбал фанер буюу хийж угсарсан модон тавилга гэх мэт). Энэхүү тарифын гол зорилго нь нэгдүгээрт, Монгол улсын модны нөөцийг гуалин хэлбэрээр экспортод гаргахыг зогсоох, хоёрдугаарт, орон нутгийн модыг тус улсад боловсруулах явдлыг хангах, гуравдугаарт, дотооддоо бэлтгэсэн мод болон модон эдлэлийн дотоодын зах зээлийн эрэлт хэрэгцээг хангахад чиглүүлэх. Монголын ой модны аж үйлдвэрийн холбооныхны мэдэгдэж байгаагаар энэхүү экспортын тарифын үр дүнд Монгол улсын ой модны аж үйлдвэрийн салбар дотоодын зах зээлд бүрэн тогтоно гэж найдаж байгаа ажээ.

69. Монголын ойн бүтээгдэхүүний дотоодын эрэлт хэрэгцээний талаар үнэлгээ дүгнэлт өгөх зах зээлийн судалгааг төрийн байгууллага, төрийн бус байгууллагын аль аль нь авч хэрэгжүүлээгүй байна. Монголын ойн модны үйлдвэрүүдийн холбооноос тэмдэглэсэнээр өнөөгийн мод бэлтгэх зөвшөөрөгдсөн хэмжээ буюу жилд үйлдвэрлэлийн зориулалтаар 39500 куб метр, 580000 куб метр түлшний модны хэмжээ нь дотоодын эрэлт хэрэгцээний зөвхөн өчүүхэн хэсгийг хангаж байгаа бөгөөд ийм зөрүүтэй байгаа байдал нь хууль бусаар мод бэлтгэх явдлын гол шалтгаан болж байгаа ажээ.

70. *Бүтээгдэхүүн ба бүтээгдэхүүний үнэ.* Өнөөдөр тус салбар нь шинэс, нарс болон багаахан хэмжээгээр хуш бэлтгэж боловсруулахад үйл ажиллагаагаа чиглүүлж байна. Хусыг өнөөдөр аж үйлдвэрийн зорилгоор бэлддэггүй бөгөөд харин дотоодын түлшний хэрэгцээнд зориулан их хэмжээгээр бэлдэж байгаа

бололтой. Өнөөдөр Монгол улсын мод боловсруулах салбар нь үндсэндээ 5 төрлийн модон бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. Үүнд: орон сууцны зориулалтаар балк мод, банз, төмөр замын дэр мод, төрөл бүрийн савх мод, мөн ахуйн эдлэл болно. Албан ёсоор мод боловсруулагчдын үйл ажиллагааны зардал, бүтээгдэхүүний үнэ болон татвар төлөхийн өмнөх олох ашгийг 4-р хүснэгтэд харуулав. Хууль бусаар ажиллагсадын өртөг зардал мэдэгдэхгүй байгаа бөгөөд харин тэдгээрийн бүтээгдэхүүний үнэ 1 куб метр нь 30-50 ам.доллар байдаг гэж тооцдог байна. Хууль бусаар боловсруулагчид нь ямарваа нэгэн татвар, НӨТ төлдөггүй байна.

**Хүснэгт 5. Албан ёсоор мод боловсруулагчдын үйл ажиллагааны зардал, бүтээгдэхүүний үнэ болон ашиг.**

Бүтээгдэхүүн	Одоогийн үйл ажиллагааны зардал (Ам.долл/ м <sup>3</sup> )	Борлуулах үнэ (Ам.долл/м <sup>3</sup> )	Ашиг <sup>1</sup> (Ам.долл/м <sup>3</sup> )
Балк	35	55-70	20-35
Анхан шатанд боловсруулсан банз	35	50-55	15-20
Хатаасан банз	45-55	75-85	20-40

<sup>1</sup> Татвар, НӨТ төлөхөөс өмнө. Эх үүсвэр: Ойн модны үйлдвэрүүдийн холбоо (хувь хүний санал)

71. *Санхүүжилт.* Монголын ой модны үйлдвэрийн холбоо баталж байгаагаар 1980-аад оны дундаас хойш шинэ үйлдвэр, тоног төхөөрөмжид ямарваа нэгэн хөрөнгө оруулалт хийгээгүй байна. 1990-ээд оны эхээр эхэлсэн эдийн засгийн шинэчлэл нь одоогоор Монгол улсын хувийн компаниудад хямд өртөг зардал бүхий санхүүжилт буй болгох үнэт цаасны зах зээлийг тогтоогоогүй байна. Нөгөөтэйгүүр, банкны арилжааны салбар нь нэг талаас зээл авах бололцоогоор хоёрдугаарт, өртөг зардлын хувьд өндөр эх сурвалж ажээ. Товчхон хэлбэл Монголын ой модны аж үйлдвэрийн салбар нь өнөөдөр хямдхан үнэт цаасны зах зээл богино болон урт хугацааны зээл эсвэл хөрөнгө оруулалтыг дэмжих бондын зах зээлгүйгээр үйл ажиллагаа явуулж байна. Өнөөдөр үйлдвэр болон үйлдвэрийн тоног төхөөрөмжид хийх хөрөнгө оруулалтыг боловсруулагчид өөрсдийн орлогоос зохих хэмжээгээр эргүүлэн оруулснаар гүйцэтгэж байгаа ажээ.

72. Жижиг хэмжээний, орон нутгийнханд түшиглэсэн ажиллагаа явуулахад Хөгжлийн Алтан Сан /ХАС/ санхүүгийн байгууллагын<sup>2</sup> 6 бичил зээл үндсэндээ шинэ эх үүсвэр болж байна. Ийм төрлийн жижиг хэмжээний зээл нь 30-60 хоногийн хугацаанд модыг бэлтгэж улмаар борлуулах хүртэл циклээр ажилладаг, жижигхэн үйл ажиллагааны эргэлтийн хөрөнгө буй болгоход тустай байж болно. Бичил зээл олгогчдын санхүүгийн чадвараас гадуур (жишээлбэл 10000-30000 ам.доллараас дээш) санхүүжилтийг жижиг хэмжээний боловсруулах тоног төхөөрөмжийг сольж илүү үр ашигтай зөөврийн боловсруулах технологи худалдаж авахад зарцуулж болох юм.

73. *Мод боловсруулах үйл ажиллагаа.* Энэхүү судалгааг хийж байх үед ажигласан ихэнх модны цех нь дараах зүйлээс бүрдсэн хөрөө ажиллуулж байв. Үүнд:

<sup>2</sup> ХАС нь 1999 оны 9 сард банк болж байгуулагдсан бөгөөд Монголчуудад жижиг хэмжээний бизнесийг шинээр эхлүүлэхэд нь туслаж байгаа ажээ. Дундаж зээлийн хэмжээ 150 ам.доллар байдаг байна. Нэмэлт мэдээллийг ХАС банкны вэб сайтаас харна уу).

- Гуалингийн тавцан
- Ямар ч холтос хуулагч байхгүй (гараар хамгийн наад захын хэмжээнд холтсыг хуулдаг ажээ)
- Гар гуалин түлхэгч
- Ирийг нь сольдог олон ир бүхий цахилгаан хөрөө
- Цахилгаан мотор (20-30 морины хүчтэй)
- Хөрөөдсөн банзыг хураах тавцан (банз, балкийг гараар хураадаг ажээ.)

Банзны ирмэг болон гадаргууг тэгшлэгч ямарваа нэгэн тоног төхөөрөмж харагдахгүй байх бөгөөд банзны уртыг тохиолдлын байдлаар тогтоодог байна. Банзны уртыг хэрвээ зохицуулж тайрдаг бол гараар (гинжин хөрөөгөөр) эсвэл тусдаа хөрөөгөөр тайрдаг байна. Эдгээр тоног төхөөрөмж нь маш хоцрогдсон (30-аад жилийн өмнө Орос улсад үйлдвэрлэсэн) байх бөгөөд эдийн засаг болон ашигт ажиллагааныхаа хугацааг аль хэдийн гүйцээсэн байх юм. Сэлбэг хэрэгсэл нь (технологийн хувьд хоцрогдсон учраас) анх үйлдвэрлэгчээс олдох боломжгүй бөгөөд Монгол улсад байгаа бусад ижил төрлийн тоног төхөөрөмжөөс тонож ашигладаг нь ойлгомжтой.

74. Одоо хэрэглэж буй боловсруулах технологи нь өнөөгийн ойн нөөц бололцоотой харьцуулах юм бол үндсэндээ "шударга биш" гэж үзэж болно. Шинэс болон нарсыг өндөр чанарын гуалин болгон боловсруулдаг ба энэ нь өндөр үнэтэй барилгын материал болж гардаг байна. Шинэ бөгөөд бага оврын үр ашигтай технологийг хэрэглэснээр эдгээр модноос илүү үнэ өртөг олж болох бөгөөд цаашид модон эдлэлийг шинэсээр хийж улмаар түлшний модонд хэрэглэх явдлыг зогсоож болох юм.

#### **4.3 Ой модны аж үйлдвэрийн салбарын эдийн засагт оруулж буй хувь нэмэр**

75. *Тус салбарын орлого.* Ашиг орлогын хувьд Монголын ой модны аж үйлдвэрийн салбарын эдийн засагт оруулж буй хувь нэмрийг хууль ёсны мод бэлтгэгч болон боловсруулагчдаар төлөөлүүлж болох ба энэ нь маш бага хэмжээнд байна. Өнөөдөр энэ чиглэлээр үйл ажиллагаа зохион байгуулалттай явуулж байгаа байгууллагууд нь модны хураамж болон бусад татвар хураамжийг төлсний дараа богино хугацаанд нийтдээ 30-40 хувийн цэвэр ашигтай байгаа бөгөөд зарим тохиолдолд 5 хувийн ашиг ч олдог байна. Энэ нь тухайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа боловсруулагчид, худалдагчид болон зах зээлийн эрэлт хэрэгцээнээс шалтгаалж байна. Монголын ой модны аж үйлдвэрийн холбоо нь гишүүдээсээ тэдний орлого зарлага болон орлогын албан татвар, элэгдэл хоргодлын дараах ашгийн талаар ямарваа нэгэн мэдээлэл авдаггүй байна. Иймд Монгол улсын ойн нөөц баялгийг ашиглаж боловсруулснаас хувийн хэвшилд орж буй эд баялгийн талаар ямарваа нэгэн хэмжилт дүгнэлт хийх бололцоогүй байна.

76. *Ой модны аж үйлдвэрийн салбарын ажилтан ажилтнуудад өгч буй цалин.* Ой модны аж үйлдвэрийн ажилчдын нэгдсэн холбооноос үнэлж байгаагаар энэ салбарын ажилчдын дундаж цалин сард 60000-70000 төгрөг байгаа ажээ. Энэ нь тус үйлдвэрчний эвлэлийн байгууллагаас энэ салбарт ажиллаж байгаа ажил олгогчидтой хэлэлцэн тохирсон цалин юм. Энэ цалин болон тус холбооны 1670 гишүүний тоон дээр үндэслэн тооцож үзэхэд Монголын ой модны аж үйлдвэрийн салбараас жилд цалингийн хэлбэрээр олгож байгаа орлого нь 1,2-1,4 тэрбум төгрөг буюу 1,08-1,26 сая доллар байна. Мөн аж үйлдвэрийн зорилгоор болон түлээний зорилгоор хууль бусаар мод бэлтгэж байгаа хүмүүст ч эндээс зохих

орлого очиж байгаа нь тодорхой. Хэдийгээр хууль бус салбарт ажиллагсад нь сарын цалингийн оронд тодорхой тохирсон хэмжээгээр хөлс мөнгө авч байгаа учраас энэ салбарын цалингийн орлогыг тодорхойлоход амаргүй боловч хамгийн наад захын үнэлгээгээр бодож үзэхэд энэ нь хууль бусаар үйл ажиллагаа явуулагчидтай адилхан хэмжээний орлогыг цалингийн хэлбэрээр олгож байна гэсэн тооцоо байна.

77. *Төр засгийн байгууллагад орж буй орлого-хураамж болон бусад төлбөрүүд.* 2000-2001 онд мод бэлтгэснээс авах хураамжийн орлого нь 420000- 516000 ам.доллар болж байжээ. Ой модны нөөцийн бүртгэл тооцоог хийх ажлыг санхүүжүүлэхийн тулд га-аас 9500 төгрөг буюу ойролцоогоор 1 куб метр-ээс 240 төгрөгийн бүртгэлийн хураамжийг авдаг байна. Энэ хураамжийг түлшний модноос авдаггүй учраас бүртгэлийн хураамжийн нийт орлого нь хамгийн дээд зах нь 10000 доллар байгаа гэж тооцдог байна.

## **V. ОЙ МОДНЫ АЖ ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ШИНЭЧЛЭЛ, БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ГОЛ АСУУДЛУУД БОЛОН БЭРХШЭЭЛҮҮД**

### **5.1 Модны тогтвортой нийлүүлэлт**

78. Жилд бэлтгэх модны зөвшөөрсөн хэмжээ гэдэг нь үндсэндээ цаашид тус салбарын тооцоолсон өсөлт (жилийн дундаж өсөлт), ойн өнөөгийн төлөв байдал (одоогийн мод бэлтгэлийн ба урд өмнө хэтрүүлэн бэлтгэсэн хэмжээ), ойн бүсчлэл (шууд ашиглахаар зориулагдсан бүсүүд), эдийн засгийн болон байгаль орчны хувьд үйл ажиллагаа явуулах боломж зэргийг харгалзан үзэж тооцож гаргадаг. Ойжуулж ашиглах тогтолцоо (силвикултурын систем) ба эргэн ашиглах хугацааны хүрээнд жилд бэлтгэх модны зөвшөөрсөн хэмжээг бодож гаргахын тулд гурван тусдаа тооцоо гаргах хэрэгтэй болдог. Үүнд:

- Тогтвортой хамгийн их бэлтгэх ургац. Энэ нь модны ургалт, ургацын талаар хийсэн судалгааны үндсэн дээр модны хэмжээнд түшиглэн хийх тооцоо бөгөөд хүрч очиж судлах бололцоотой ой дахь жилийн өсөлтийг харуулж байдаг. (Үүнийг жилд бэлтгэх модны зөвшөөрсөн хэмжээг тооцоход нэг хувьсагч болгон хэрэглэнэ).
- Мод бэлтгэх түвшин. Энэ нь жил бүр ямар нэг сөрөг үр дагавар учруулахгүйгээр бэлдэж болох газрын хэмжээ буюу модны тооны тооцоо. Энд ойн менежментийн ерөнхий зорилго, тогтвортой хэмжээнд бэлтгэх модны гарцын мэдээлэл, байнгын байгууламжууд болон төрөл зүйлийг хадгалах хэрэгцээ, шаардлага, байгаль орчны сөрөг нөлөөллүүд (тухайлбал ус, биологи, ландшафтын тогтвортой байдал) болон бусад хүчин зүйлийг харгалзан үзнэ. (Үүнийг жилд бэлтгэх модны зөвшөөрсөн хэмжээг тооцоход нэг хувьсагч болгон хэрэглэнэ).
- Жилд бэлтгэх модны зөвшөөрсөн хэмжээ. Ой бүрээр гаргасан мод бэлтгэх түвшинд тохируулан жил бүр тогтвортойгоор бэлдэж болох модны хэмжээнд түшиглэсэн тооцоо. (Энэ нь тооцооны эцсийн дүн байна).

79. Жилд бэлтгэх модны зөвшөөрөх хэмжээг тооцохдоо богино болон дунд хугацааны хүчин зүйлүүд болох үйлдвэрлэл эрхлэх боломж буй болгох, ажил олголт, аж ахуйн үйл ажиллагаа, орон нутгийнхны эдийн засгийн тогтвортой байдал зэргийг мөн харгалзан үзэж болно. Жилд бэлтгэх модны зөвшөөрсөн хэмжээ нь жилээс жилд өөр байж болох боловч 10-15 жилийн хугацааны тогтвортой түвшинд баланслаж байх ёстой. Эдгээр хүчин зүйлүүдийг харгалзан үзсэний үндсэн дээр Монгол улсад жилд бэлтгэх модны зөвшөөрсөн хэмжээг Хүснэгт 6-аар жишээлэн, маш ойролцоогоор бодож гаргав.

80. Хүснэгт 6-д ашигласан тооцоонууд нь зарим талаар зүйд нийцэхгүй байж болох боловч ямар ч гэсэн үндэслэлтэй юм. Монголын хувьд модны эргэлтийн хугацаа 130 жил гэдгийг нийтээр хүлээн зөвшөөрдөг бөгөөд зарим ( тухайлбал, НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн 2001 онд болон Жаакко Пойрийн 1995 онд боловсруулсан) баримт бичгүүдэд дурдсан жилийн дундаж өсөлт нь Хойд Америкийн Тайгын экосистемтэй ( жиш: Тайгын хөндийд 1,25 м<sup>3</sup>/га/жил ба Тайга Корделад 0.7м<sup>3</sup>/га/жил ) ойролцоо дүйж байна. Бичил бүсчлэлийн талаарх мэдээллийг ЯОТА-гаас 1998 онд Сэлэнгэ аймагт хийсэн бүртгэл тооллого болон менежментийн судалгааны дүнгээс авсан ба тус ашиглалтын бүс дэх "загвар ойн" ашиглалтын дүн шинжилгээ хийхдээ төлөөлүүлэн ашигласан болно. Зүүн гар талын хоёр баганад байгаа жилд мод бэлтгэх зөвшөөрсөн хэмжээний тооцоо нь одоогийн ашиглалтын бүсийн ойтой холбогдуулан гарсан тооцоо болно. Баруун гар талд байгаа хоёр баганад байгаа жилд мод бэлтгэх зөвшөөрсөн хэмжээний тооцоог байгаль орчны болон эдийн засгийн үр ашгийн тооцоог маш няхуур, нухацтай хийсний үндсэн дээр одоогийн хамгаалалтад байгаа бүсийн 25 хувийг (1,9 сая га-г) ашиглалтад гаргахаар зөвшөөрсөн гэж тооцож гаргасан болно.

81. Хэрэв, ашиглалтын бүс дэх жилд зөвшөөрөгдөх мод бэлтгэлийн хэмжээ нь бодит байдалтай ойр байлаа гэхэд өнөөгийн зөвшөөрөлийн дагуу бэлтгэх модны жилийн хэмжээ нь жилд зөвшөөрөгдөх мод бэлтгэлийн хэмжээнээс дунджаар 1,3 дахин, нийт бэлтгэл нь / зөвшөөрөлтэй болон хууль бус мод бэлтгэлийг оруулаад / 4 дахин илүү байна. Хамгаалалттай бүсээс 1,9 сая га-г ашиглалтын бүсэд нэмж оруулаад ч, өнөөгийн нийт мод бэлтгэлийн хэмжээ жилд зөвшөөрөгдөх мод бэлтгэлийн хэмжээнээс дундажаар 1,75 хувиар илүү байна.

**Хүснэгт 6. Монгол улсын ашиглалтын бүс болон зарим хамгаалалттай бүсээс жилд бэлтгэх модны зөвшөөрсөн хэмжээ (бүх талбай, бүх төрөл зүйлийг оруулан).**

	<b>1,19 сая га ашиглалтын талбай байгаа гэж тооцсон.</b>		<b>1,19 сая га ашиглалтын талбай, мөн 1,9 сая га-г хамгаалалтын бүсээс шилжүүлнэ гэж тооцсон</b>	
<b>Эргэлтийн нас (жилээр)</b>	130		130	
<b>Жилийн дундаж өсөлт (м<sup>3</sup>/га)</b>	0.75	1.20	0.75	1.20
<b>Эргэлдүүлэхээр ашиглаж буй талбайд ургаж байгаа мод (м<sup>3</sup>/га)</b>	97.5	156	97.5	156
<b>Нийт талбайд ургаж байгаа мод (сая м<sup>3</sup>)</b>	116.03	185.64	301.275	482.040
<b>ЖЗМБ-ийн хамгийн дээд хэмжээ (м<sup>3</sup>)</b>	892,540	1,428,000	2,317,500	3,708,000

Ашиглах боломжийн тооцоо хийсний дараа ЖЗМБ-ийн хэмжээ (м <sup>3</sup> )	374,865 <sup>1</sup>	599,760 <sup>1</sup>	374,865	599,760
			<u>479,750</u>	<u>798,000</u>
			873,600 <sup>2</sup>	1,397,760 <sup>2</sup>

Хүснэгт 5-ын тайлбар:

<sup>1</sup> ЯОТА-гийн 1998 оны бичил бүсийн тооцоогоор 42%-ийг ашиглах боломжтой, 26%-ийг газар нутгийн газар зүйн байрлалын улмаас ашиглах боломжгүй, 15% нь хангалттай модны нөөцгүй, 17%-ийг модгүй газар гэж үзжээ. ЯОТА нь нэлээд тохиромжтой бүс сонгож авсан учир энэ нь бусад ашиглалтын бүстэй харьцуулахад хавьгүй өндөр үзүүлэлт бололтой.

<sup>2</sup> Дээрх тооцоонд үндэслэн ашиглалтын бүсийн 42% хувийг, хамгаалалтын бүсээс шилжүүлсний 35%-ийг ашиглах боломжтой гэж үзэв. (Тухайлбал, 35% нь ашиглах боломжтой, 25% нь хангалттай нөөцгүй, 10% нь бэлчээр, 30% нь бартаанаас шалтгаалан ашиглах боломжгүй гэж тооцсон).

Мэдээлэл хомс байгаа учраас хоёр чухал хүчин зүйлийг харгалзаагүй учир дээрх хүснэгтийн доод эгнээний тооцоо нь зохиомлоор өндөр гарч байгаа байх. Үүнд:

- Модны нөөцөд хус, улиасыг оруулж тооцсон. Зарим аймагт нийт модны нөөцийн 40 гаруй хувийг эдгээр мод бүрдүүлдэг бөгөөд үйлдвэрийн зориулалтаар эдгээр модыг бэлддэггүй.
- Бүх талбайд хүрч очиж ашиглах боломжгүй байгаа бөгөөд зам гүүр барих төлөвлөгөө боловсруулж, ашиглах бололцоотой болсон хойно эдгээр талбайг жилд бэлтгэх модны зөвшөөрлийн хэмжээнд оруулж тооцох ёстой.

Эдгээр хоёр хүчин зүйлийг харгалзан үзвэл жилд бэлтгэх модны зөвшөөрлийн хэмжээ 25-30 хувиар буурч болох юм.

82. Энэхүү илтгэлийн өмнөх хувилбарт / Ван Дер Плас 2003/ ой модны нийлүүлэлт ба хэрэглээний талаар нааштай дүр зурагтай байсан бол энэ илтгэлд түлээний модны ашиглалтын асуудлыг хурцаар тусгасан болно. Ой модны хэрэглээнд хийсэн дүн шинжилгээнд бүс нутгийн хэрэглээг үнэлэх асуудлыг тусгасан бөгөөд түүнийг 101 –р хэсгийн 8-р хүснэгтэд дурьдсан болно. Монголд өнөөдөр ой нөөгийн байдлыг жинхэнээр үнэлэх найдвартай мэдээлэл хомс учир ой модны нийлүүлтийн асуудалд дүн шинжилгээ хийх боломжгүй юм. Ойн өсөлтийн тооцоонд үндэслэн өсөлт сайтай, өсөлт удаантай ойн нөөцийн 1 ба 3 хувийг огтлохоор зохиогч тооцсон байна. Энэ тооцоо нь шилмүүст ойн жилийн дундаж өсөлт нь 1,42 ба 4,26 м3/ га/ жил байх ба заган ойн жилийн дундаж өсөлт нь 1,18 м3/га/жил байхад 15 - 47 сая м3 мод жилдээ бэлтгэхээр болж байгаа юм. Зохиогч ойн нөөцийн 1- 3 хувийг огтлохоор тооцохдоо огтлолтын эргэлт нь 50-100 жил байхаар авч үзэж хөгшин ойн нөөц 180-300 жилийн хугацаанд хэт их хуримтлагдаж болно гэдгийг анхаарч үзээгүй байна. Дээрх хэмжээний бэлтгэл нь байгалийн ойн менежмент гэхээс илүү хөгшин ойг огтлох буюу ойг сайжруулахад чиглэгдэхэд хүргэж байна.

Хэрэв жилд бэлтгэх модны хэмжээ нь бодитой, өсөлтийн тооцоон дээр суурьсан бол нас гүйцсэн модыг огтлох шийдвэрийг түргэн шуурхай хэрэгжүүлж болно. Нас гүйцсэн хөгшин ойтой бүтцээс "ойн менежментэй" чиглэлрүү шилжлээ гэхэд, хэрэв жилд бэлтгэх модны хэмжээг тооцохдоо зөвхөн нас гүйцсэн модыг л бэлтгээд байх бол хөгшин ойн нөөц дуусахаас гадна, түүний гуалин эсвэл түлшний мод гэхээс бусад ойн ач холбогдол алдагдана. Харамсалтай нь өнөөгийн байдлаар нас гүйцсэн мод бэлтгэх сонирхол давамгайлдаг ба энэ нь улам эрчимжиж байна.

Доор дурьдсан тооцоог авч үзвэл зохиогчийн модны нийлүүлэлтийн талаарх дүн шинжилгээний ач холбогдол буурах болно:

- Ойн сан нь нийтдээ эрүүл бөгөөд зохих ойн нөөцтэй гэж авч үзэх
- Хуулиар тогтоогдсон ойн бүсчлэлд өөрчлөлт хийгээгүй ( тухайлбал онцгой бүсийн 48% д мод бэлтгэлийн ямарч ажил хориотой, хамгаалалтай бүсийн 47%-д зөвхөн ахуйн хэрэглээний зориулалтаар мод бэлтгэхийг зөвшөөрдөг)
- Зам харилцааны хүндрэлийн улмаас хүрч очих боломжгүй, байгаль орчин, эдийн засгийн нөхцөл байдал бүрдээгүй
- Түлшний модноос өөр ямар ч ойн дагалт баялагийг ( зэрлэг ан амьтны амьдрах орчин, биологийн төрөл зүйл ойн далаат баялгийг ) авч ашиглах боломжийг тооцох

83. Зохиогчид энэхүү илтгэлд дурьдсан нийлүүлэлт ба хэрэглээний талаар хийсэн дүн шинжилгээг, ялангуяа нийлүүлэлтийн хэмжээн дээр консерватив байдлаар хандсан болно. Гэсэн хэдийч бид ирээдүйд ой болон байгаль орчныг хамгаалах бололцоог аль болох өргөн хүрээнд авч үзэх зорилгоор "урьдчилан анхааруулах зарчим"-ийг баримталсан болно. Ван Дер Плас /2003/ нарын илтгэлд дурьдагдсан иймэрхүү өөдрөг дүн шинжилгээгээр өнөөгийн мэдээлэлийн хангалттай бус байдлыг зөвтгөж чадахгүй бөгөөд энэ нь ердөө л хий хоосон, тогтвортой бус үр дүнг сайшаасан хэрэг болсон байна.

## **5.2 Хууль тогтоомжийг сахиж мөрдөх, хууль бус үйл ажиллагаа.**

84. Энэхүү илтгэлд өмнө нь дурьдсанаар хууль бус мод бэлтгэх явдал нь өргөн хүрээг хамрах болсон бөгөөд Байгаль орчныг хамгаалах агентлагийн дэд захирал бөгөөд улсын ерөнхий байцаагчийн тус судалгааны багтай уулзаж ярилцах үед тэмдэглэж хэлснээр "Монгол улсын ойн нөөц баялагт өнөөдөр заналхийлж буй цорын ганц хамгийн том аюул" ажээ. Гэтэл тус багийг Монгол улсад ажиллаж байх үеэр Богд Хан уулын дархан цаазат газарт (ЮНЕСКО-ийн Хүн ба байгальд бүртгэгдсэн) Улаанбаатараас ойрхон, онгоцны буудал руу явах замд ил мод унагаж байсан бөгөөд энэ талаар ямарваа нэгэн арга хэмжээ авахгүй байлаа. Хэрэв улсын нийслэлийн дархан цаазат газарт ийм үйл ажиллагааг тэвчин хүлцэн өнгөрүүлж байгаа бол аймаг болон сумын түвшинд ямар арга хэмжээ авч байгаа гэж бодох вэ? Дараах хэсгүүдэд дурьдсанаар, хууль тогтоомж хэрэгжүүлэх ажилд бүтэц зохион байгуулалтын нэлээд бэрхшээл учирч байгаагаас гадна хамгийн томоохон бөгөөд суурь ач холбогдолтой бэрхшээл нь энэхүү асуудалтай бүтээлч, шийдвэртэй тэмцэх чиглэлээр улс төрчид болон төрийн өндөр албан тушаалтнуудад хүсэл эрмэлзэл дутаж байгаа явдал юм.

85. Байгаль орчны болон байгалийн нөөц баялгийг ашиглахтай холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх нь аймаг, сумын хэмжээнд ажиллаж буй байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагчдын үүрэг ажээ. Тус улсад 510 байгаль орчны байцаагч, 512 байгаль хамгаалагчид байгалийн нөөц хамгаалалт, бүтээгдэхүүний чанар, хүнсний аюулгүй байдалтай холбоотой 30-аад хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд хяналт тавьж байна. 1994 онд энэ чиглэлийн мэргэжлийн ажилтнууд бэлдэх техникум болон техник мэргэжлийн сургуулийн үйл ажиллагаа зогссоноос хойш одоо ажиллаж явуулж байгаа болон шинээр ажиллах хүмүүст мэргэжил дээшлүүлэх талаар ямар нэгэн сургалт явагдаагүй байна. Хууль хэрэгжүүлэх ажилтнуудын техникийн болон эрх зүйн мэдлэг тэднийг үйл ажиллагаагаа үр бүтээлтэй явуулахад шаардлага хангадаггүй талаар яриа байдаг ажээ. Байцаагч, байгаль хамгаалагч нарын аль аль нь бие даасан тээврийн хэрэгсэл байхгүй бөгөөд зарим шалгалт үйлчилгээ хийхийн тулд ойн модны аж үйлдвэрийн салбарт ажиллагсадад найдахад хүрдэг байна. Улсын байцаагч, байгаль хамгаалагч нарын аль аль нь аймаг, сумын захиргааны дэргэдэх байгалийн нөөц баялгийг ашиглах зөвшөөрлийг олгодог байгууллагуудад

харьяалагдаж байжээ. Мод гуалинг ачиж зөөвөрлөхөд олгодог гол зөвшөөрөл нь "гарал үүслийн гэрчилгээ" нэртэй бичгийг маш олон янзаар урвуулан ашигладаг тухай яригддаг. Гуалин болон модон бүтээгдэхүүнийг хууль ёсоор бэлдэж, зөөж байхад зориулж ямарваа нэгэн ил тэмдэг тавьж ашигладаггүй. Замын шалгалт зэрэг хамгийн наад захын арга техникийг ч тодорхой давтамжтайгаар ашигладаггүй байна. Дүгнэж хэлэхэд нөөц бололцоогоор хомсхон орон нутагт, өөрийн үүрэгт ажиллагаагаа хэрэгжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмж багаж хэрэгсэл байхгүй, дээд түвшний байгууллагуудаас дэмжлэг тусламж бараг авдаггүй нөхцөлд ажиллаж, амьдарч байгаа тохиолдолд орон нутгийн байгаль хамгаалах чиглэлээр ажиллаж буй ажилтнууд хууль тогтоомжийг хэрэгжүүлж биелүүлэхтэй холбогдсон үүргээ хүлээхдээ зарим тохиолдолд хэрээс хэтэрсэн байр суурь баримталдаг нь ойлгомжтой.

86. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажилд хяналт тавих тогтолцоо зарим талаар өөрчлөгдөж байгаа ажээ. Хамгийн сүүлд саяхан гарсан хууль тогтоомж болон Засгийн газарт хийж буй бүтцийн өөрчлөлтийн хүрээнд бүх байцаагч нар одоо Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дэргэд байгуулагдсан Улсын мэргэжлийн хяналтын албанд харьяалагдах болсон бөгөөд ингэснээрээ тодорхой бие даасан байдалтай болж байгаа юм байна. Харин байцаагч нарын нүд чих болж байдаг байгаль хамгаалагч нар нь сумын засаг даргад харьяалагдсан хэвээр байх аж. Мөн энэ талаар асуудал хариуцсан тусгай прокурор, мөн байгаль орчны болон нөөц баялгийг ашиглах асуудлыг зөрчиж байгаа асуудлаар бодлого боловсруулах тусгай байгууллагууд байгуулсан боловч прокурор, цагдаа, улсын байцаагч, байгаль хамгаалагч нарын хооронд үйл ажиллагаагаа хэрхэн уялдуулж, хариуцлагаа хэрхэн хувиарлах талаар зохион байгуулалтын журам гаргаагүй байна.

87. Монгол улсын Засгийн газар ойн хуулийг хэрэгжүүлэх явдлыг хамгийн нэн тэргүүний ээлжинд хэрэгжүүлбэл зохих хөтөлбөр гэж үзэж улмаар энэ чиглэлийн байгууллагуудыг хүний нөөцөөр хангах, санхүүжүүлэх, үүрэгт ажлаа үр бүтээлтэй хийж гүйцэтгэхэд нь тоног төхөөрөмж олгоход чиглэсэн арга хэмжээ авахгүй бол одоогийн нөхцөл байдлыг сайжруулах ямарваа нэгэн бололцоо харагдахгүй байна.

### **5.3 Ой мод ашиглах зөвшөөрөл ба орон нутгийнхан**

88. Өмнөх хэсэгт дурьдсанаар ойн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх дээрээс доошоо чиглэсэн арга хэмжээ нь урьд өмнө амжилтгүй байсан бөгөөд одоо хэрэгжүүлж буй бүтэц зохион байгуулалтын шинэчлэл нь дангаараа ямарваа нэгэн үр дүнд хүрэх найдвар төдийлэн алга байна. Ойн талаарх одоогийн хууль тогтоомж асуудлыг арай өөр байр сууринаас тавих бололцоо олгож байна. Энэ нь ойг ашиглах удаан хугацааны эрхийг тухайн орон нутгийнханд олгох явдал юм. Ойн нөөц баялгаас эдгээр хүмүүс нь шууд бөгөөд хамтдаа ашиг орлогыг нь хүртдэг гэж үзэх үзэл дээр энэхүү хандлага нь түшиглэж байгаа бөгөөд тэд уг нөөц баялгаа тогтвортойгоор ашиглаж гадныхан хууль бусаар ашиглах явдлаас урьдчилан сэргийлэх урамшуулалтай байдаг гэж үздэг байжээ. Монгол улс хамтын эзэмшлийн ойн тухай ойлголтыг 1996 онд анх нэвтрүүлсэн байна. Энэхүү хэсэгт орон нутгийнхан өөрийн эзэмшилд байгаа ойг хэрхэн ашиглаж байсан туршлага болон тэндээс авах сургамжийн талаар товчхон дурьдана.<sup>3 7</sup>

89. *Ой эзэмших эрх олгох үйл явц.* 1990 оноос хойш Монгол улсын Засгийн газраас олгож байсан ойн эзэмшлийн хэлбэр нь жил бүрийн мод бэлтгэх зөвшөөрөл байлаа. Ойн хуулийн дагуу сонирхсон байгууллагууд өөрсдийн саналаа

<sup>7</sup>Энэхүү хэсгийг Байгаль орчны яам, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн ажилтнууд болон Альбак, 2000 он, Уламбаяр нарын 2002 онд бичсэн илтгэл дээр түшиглэн бэлтгэв

сумын засаг даргад тавих ёстой. Засаг дарга ирсэн саналуудыг тодорхой шалгууруудын дагуу тодруулж улмаар өөрийн сонгож авсан саналуудаа Байгаль орчны яаманд хүргүүлэх ёстой. Энэхүү сумын засаг даргаас зөвшөөрсөн саналын үндсэн дээр Байгаль орчны яамны сайд нь жилд бэлтгэхийг зөвшөөрсөн модны хэмжээг тогтооно. Улмаар энэхүү зөвшөөрсөн модны хэмжээг санал авсан аж ахуйн нэгж байгууллгуудад хуваарилж өгөх юм байна. Ийнхүү мод бэлтгэх зөвшөөрөл авсан этгээд нь Байгаль орчны яамнаас мод бэлтгэх гарал үүслийн гэрчилгээ авсан компанитай гэрээ байгуулах ёстой.<sup>4</sup> 8 Ийм гэрчилгээ олгох үйл явц нь нэлээд нарийн бөгөөд тухайн компани нь ойд мод бэлтгэх явдлыг мэргэжлийн өндөр түвшинд, тогтвортой байдлаар явуулах ур чадавхитайгаа харуулах ёстой ажээ.

90. 1997 онд Байгаль орчны яам сонирхогч талуудад урт хугацаагаар ой эзэмших бололцоог нэвтрүүлсэн байна. Газрын хуульд заасны дагуу орон нутгийн эрх баригчид ой бүхий газрыг 60 жилийн хугацаатайгаар эзэмших эрхийг эхний ээлжинд олгож, үүнийг цаашид 40 жилээр сунгах бололцоотой болсон байна. Жилд бэлтгэвэл зохих модны хэмжээг тогтоодог үйл явцын нэгэн адил сонирхогч талууд энэ талаар өөрсдийн саналаа сумын засаг даргад хүргүүлэх ёстой ажээ. Аж ахуйн нэгж компаниуд болон орон нутгийнхнаас ийм санал орж ирсэн байна. Эдгээр саналыг үнэлэх үндсэн журам нь жил бүрийн мод бэлтгэх зөвшөөрлийг олгохдоо хэрэглэдэг шалгууртай адилхан ажээ. Эзэмших журмаар авсан ойд мод бэлтгэхийн тулд мөн ялгаагүй гарал үүслийн гэрчилгээ авсан байгууллагуудтай гэрээ хийх ёстой юм байна.

91. *Орон нутгийнханд ой эзэмших зөвшөөрөл олгох талаар хандивлагчдын дэмжлэгтэйгээр гаргасан санаачлагууд.* 1996 -1997 онд эхлүүлсэн хоёр төслийн хүрээнд орон нутгийнхан ой эзэмшин ашиглах явдалд дэмжлэг үзүүлж эхэлжээ. Эхний төслийг НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр ба Байгаль орчны яам хэрэгжүүлж эхэлсэн ба хоёрдахь төслийг Дэлхийн зөн байгууллагаас хэрэгжүүлсэн байна. Энэхүү 2 төслийн үр дүнд 1998 онд 15-22 өрх бүхий орон нутгийн зургаан ой хамгаалах хамтлагууд ой эзэмших гэрээ байгуулсан ба нийт газар нутгийн хэмжээ нь 40000 га газар болжээ. Нэг бүлгийн эзэмшлийн газар нутгийн хэмжээ нь 19000 га байсан ба бусад нь 2000-6000 га газрыг хамарсан байна.

92. Дэлхийн зөн байгууллага ой санг орон нутгийнханд эзэмшүүлэхэд дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаагаа үргэлжлүүлж 1999 оны 12-р сард 2 дахь төслөө эхлүүлэн Булган аймгийн нутаг дэвсгэрт орших 4 ой хамгаалах хамтлагт үйл ажиллагаагаа чиглүүлсэн байна. Энэ төслийн гол зорилго нь гал түймэр болон хүний анхаарал болгоомжгүй үйл ажиллагааны улмаас нөөц баялаг нь ноцтойгоор буурсан ойн бүсэд нутгийн иргэдэд тулгуурласан ой хамгаалах, нөхөн сэргээх, ойжуулах болон цаашид тогтвортой ашиглах үйл ажиллагааг дэмжихэд оршино. Төсөлд ялангуяа ядуу өрхийг хамруулсан байна. Төслийн үйл ажиллагаагаар байгуулагдсан 4 ой хамгаалах хамтлагийн 2 нь л ой ашиглах эрх олж авчээ. Эдгээр хамтлагт 5-13 өрхийг хамардаг байна. Тэд гол төлөв үр цуглуулах, боловсруулах, хадгалах, мод үржүүлэг, ойжуулалт, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, гал түймэртэй тэмцэх, ой цэвэрлэх, модон эдлэл хийх, зөгийн бал олзворлох болон ногоо тарих, байгаль орчны талаар мэдээлэл сурталчилгаа явуулах зэрэг үйл ажиллагаа явуулах ажээ. Дэлхийн зөн байгууллагын энэхүү төслийг 2001 онд дахин сунгаж 2004 оны 9 сар хүртэл 3 жил ажиллах болжээ. Энэхүү төслийн 2 дахь шатанд хамрагдах сумдын тоог 11 болгон нэмэгдүүлж төслийн үйл ажиллагаагаа өргөжүүлсэн байна. Нэмэгдсэн 7 сум нь Булган аймгийн өмнөд хэсэгт оршидог бөгөөд уг төслийн гол анхаарах чиглэл нь цөлжилттэй тэмцэх ажлын эрчимжүүлэхэд оршиж байна.

---

<sup>8</sup> Ойн тухай хуулийн 26.3-т заасны дагуу "мэргэжлийн байгууллагууд" гэж нэрлэгдэх ажээ.

93. 2003 оны эхний байдлаар Байгаль орчны яамны мэдээлж байгаагаар Сэлэнгэ, Булган, Хэнтий, Дорнод аймгуудад нийтдээ 270 мянган га газрыг хамарсан 22 ой эзэмших зөвшөөрлийг олгоод байгаа ажээ. Эдгээр зөвшөөрлийн тал хувийг орон нутгийн хамтлагуудад өгсөн байна. Орон нутгийнханд зөвшөөрөл өгөхдөө ой ашиглахаас гадна ой хамгаалах ажлыг оруулж байгаа ажээ. Орон нутгийнханд олгож буй энэхүү зөвшөөрлийн хүрээнд тэд ойжуулах ажлыг улсын төсвийн санхүүжилттэйгээр хийх, тухайн эзэмшилдээ байгаа газарт хууль бус мод бэлтгэх, хулгайн ан хийх, хөнөөлт шавьж тархах, гал түймэр гаргахаас урьдчилан сэргийлэх, түүнчлэн ойн дагалт баялагийг цуглуулах, ойг сийрэгжүүлэх, цэвэрлэх замаар өрхийнхөө хэрэгцээнд түлшний мод цуглуулах явдал орж байгаа юм байна.<sup>5</sup> 9

94. *Орон нутгийнханд ой эзэмших зөвшөөрөл өгснөөс хуримталсан туршилага.* Байгаль орчны яамны ажилтнууд өөрсдийн зөвшөөрсөн орон нутгийнхны ой эзэмших үйл ажиллагааны талаар эерэг үнэлгээ өгч байлаа. Ялангуяа иймэрхүү байдлаар ой эзэмших зөвшөөрөл өгсөн нь дараах үр дүнд хүрсэн гэж үздэг байна:

- Хамтлагийн гишүүдийн ой хамгаалах хариуцлага хүлээх сонирхол нэмэгдсэн. Тухайлбал, эзэмшлийн ойд гадны хүмүүсийг нэвтрүүлэхгүй байх, ойн түймрээс урьдчилан сэргийлэх, мөн унтраах талаар идэвхи чармайлттай ажиллах болсон байна. Ингэснээр зөвшөөрөл өгсөн газар нутагт гал түймэр гарах, хууль бус мод бэлтгэх явдал багассан ажээ.
- Хамтлагийн гишүүдийн өрхийн орлого нэмэгдсэн. Зөвшөөрөл авсан хүмүүст мод үржүүлгийн газар байгуулах, ажиллуулах болон ойжуулалтын талаар сургалт явуулсан ба тэд ийм үйл ажиллагааны төлөө цалин авах болсон байна.

Ой хамгаалах хамтлагийн үйл ажиллагааг цаашид бэхжүүлэхэд тулгарч буй зарим бэрхшээлүүдийг бас тодруулсан байна. Үүнд:

- Ойн менежментийн талаарх ур чадвар хязгаарлагдмал байдал. Үүнтэй холбогдсон зарим сургалт семинар явуулсан нь зохих үр дүнд хүрчээ. Гэвч цаашид энэ талаар чадавхийг бэхжүүлэх шаардлага байсаар байна.
- Шийдвэр гаргах эрх мэдэл хязгаарлагдмал байдал. Хэдийгээр ой бүхий газар эзэмших зөвшөөрөл авсан хэдий ч орон нутгийнхан Ойн тухай хуулиар үйл ажиллагаа нь хязгаарлагдаж байна. Үүний үр дүнд тэнд мод бэлтгэхийн тулд гэрчилгээ бүхий байгууллагатай гэрээ байгуулах, түүнчлэн түлээний мод, ойн дагалт баялагийг ашиглахын тулд зөвшөөрөл авах шаардлагатай хэвээр байна. Тэдэнд мөн хууль хэрэгжүүлэхтэй холбоотой эрх мэдэл байхгүй учраас хууль бус үйлдлийн талаар арга хэмжээ авахын тулд заавал улсын байцаагч буюу байгаль хамгаалагчид хандах хэрэгтэй болдог ажээ.
- Хамтлаг байгуулах эдийн засаг, эрх зүйн тодорхойгүй байдал. Орон нутгийнхны өнөөдөр хэрэглэж болох хувилбарууд нь компани буюу хоршоо болж ажиллах явдал байж болохоор байна. Гэвч эдгээрийн аль алиныг нь зохих ёстой шийдвэр гэж үздэггүй ажээ. Ийнхүү тодорхой зохион

---

<sup>9</sup>Ой эзэмших зөвшөөрөл авч байгаа орон нутгийн хамтлаг болгон дараах баримт бичгийг хүлээн авдаг ажээ: Сумын засаг захиргаатай хийсэн гэрээ, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол, сумын Засаг даргын захирамж, зөвшөөрөл олгосон газрын зураг ордог байна. Уламбаяр болон бусад судлаачид 2002 онд тэмдэглэснээр тэдний судалсан орон нутгийнхны ой эзэмших зөвшөөрөл өгсөн үйл ажиллагаанаас дүгнэлт хийж үзэхэд эдгээр баримт бичиг нь тухайн түрээсийн зорилгыг тодорхойлоогүй, хэдий хэмжээний газарт ойжуулалт хийх, мөн ойн нөөц баялгийг ашигласны төлөө төлөх төлбөр хураамж зэргийг зааж өгөөгүй байжээ. Үүнээс болж сумын захиргаа тухайн ой эзэмшигч хамтлагуудын хооронд үл ойлголцох явдал гарч байсан байна.

байгуулалтанд ороогүй учраас тэд банктай харьцах, зээл авах зэрэг арилжааны гүйлгээ хийхэд учир дутагдалтай байдаг байна.

- Жилийн турш орлоготой ажиллах бололцоо байхгүй. Ой эзэмших зөвшөөрөл нь гол төлөв Засгийн газраас дэмжиж ойжуулалтын хөтөлбөрийн хүрээнд хавар орлого оруулдаг байна. Түүнчлэн ногоо тарих болон бусад дагалт баялаг ашиглах үйл ажиллагаанаас олох орлого нь зун болон намрын эхэн үед орж ирдэг байна. Намрын эхэн болон өвлийн саруудад эдгээр орон нутгийн хамтлагийн гишүүдэд орлого олох үйл ажиллагаа явуулах бололцоог бүрдүүлэх шаардлагатай байна.

95. Булган аймгийн орон нутгийнхны ойн төсөл дээр 1999-2001 онд ажилласан талаар дүгнэлт хийсэн Дэлхийн зөн байгууллагын үнэлгээний багийнхан Байгаль орчны яамны албан тушаалтнуудтай ижил төстэй дүгнэлт хийсэн байх бөгөөд тэд бас зарим зүйлийг нэмж ажиглажээ. Үүнд:

- *Эзэмших ойн хил хязгаар дотор амьдарч байгаа малчид болон тус газар нутгийн гадна амьдардаг хамтлагийн гишүүдийн хооронд зөрчилдөөн гарсан байна.* Тухайлбал, зарим ой эзэмших зөвшөөрлийг тэр нутагт оршин суудаггүй бүлгийнхэнд олгожээ. Эдгээр зөвшөөрөл олгосон бүлгийнхэн дотор мөн тухайн газар нутагт амьдардаг малчид орж байсан байна. Тэд нүүдэллэн явах шаардлагатай учраас тухайн хамтлагийн үйл ажиллагаанд гишүүний хувьд оролцох боломжгүй буюу сонирхолгүй байсан байна. Үүний үр дүнд тэд тухайн орон нутгийнхны ойтой холбоотой үйл ажиллагаанаас ямар нэгэн орлого олдоггүй тэр утгаараа ойг хамгаалах хүсэл багатай байдаг.
- *Ой хамгаалах хамтлаг нь гол төлөв ядуу хүмүүсээс бүрдэж байсан бөгөөд тэдэнд энэ талаар ажиллах туршилага ур чадвар хязгаарлагдмал байдаг.* Орон нутгийн хамтлагууд өөрсдийнхөө үйл ажиллагаа болон санхүүгийн асуудлыг шийдэх, мөн дотооддоо шийдвэр гаргах чиглэлээр нэлээд бэрхшээлтэй тулгарчээ. Дэлхийн зөн байгууллага уг төслийн хүрээнд зөвхөн ядуу өрхүүдийг хамруулснаас анхаарлаа хандуулснаас эдгээр хүмүүс нь энэ салбарын тодорхой мэдлэг чадвар хүрэлцэхгүй байсан байна. Цаашид тэдний ур чадавхийг нэмэгдүүлэх асуудалд анхаарал тавихын зэрэгцээ тухайн орон нутгийн нэн ядуу давхаргаас биш боловч илүү чадварлаг мэдлэгтэй хүмүүсийг энэхүү бүлэгт хамруулахыг мөн үнэлгээний баг зөвлөсөн байна.
- Эзэмшиж буй ойн сангийн хэмжээ нь тухайн хамтлагийн хувьд хэтэрхий их байв. Орон нутгийнханд эзэмшүүлж буй ойн сангийн хэмжээ нь бодит амьдралд тохиромжтой байх ёстой. Хэрэв ойн сан нь хэтэрхий их бол тухайн хамтлаг уг газраа зохих ёсоор хамгаалж, арчилах үүргээ биелүүлэх бололцоогүй болно.
- Орон нутгийн албан тушаалтны үзэж байгаагаар тухайн орон нутгийн ой хамгаалах хамтлаг нь мод бэлтгэл эрхэлэх боломжгүй ажээ. Өнөөгийн байдлаар ой хамгаалах хамтлаг нь өөрсдийн хариуцсан ойн сангаас мод бэлтгэх эрхгүй байна. Тэдэнд мөн иймэрхүү үйл ажиллагаа явуулах тоног төхөөрөмж, сургалт дутагддаг байна. Гэвч урьд өмнө олгосон сургалтаас олж авсан ой модны чиглэлээр зарим ур чадвараа тэд нар үзүүлж чадаж байв. Иймд тэд цаашид мод бэлтгэх чиглэлээр сурч чадахгүй гэх үндэслэл байхгүй юм. Гэвч аймаг, сумын албан тушаалтнууд орон нутгийн ийм хамтлагын гишүүд мод бэлтгэх ажлыг эрхэлж чадна гэж итгэхгүй байлаа.

96. *Дүгнэлт.* Монголын ойн бүс, түүний ойр орчим амьдарч байгаа ард иргэд өнөөдрийн өөрчлөгдөж буй эдийн засгийн нөхцөл байдалд дадаж зохицож амьдрах чадвартайгаа харуулсан билээ. Үүний нэг илэрэл нь хууль бус мод бэлтгэх ажиллагаа юм. Гэвч иймэрхүү үйл ажиллагаа нь өнөөдөр ойн нөөц, баялгийн чанар болон нийт цар хүрээг доройтуулж байна. Засгийн газраас гаргасан олон төрлийн хууль тогтоомж, дүрэм, журам нь тэр болгон мөрдөгдөхгүй байна. Орон нутгийн хэмжээнд зөвхөн тухайн орон нутгийн хэдэн хүнд зориулсан дүрэм, журам нь ойг тогтворгүй байдлаар ашиглах явдлыг хөхүүлэн дэмжиж, улмаар тухайн цөөн хэдэн хүнд ашиг тусаа өгч байна. Үүнийг өөрчлөхийн тулд нэг талаас төр засгийн байгууллагаас тогтоосон хууль дүрэм хэрэгжүүлэх явдлыг сайжруулах, нөгөө талаас орон нутгийн байгууллагуудад энэ талын шинэчлэлийг дэмжсэн өөрчлөлт хийх хоёр чиглэлийн арга хэмжээг шаардаж байх шиг байна. Одоогийн байдлаар орон нутгийнхан өөрсдийнхөө оршин сууж буй газрын эргэн тойрон дахь ой санд ямарваа нэгэн хяналт тавих эрх зүйн боломж алга байна. Байгаль орчны яам болон Дэлхийн зөн байгууллагаас авсан арга хэмжээний хүрээнд орон нутгийнхан ойн санг өөрсдийнхөө хариуцлагад авч хамгаалах сонирхолтой, хүсэлтэй байгааг сүүлийн хэдэн жилийн туршлага харууллаа. Түүнээс гадна тэд ой хамгаалах үйл ажиллагаагаа сайжруулах чадвартайгаа ч харуулсан байна.

97. Цаашид Монгол улсын ойн менежментэд урт удаан хугацаанд эерэг нөлөө үзүүлэхийн тулд өнөөдөр хамтын эзэмшлийн ойн талаар хэрэгжүүлж байгаа төслийн хүрээнд илэрсэн хэд хэдэн дутагдлыг арилгах шаардлагатай байна.<sup>6</sup> 10 Одоогийн концепцийг дараах байдлаар өөрчлөх: Үүнд

- *Хамтын эзэмшлийн тухай концепцийг өргөжүүлж зөвхөн жижиг бүлэг биш нийт орон нутгийнхныг хамруулах.* Тухайн орон нутгийн ойн нөөц баялгийн тогтвортой менежментэд орон нутагт байнга буюу түр оршин сууж байгаа хэн боловч үүрэг хүлээнэ гэдгийг ойлгуулах нь чухал байна. Орон нутгийн ойг ашигласнаас ямар нэг хэлбэрээр хүн бүхэн ашиг хүртэх нөхцөлийг хангах нь хамгийн зөв арга юм. Үүний тулд хууль бусаар мод бэлтгэж байгаа хүмүүс болон жилийн турш тухайн ойн бүсэд нүүдэллэж буй малчдыг оролцуулаад нийт орон нутгийнхныг хамруулах шаардлагатай.
- *Орон нутгийнханд ойгоос ашиглаж болох бүх зүйлийг ашиглах бололцоо олгох.* Үүнд мод бэлтгэх болон бусад төрлийн бүтээгдэхүүн ашиглах түүнийг удирдах явдал орно. Ингэснээр Засгийн газар хандлагаа өөрчилж улмаар орон нутгийнханд ойн менежментийн зохих арга ажиллагаатай болоход нь тус дэмжлэг үзүүлэх чиглэлээр нягт хамтран ажиллахыг шаардах болно. Орон нутгийн засаг захиргааны байгууллагууд ч энэхүү үүргээ биелүүлэхэд нь тус дөхөм үзүүлж дэмжих хэрэгтэй.
- *Орон нутгийнханд үр бүтээлтэй ажиллах зохих бүтэц зохион байгуулалт буй болгоход нь туслах.* Ойтой холбоотой үйл ажиллагаанд өөрөөр хандах, шинэ арга барилаар явуулахтай холбоотой арга замыг буй болгож, дэмжин сурталчлах. Ойтой холбоотой үйл ажиллагааг зохих ёсоор удирдаж, түүнээс олох ашиг орлогыг холбогдох бүх сонирхогч талуудын (төр, орон нутгийнхан болон тодорхой төсөл дээр хөлслөн ажиллуулж буй хүмүүсийн) хувьд шударгаар хуваарилах байна. Эцэст нь тухайн орон нутгийнхны ойгоос олох ашиг орлогыг шударга, үр бүтээлтэй байдлаар хэрэглэх үйл явцыг ч бий болгох шаардлагатай. Үүний тулд одоогийн эрх зүйн зохицуулалтыг эргэж харж цаашид дэмжлэг үзүүлэх чадавхи буй болгох арга хэмжээ авах шаардлагатай байна.

---

<sup>10</sup> Монгол улсад орон нутгийнхны талаар баримтлах бодлогын тухай хавсралт 4-д дурьдсаныг харна уу.

#### 5.4 Нэмүү өртөг буй болгох зорилгоор ойг үр ашигтайгаар боловсруулах

98. Монголд байгаа Сибирийн шинэс буюу Шотландын нарсны (насанд хүрсэн) нөөц нь анхдагч болон хоёрдогч модон бүтээгдэхүүн болгож боловсруулах бололцоотой, зөөлөн модны өндөр чанартай нөөцийг бүрдүүлж байгаа юм. Өнөөдөр энэхүү зөөлөн модны төрлийг цаашид өндөр үнэтэй эцсийн бүтээгдэхүүн болгоход саад болж байгаа гол хүчин зүйл нь Монголын мод боловсруулах салбарын өнөөдрийн хоцрогдсон бөгөөд үр ашиггүй ажиллагаа юм. Нөгөөтэйгүүр Сибирийн шинэсийг өрхийн түлээний хэрэгцээнд гол төлөв хэрэглэдэг бөгөөд маш өндөр чанартай шинэсний гуалин хөрөөдөж, хагалаад гал түлж байгаа нь ийм чухал нөөц бололцоог маш зохистой бус байдлаар хэрэглэж байгаа хэрэг юм.

99. Өнөөдөр боловсруулагчдын хувьд нэмүү өртөг бий болгох хамгийн чухал зарчмын ач холбогдолтой боломж бол боловсруулж байгаа гуалин бүрээс аль болох хог хаягдал багатай, бүтээгдэхүүн гаргаж авахад оршино. Анх мод бэлтгэхээс эхлээд эцсийн бүтээгдэхүүнээ хэрэглэгчдэд хүргэх бүхий л хугацаанд мод боловсруулах үйлдвэрүүдэд нэмүү өртөг буй болгох үйл явц үргэлжилдэг. Гуалинг анх зүсэж боловсруулж эхлэх шатанд л хамгийн өндөр өртөг буй болгох талаар Монголын боловсруулагчид анхаарлаа хандуулах хэрэгтэй. Үүний тулд гуалинг зүсэх хамгийн анхан шатны түвшинд, орчин үеийн бага оврын технологид хөрөнгө оруулалт хийх хэрэгтэй. Үүнд хамгийн тохирох технологи нь нарийн зүсэлттэй, зөөврийн, олон хөрөө бүхий тоног төхөөрөмж бөгөөд энэ нь одоогийн хэрэглэж буй хөрөөнөөс 30 хувь илүү мод гаргаж авдаг бөгөөд 60 хувь бага үртэс ялгаруулдаг ба цахилгаан эрчим хүчний хувьд ч хэмнэлттэй байдаг байна. Хөрөөний үзүүлэлтээс хамааран ийм зөөврийн тоног төхөөрөмжийн үнэ нь 8000-40000 ам.доллар (үйлдвэрлэгчийн ФОБ) байдаг байна. Түүнчлэн гуалингийн хэмжээ болон эцсийн бүтээгдэхүүнээс шалтгаалан зөөлөн модны хувьд ийм суурь машины бүтээгдэхүүн нь сард 75-150 куб метр, жилд 800 куб метр байдаг.

100. Монголын ойн аж үйлдвэрийн салбар нь бүхэлдээ зөөврийн тоног төхөөрөмж авч тавих зөвлөмжийг үүгээр гаргаагүй бөгөөд энэ нь модны аж үйлдвэрийн нийт бүс нутгийн хувьд тэр болгон ач холбогдолтой биш байж болох юм. Шаардлагад нийцэх гуалинг тогтвортой нийлүүлэх боломжийг баталгаажуулсны үндсэн дээр аливаа шинэ хөрөнгө оруулалтыг хийх ёстой нь зүйн хэрэг юм. Гэхдээ өнөөдөр зөөврийн хөрөө нь Монголын нөхцөлд хэд хэдэн шалтгаанаар давуу талтай байх болно. Үүнд:

- Одоогоор гар хүрээгүй байгаа ойн маш тархай бутархай байгаа байдлыг харгалзан үзэх юм бол энэхүү хөрөө рамыг модны эрэлт хэрэгцээ байгаа газар зөөвөрлөх нь тээврийн зардлыг маш их хэмжээгээр бууруулах юм.
- Хөрөнгө оруулалтаа нөхөн авах хугацаа нь харьцангуй бага. (Ойролцоогоор 5 жил)
- Эдгээрийг ажиллуулах, засвар үйлчилгээ хийх нь харьцангуй амархан.(Хөрөөний ирийг засварлаж, солих нь нийт засвар үйлчилгээний дотор хамгийн голлох хувийг эзэлдэг.)
- Бүтээгдэхүүний цар хүрээ, гуалингийн хэмжээ болон гуалинд тавих шаардлагаас хамааран эдгээр хөрөөг 2 буюу 3 хүн ажиллуулах боломжтой.

Нэмүү өртөгтэй боловсруулалтад хөрөнгө оруулалт хийх өөр боломж бол бага оврын ирмэг гаргагч болон өнгөлөгч суурь машин байж болох бөгөөд ингэснээр нэгэн ижил хэмжээтэй банз болон эцсийн байдлаар өнгөлсөн гадаргуутай бүтээгдэхүүн гаргах бололцоотой бөгөөд энэ нь гуалин зүсэх технологид шинэ хөрөнгө оруулалт болох юм. Ийнхүү хоёрдогч боловсруулах технологийн ирээдүйн бололцооны талаар судлах нь энэхүү судалгааны хүрээнд багтахгүй

боловч ийм өндөр өртөг бүхий бүтээгдэхүүний дотоодын эрэлт хэрэгцээ улам өсөн нэмэгдэж байгаа талаар нотлох баримт байгаа билээ.

### 5.5 Дотоодын түлшний үр ашгийг дээшлүүлэх

101. Монгол улсын цаг уур нь доод тал нь 30-40 хэм хүртэл хүйтэрдэг, урт удаан өвлөөр тодорхойлогддог билээ. Амьдрал залгуулахад найдвартай бөгөөд үнэ өртөг багатай дулааны эх үүсвэр маш чухал. Жишээлбэл, Монголын цахилгаан станцын нийт бүтээгдэхүүний 77 хувь нь дулаан, зөвхөн 23 хувь нь цахилгаан байдаг байна. Өнөөдөр Монгол улсад дотоодын нефть болон байгалийн хийн бүтээгдэхүүн байхгүй бөгөөд нефтийн бүх бүтээгдэхүүн, түүний дотор тээврийн хэрэгсэлд голдуу хэрэглэгдэж буй бүтээгдэхүүний ихэнхийг нь Оросоос импортлож байна. Уламжлалт биомассын түлш болох түлээний мод, аргалаас өөр сэргээгдэх эрчим хүчний ач холбогдолтой эх үүсвэр Монголд алга байна. Монгол улсын аж үйлдвэрийн салбар нь Монголын эрчим хүчний төв сүлжээнээс үйлдвэрлэж буй цахилгаан эрчим хүчний 70 хувь, дулааны 28 хувийг хэрэглэж байна. Орон сууцны салбарынхан дулааны эрчим хүчний сүлжээний үйлдвэрлэсэн дулааны 48 хувийг цахилгаан эрчим хүчний 25 хувийг тус тус хэрэглэдэг ажээ. (НАХЕМ 2000 он). Боловсролын салбарын төсвийн 20 -оос дээш хувь нь дулааны зардалд зарцуулагддаг гэсэн тооцоо бий. (Финч)

102. Түлш хэрэглэж буй дотоодын салбар нь үндсэндээ хот, хөдөө, жижиг суурин газруудад амьдарч буй оршин суугчдад хуваагдана. Томоохон хот суурин газар суугчид дотроо мөн 2 хэсэгт хуваагдаж байна:

- Орон сууцанд амьдарч байгаа хүмүүс нь нүүрсээр дулаацаж, цахилгаанаар хоол ундаа хийж байх бөгөөд
- Нэг өрхийн орон сууц буюу (гэр эсвэл жижиг модон байшинд) зууханд түлээ буюу нүүрс түлж дулаацах буюу хоолоо хийж байгаа гэсэн 2 бүлэгт хуваагдаж байна.

Хөдөө орон нутгийнхан 100 хувь түлшний мод эсвэл мод болон аргалын холимог түлшийг дулаацах буюу хоол боловсруулахад хэрэглэж байна. Түлшний мод цуглуулж байгаа найдвартай тоо баримт байхгүй байгаа бөгөөд 6-р хүснэгтэд харуулснаар тус судалгааны багийнханд танилцуулсан 2 жишээнээс үзэхэд энэ талаарх тооцоо нь хоорондоо маш их зөрж байгаа ажээ.

#### Хүснэгт 7. Монгол улс дахь түлшний модны хэрэглээний тооцоо.

Нийт өрхийн тоо	Нүүрс зэрэг бусад түлш хэрэглэж буй өрх	Мод түлдэг өрх	Өрхийн түлээний модны хэрэглээ (m <sup>3</sup> /жилд)	Улсын нийт хэрэглээ (m <sup>3</sup> /жилд)
500,000	250,000	125,000 зөвхөн мод түлдэг  125,000 холимог түлш /аргал болон мод /	4-7  1-2	625,000 to 1,125,000 <sup>1</sup>
500,000	160,000	340,000	5	1,700,000 <sup>2</sup>

Эх үүсвэр: <sup>1</sup>Батболд, WWF (хувийн санал) and <sup>2</sup>Ойн аж үйлдвэрийн холбоо (Хувийн санал).

103. Модны хэрэглээний хэмжээг бүсчилэн харуулсан сонирхолтой тооцоог (Ван Дер Плас 2003) энэхүү илтгэлд дурьдсан билээ. Уг дүн шинжилгээг дөрвөн бүс болгон хийсэн сон байна: Хойд бүс (шилмүүст ой), Өмнөд бүс (заган ой), Улаанбаатар (импортлогч) болон бусад хэсэг. Өрхийн их, бага хэрэглээний тооцоог дараах байдлаар гаргасан:

- Бүс бүрд гэр болон байшинд амьдарч буй өрхийн тоо болон тэдгээрийн хэрэглэж буй модыг зундаа хоол хийх , өвөлдөө халаалтын зорилгоор ашиглаахаар тооцсон
- Өрхийн хэрэгцээний түлшний модны зарцуулалтын хамгийн бага хэмжээ нь ( зундаа 2.5 м3, өвөлдөө 3.75 м3 ) байхад хамгийн их хэргэлээний хэмжээ ( зундаа 3.5м3, өвөлдөө 6.2м3) тус тус байна.

8-р хүснэгтэд дүн шинжилгээний үр дүнг үзүүлэв.

Хүснэгт 8. Түлшний модны хэрэглээний тооцоог бүсчилсэн харуулсан байдал

Бүс	Өрхийн тоо	Бага хэрэглээтэй	Их хэрэглээтэй
Хойд	154.041	753.337	1.348.213
Өмнөд	77.316	209.685	390.609
Улаанбаатар	161.273	144.833	293.561
Бусад газар	148.519	77.413	238.696
Бүгд	541.149	1.185.268	2.271.079

*104. Заган ойг тулинд хэрэглэж байгаагаас учирч буй дарамт.* Говийн бүсэд эрчим хүчний гол эх үүсвэр болж байгаа заган ойгоос түлээ түүж байгаагаас үүсэх үр дагавар нь онцгой сонирхол татаж байгаа юм. Насанд хүрсэн заг модны томоохон үндэс нь сул хөрс шороог тогтворжуулж, хөрсөн дээрх ургамал нь салхины зөөвөрлөх эффектыг бууруулдаг учраас цөлжилттэй тэмцэх, түүнийг хянахад заган ойн үзүүлэх үүрэг роль нь маш чухал. Насанд хүрсэн заг модыг түлээнд ашиглахаас гадна түүний навчыг малын тэжээл болгон ашигладаг ажээ. Хөдөө орон нутгийн малчид болон иргэд загийг албан бусаар өрхийн болон сургууль, эмнэлгийн түлшний зориулалтаар түүж байгаа учраас өнөөдөр заган ойн ашиглалтын талаар үндэсний хэмжээнд тооцсон найдвартай тоо баримт алга байна. Гэвч Баянхонгор аймгийн Баянтээг сумын засаг даргын тооцож байгаагаар тухайн суманд жилд 700 тн заг хэрэглэж байгаа бөгөөд үүний 200 тн-ыг аж ахуйн нэгж байгууллагууд, харин 500 тн-ыг өрхийнхөн хэрэглэж байгаа ажээ. Заган ойн 1 метр куб модыг 480 кг-ын нягтшилтай байдаг, түүнчлэн нэлээд хэмжээний заган ой бүхий 84 сумд байна гэж тооцож үзэх юм бол жилийн заган ойн ашиглалт нь 124500 куб метр буюу нийт 1.4 сая метр куб заган ойн нөөцийн 9 хувь орчим байна. Хүснэгт 8 үзүүлснээр өмнөд бүсийн хэрэглээ 1.7 оос 3.1 хувиар илүү байна. Энэхүү мод бэлтгэлийн дарамт нь тогтвортой бус бөгөөд өнөөдөр заган ойг аль хэдийнэ маш ноцтой байдлаар доройтуулаад байна.

105. "Сайжруулсан зуух төсөл" нь Байгаль орчны яам болон Дэлхийн банкнаас хамтран хэрэгжүүлж буй санаачилга ажээ. Үүний зорилго нь хот суурин газрын агаарын бохирдол (хог шороо, SO<sub>2</sub> болон нүүрсхүчлийн хий)-ыг багасгах, үүний тулд эрчим хүчийг үр ашигтайгаар хэрэглэдэг, цэвэрхэн шаталттай зуух нэвтрүүлэх явдал юм. Агаарыг бохирдуулж буй хүлэмжийн хийг бууруулахаас

гадна эдгээр зуух нь нүүрс, түлээний модыг маш багаар хэрэглэх давуу талтай ажээ. 440000 өрхийг одоогийн санал болгож буй 4 төрлийн зуухны аль нэгийг хэрэглэдэг болгосноор нүүрс хэрэглэж буй өрхүүдийн хувьд жилд 1 тн нүүрс хэмнэх, түлээний мод хэрэглэдэг өрхүүдийн хувьд 1,5 куб метр мод хэмнэх бололцоо олгож байгаа юм байна. Ингэснээр нүүрсний хувьд 1 өрх жилд 24-38 ам.доллар түлээний модны хувьд 22 ам.долларыг хэмнэх бөгөөд сарын 20 долларын цалинтай монголчууд олон байдгийг бодолцох юм бол энэ нь нэлээд ач холбогдолтой хэмнэлт болох юм. Хэрэв ийнхүү өндөр үр ашигтай зууханд шилжиж чадвал жил бүрийн түлшний хэрэглээ нь 70000 тн нүүрс, 510000 куб метр түлээний модоор багасах бололцоотой ажээ. ("Сайжруулсан зуух төслийн" удирдагчын хийсэн тооцоо).

106. Түлээний модны эрэлт хэрэгцээг бууруулахаар дотооддоо санаачилж буй бас нэг зүйл бол шахмал түлшний үйлдвэрлэл юм. Бага хэмжээгээр 2 төрлийн шахмал түлшийг үйлдвэрлэж байна. Нэгэнд нь аргал, цаас, нүүрсний хог, модны үртэс, модны хаягдал болон байгалийн бут сөөгийг ашиглаж байгаа бөгөөд нөгөөд нь нүүрсийг сайн бэхжүүлж, цэвэрхэн шатаах зорилгоор бага хэмжээний шавар, шохой хольж хийдэг байна. Эдгээр шахмал түлшний давуу тал нь түлээний модыг бодвол 18 хувийн илүү энерги боловсруулахаас гадна утаа багатай, агаарын бохирдуулах хог хаягдал нь бага байдаг ажээ. Шахмал түлшний үнэ нь зах зээл дээр борлуулагдаж буй түлээний модны үнийн гуравны хоёр л байдаг ажээ.

## VI. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

107. Монголын ойн салбар хямрал руу тун түргэн дөхөж байгаа бөгөөд уг хямралын үр дагавартай тэмцэхэд бэлэн биш байна. Энэ илтгэлийн зарим томоохон дүгнэлтүүдийг дахин тэмдэглэхэд:

- Одоогийн "ашиглалтын бүс" гэж нэрлэгдэж буй талбай нь дотоодын модны үйлдвэрлэлийг тэтгэх, түүний үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтыг татахад хүрэлцэхгүй байна;
- Мод бэлтгэлийн өнөөгийн хэмжээ нь бүхэлдээ тогтвортой бус, одоогийн ашиглалтад зориулсан талбайд энэ нь жилийн зөвшөөрөгдөх, тогтвортой хэмжээнээс 4 дахин их, хэрэв хамгаалалттай бүсийн модноос 25 орчим хувийг аж ахуйн зориулалтаар бэлтгэхийг зөвшөөрлөө гэж бодоход ч энэ нь жилийн зөвшөөрөгдөх хэмжээнээс 1.75 дахин их байхаар байна;
- Хууль бусаар мод бэлтгэх үйл ажиллагаа нь нийт мод бэлтгэлийн 36-80 хувийг эзэлж байгаа ба үүнээс Засгийн газар ямар ч татвар, хураамж авч чадахгүй байна. Нөгөөтэйгүүр ийм үйл ажиллагаа нь үйлдвэрлэлийн болон түлээний модны дотоодын зах зээлийн үнэд маш их сөрөг нөлөө үзүүлж байгаа ажээ;
- Хууль тогтоомж хэрэгжүүлэх дээрээс доош чиглэл нь бүхэлдээ үр дүнгүй байгаа бөгөөд орон нутгийнханд нутгийнхаа ойн менежментийг хариуцах эрхийг аажмаар олгох, хууль хэрэгжүүлэх одоогийн бүтэц тогтолцоог бэхжүүлэх зэрэг хоёр чиглэлийн стратеги нь хууль бусаар мод бэлтгэх явдлыг зогсоох хамгийн зөв боломжийг бүрдүүлж байна.
- Ойн нөөц баялаг болон ой ашиглалтын талаар хоорондоо маш зөрүүтэй мэдээлэл байгаа учраас ойн өнөөгийн төлөв байдлын талаар бодитой дүр зураг гаргахад бэрхшээлтэй байна;
- Бэлтгэхийг зөвшөөрч буй модны хэмжээ болон гоожингийн хураамж нь зах зээлийн хүчин зүйл болон үнтэй уялдахгүй байна;
- Түлшний мод нь одоогийн мод бэлтгэлийн 65-80 хувийг эзэлж байгаа бөгөөд голдуу хот, хөдөөгийн ядуу айл өрх гэрээ дулаацуулах, хоол унд хийхдээ хэрэглэж байна. Модны нөөц ноцтойгоор, хурдацтай буурч буй энэ үед түлшний модноос өөр бодитой хувилбар алга байна;
- Өрхийн түлшний хэрэгцээг хангах өөр хувилбарыг гаргаж ирэхгүй, модны нөөцийг одоогийн түвшинд шавхсан хэвээр байвал хот суурин газрын түлшний модны нийлүүлэлт энэ зууны эхний арван жилийн сүүлээр ноцтойгоор хомсдож, Монгол улсын биологийн төрөл зүйл болон ойн маш чухал нөөц баялагт ихээхэн хохирол учрах болно.

Ойн нөөц баялгийг асар их хэмжээгээр шавхаж, улмаар цаашид ямар ч хувилбаргүй болохоос өмнө одоогийн бэрхшээлтэй асуудлыг шийдье гэвэл нэн яаралтай арга хэмжээг зургаан тодорхой чиглэлээр авах хэрэгтэй байна. Гэхдээ эдгээр бэрхшээлтэй асуудлыг шийдэх талаар гаргах аливаа санаачилгыг няхуур болгоомжтой зохицуулж, тодорхой дараалалтайгаар, бага багаар үечлэн хэрэгжүүлэхгүй бол байдлыг улам муутгаж болно. Жишээлбэл:

- Түлээний модны оронд хэрэглэх боломжтой, хямд төсөр түлшний хувилбар гарч ирж байж хууль бусаар мод бэлтгэх явдлыг багасгаж, түлшний модны үнийг нэмэгдүүлэх боломжтой болно. Ингэхгүй бол, ядуу өрхүүд маш хэцүү байдалд орох болно;

- Хууль тогтоомжийг бүрнээ даган мөрдүүлдэг, хэрэгжүүлдэг журам тогтоохоос наана үйлдвэрлэлийн зорилгоор мод бэлтгэх талбайн хэмжээг нэмэгдүүлэх нэг ч арга хэмжээ авч болохгүй;
- Мод боловсруулах салбарт нэмүү өртөг буй болгох, тус салбарыг өндөр үр ашигтай байлгах талаар авах арга хэмжээг үр ашиггүйн улмаас дампуурах гэж буй модны үйлдвэрүүд, түүнээс үүдэх ажилгүйдлийн талаар авах шилжилтийн стратегитай хослуулах хэрэгтэй.

108. Дээр дурдсан зургаан чиглэлээр авах арга хэмжээг дор тайлбарлав:

### **6.1 Ойн менежмент болон хууль хэрэгжүүлэх үйл ажиллагааг сайжруулах**

- Хууль тогтоомж сахин мөрдүүлэх үйл ажиллагааны үндсийг ойн хууль тогтоомж, ойн менежментийн талаарх урт хугацааны стратеги болон шинжлэх ухаанд тулгуурласан ойг нөхөн сэргээх замаар ашиглах (силвикультур) арга барилтай зохицсон менежментийн төлөвлөгөө болон мод бэлтгэх зөвшөөрөл бүрдүүлж байх ёстой.
- Засгийн газар хууль тогтоомжийг хэрэгжүүлэх хүсэл зорилоготой байж, энэ ажлыг хийх мэргэжилтэй боловсон хүчнээр хангаж, тэдэнд үүргээ гүйцэтгэхэд нь шаардагдах материаллаг нөөцийг нь бүрдүүлж өгөх шаардлагатай.
- Дараах дарааллаар нэн тэргүүний ээлжинд авах арга хэмжээг тодорхойлно. Нэгдүгээрт, хууль бусаар мод бэлтгэж байгаагаас үүдэн учирч буй улсын орлогыг гаргуулж авах, зах зээлийн үнэд учирч буй сөрөг нөлөөг арилгахын тулд бүх хууль бусаар бэлтгэсэн модыг илрүүлж, хурааж, зах зээлийн үнээр дуудлага худалдаагаар зарах. Хоёрдугаарт, онцгой хамгаалалттай болон тусгай хамгаалалттай бүсэд хууль бусаар мод бэлтгэх явдлыг арилгах. Гуравдугаарт, өрхийн хэрэглээнд хэрэглэх түлшний бусад хувилбар гарч ирсний дараа түлшний мод бэлтгэх жилийн зөвшөөрөгдсөн, тогтвортой хэмжээтэй холбоотой хууль тогтоомжийг хэрэгжүүлэх.

### **6.2 Модны аж ахуй эрхлэх боломж болон жилд бэлтгэх модны хэмжээний дүгнэлтэд тулгуурлан ойн бүсчлэлийн асуудалыг шинэчлэх**

- Өргөн хүрээтэй тогтоосон "тусгай хамгаалалтын бүсийн" зарим хэсгийг менежментийн маш хатуу бөгөөд нарийн тодорхойлсон журмын дор ашиглалтын бүс болгон шилжүүлэх боломжтой эсэхийг (үүний тулд хууль тогтоомжид өөрчлөлт хийх шаардлага ч гарч болно) судлахын тулд тусгай хамгаалалттай бүсэд аж ахуй эрхлэх байгаль орчны болон эдийн засгийн боломжийн талаар судалгаа хийх шаардлагатай.
- Цаашид жилд бэлтгэх модны хэмжээг дунд болон урт хугацаанд тооцож гаргахад ашиглах суурь болгохын тулд одоогийн ашиглалтын бүсэд байгаа ой модны нөөц, төлөв байдлыг тодорхойлох, орчин үеийн аргаар явуулах ойн нөөцийн бүртгэл, тооллого хийх (энэ талаар дор 6.4-д дурдсан).

### **6.3 Ойн нөөцийн орон нутгийнханд түшиглэсэн менежментэд аажмаар шилжих**

- Модон болон модны бус нөөц баялгийг ашиглан зохицуулах үүргийг орон нутгийнханд шилжүүлэх зорилгоор ойн эзэмшил, менежментийн гэрээг орон нутгийнхантай хэлэлцэн тохирч байгуулах хэрэгтэй.

- Ойн эзэмшлийн үйл ажиллагааг төр, захиргааны байгууллагууд болон орон нутгийнхан хамтран удирдах ёстой. Төрийн байгууллагууд сургалт явуулах, төлөвлөхөд нь туслаж, хяналт тавин, харин орон нутгийнхан газар дээр нь ойн нөөцөө бүртгэх, ашиглах арга хэмжээ авна.
- Одоо хэрэгжиж байгаа хамтын эзэмшлийн ойн 22 гэрээг зогсоож болохгүй бөгөөд харин тэдгээрийн ихэнх нь ойн төрөл бүрийн нөөц баялгийг өөрсдөө цуглуулж, ашиглах, шинээр хэрэгжүүлэх орон нутгийнханд тулгуурласан хөтөлбөрийн хүрээнд өөрсдийн техникийн чадавхиа сайжруулах зорилгоор шинэ гэрээ байгуулахыг хүсэж байж болох юм.

#### **6.4 Ойн нөөцийн бүртгэл тооллого, мэдээллийн менежментийг боловсронгуй болгох**

- Ойн нөөц баялгийн одоогийн хайгуул судалгааны аргыг орчин үеийн стандартад тохируулан шинэчлэх шаардлагатай ба үүнийг шинэчилсэн ашиглалтын бүсэд хэрэглэх хэрэгтэй (Онцгой болон тусгай хамгаалалтын бүсэд бүртгэл, тооллогын өөр стандарт, арга техник шаардлагатай байдаг).
- Байгаль орчны яамны хүрээнд (орон нутгийнхны эзэмшлийн ойн бүсээс гаргуулж авсан, ойн нөөц баялгийн бүртгэл, тооллого, модны ургалт, гарц, мод бэлтгэлийн хэмжээний мэдээллийг нэгтгэсэн) байгаль орчны нөөцийн мэдээллийн менежментийн системийг орчин үеийн хиймэл дагуулын зураг, компьютерт тулгуурлан цогцолбор байдлаар буй болгох.

#### **6.5 Модны нөөцийг илүү үр ашигтай ашиглах, модноос өөр төрлийн эх үүсвэрийг ашиглах үйл ажиллагааг дэмжихэд зах зээлийн арга хэрэгслийг хэрэглэх нь**

- Засгийн газраас одоо хэрэглэж буй ой мод ашигласны төлбөрийн тогтолцоо нь хаягдлыг багасгах, нэмүү өртөг буй болгох болон өртөг багатай модон эдлэл хийхээс өөр хувилбар бий болгохыг урамшуулан дэмжихэд ямар ч нөлөө үзүүлэхгүй байна. Ойн нөөцөд учруулж буй дарамтыг багасгахын тулд, илүү чанартай бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ болон түлээний мод зэрэг нэн чухал бүтээгдэхүүнийг орлох бүтээгдэхүүн гарахтай зэрэгцүүлэн мод бэлтгэх хураамжийн хэмжээг бага багаар, няхуур төлөвлөж тооцсон үе шаттайгаар аажмаар нэмэгдүүлэх асуудлыг судлах хэрэгтэй.
- Орон нутгийнхны бэлтгэсэн модыг (тухайн орон нутгийнхан оролцсон) дуудлага худалдаагаар худалдаж, орсон орлогыг анхнаасаа хэлцэн тохирсон "орлогоо хуваалцах" гэрээний дагуу хуваарилах нь зүйтэй.

#### **6.6 Зүсмэл материал, түлээний мод болон ойн дагалт бүтээгдэхүүнийг боловсруулах, өөрчлөн зохион байгуулагдсан салбарт зохих хөрөнгө оруулалт хийх**

- Хаягдал багатай, өндөр чанартай хөрөөдсөн модон бүтээгдэхүүн гаргах чиглэлээр шинэ, бага оврын технологи нэвтрүүлэх санаачлагыг дэмжих хэрэгтэй. Орон нутгийнханд ой эзэмших менежментийн гэрээний дагуу бэлтгэсэн гуалингаа боловсруулахад нь төлбөртэйгээр үйлчилдэг зөөврийн хөрөөг цөөн тоогоор нэвтрүүлэх асуудлыг эхний ээлжийн стратеги болгон судлаж үзэж болох юм.
- Өрхийн хэмжээнд хэрэглэж буй түлээний үр ашгийг дээшлүүлэх талаар хэрэгжүүлж байгаа одоогийн стратегийг бэхжүүлж, өргөжүүлэх хэрэгтэй байна. Шахмал түлш зэрэг түлээний модны оронд хэрэглэж болох, арилжааны журмаар борлуулахуйц өөр хувилбарын түлш буй болгох санаачлагыг ч дэмжих хэрэгтэй.

- Орон нутгийнханд ойн дагалт баялагаас илүү их нэмүү өртөг гаргаж авах бололцоо олгохуйц ердийн технологийг сурталчлах техник эдийн засгийн судалгаа, үзүүлэх сургалт, төслүүдийг хэрэгжүүлэх нь зүйтэй. Ийм технологид (самар, мөөг, жимс болон эмийн ургамлыг хатаах) хатаагч, анхилуун үнэртэй ургамлаас эссенци тос ялгаруулах бага оврын нэрэгч машин зэрэг орж болох юм.

## **VII. ОЙН МОДНЫ САЛБАРТ ДЭЛХИЙН БАНКНААС ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЖ БОЛОХ ЧИГЛЭЛҮҮД**

### **7.1 Ой модны салбарт хандивлагчдаас үзүүлэх тусламжийг зохицуулах**

109. Монголтой ижил төстэй бэрхшээл амсаж байгаа орнуудад (тухайлбал, Индонез, Камбож, Лаост) ойн менежмент, байгаль хамгаалах болон хууль тогтоомж хэрэгжүүлэх чиглэлээр мэдэгдэхүйц ахиц гаргаж байгаа тохиолдолд Дэлхийн Банк тэргүүлсэн олон улсын хандивлагчид ой модны салбарт нь санхүүгийн туслалцааг үргэлжлүүлэн үзүүлж байна. Төр засгийн агентлагуудтай хамтран ойн модны салбарын тэргүүн чиглэлийн үйл ажиллаганы хөтөлбөрийг хамтран боловсруулах, түүнд зориулсан техникийн туслалцааг зохицуулах зорилгоор хандивлагчид "ой модны салбарын асуудлаарх зөвлөлдөх бүлгүүдийг" байгуулж ажилладаг. Дэлхийн Банк нь Монгол улсад ижил төстэй зохицуулагч механизмыг дэмжин сурталчлах, зохион байгуулах, дэмжих чиглэлээр ажиллах бололцоог эрэлхийлвэл зохино.

### **7.2 Эрх зүйн зохицуулалтын хяналт, хууль сахиулах болон хэрэгжүүлэх асуудлаар чадавхи буй болгох**

110. Техникийн туслалцааны ийм төслийн гол зорилго нь Байгаль орчны яам, хяналтын байцаагч, цагдаа, бусад байцаагчид, аймаг, сумдын захиргааны ажилтнуудын байгалын нөөц баялгийн талаарх бүх хууль тогтоомж, түүний дотор ойн нөөц баялагтай холбоотой хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжүүлэх чадавхийг бэхжүүлэхэд оршино. Төслийн хүрээнд хууль хэрэгжүүлэх үйл ажиллагааг үр бүтээлтэй болгоход зориулж зохих тоног төхөөрөмж олгох (холбоо, тээврийн хэрэгсэл, дүрэмт хувцас гэх мэт) мөн сургалтын хоёр хөтөлбөрийг орон нутгийн аль нэг их сургуультай хамтран зохион байгуулж болох юм. Үүнд:

- Монгол улсын байгалын баялгийн талаарх хууль, тогтоомжийн заалт, тавигдаж буй шаардлага, нөөц баялгийн тогтвортой менежментийн зарчим, шалгуурууд, нөөц баялгийн менежментийн төлөвлөгөө, төлөвлөсөн зорилтуудаа хууль хамгаалах, бодит амьдрал дээр хэрэгжүүлэх хэрэгсэл болсон зөвшөөрөл болгон ашиглах, байгалын нөөц баялгийн бүртгэл, тооцоо гаргах, түүнийг хууль тогтоомж сахих, хэрэгжүүлэхтэй уялдуулах талаар дэлгэрэнгүй тайлбарлах 2-3 долоо хоногийн үлгэр жишээ хэлбэрийн сургалт явуулах;
- Хууль тогтоомжийг биелүүлэх, биелэлтэд хяналт тавих, хууль хэрэгжүүлэх талаар газар дээр нь үзүүлэх сургалт хийх зэргээр 3-4 долоо хоногийн модуль хэлбэрийн сургалт зохиох. Энэ сургалтад мөн мод бэлтгэх, бусад ойн бүтээгдэхүүн цуглуулах журам, бүтээгдэхүүнд тэмдэг тавих, ажиглах тогтолцоо, системтэй ба стандартчилсан илтгэл, тайлан гаргах журам нэвтрүүлэх зэрэг орон нутагт, газар дээр нь хууль тогтоомжийн биелэлтийг шалгах, эргүүл харуул хийх, хяналт тавих арга техник, байцаагчид, байгаль хамгаалагчид, цагдаа, прокуроруудын хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоог үр бүтээлтэй болгох, хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд торгууль тавих, хуулийн дагуу мөрдөн шалгах, захиргааны торгуулиас өгсүүлээд

шүүхэд өгөх хүртэл хууль хэрэгжүүлэх олон төрлийн арга хэрэгслийг зохистой хэрэглэх зэрэг сэдвүүдийг хамарч болох юм.

### **7.3 Орон нутгийнхан ойн нөөц баялгийн менежментийг эрхэлсэн туршилтын төслүүд**

111. Ойн бүтээгдэхүүнийг хамтран ашиглах талаар орон нутгийнхан болон төр, захиргааны байгууллагууд гэрээний үндсэн дээр хамтран ажиллахад хүргэсэн, ойн тогтвортой менежментийн хөтөлбөрийг хандивлагчдын тусламжтайгаар хэрэгжүүлсэн Лаос улсын туршлага дээр үндэслэн Дэлхийн Банк энэ чиглэлээр ажиллаж болох юм. Орон нутгийнхан ойн менежментийг эрхэлж чадах юм гэдгийг таван жилийн хугацаатай хэрэгжсэн хоёр төсөл харуулж чадсан бөгөөд тус Банк болон Финлянд улсын Засгийн газрын ивээн тэтгэж буй зургаан жилийн хугацаатай шинэ төслийн хүрээнд Лаосын арилжааны зорилгоор ашиглах ойн 65 гаруй хувийг ийм тогтолцоонд хамруулах юм байна. Төслийг хэрэгжүүлж эхлэхийн өмнө орон нутгийн захиргааны ажилтнууд, тосгоны удирдлагуудад чадавхи буй болгоход чиглэсэн томоохон сургалтын хөтөлбөрийг урьдчилан явуулдаг ажээ. Засгийн газрын ойн асуудал эрхэлсэн албан тушаалтнууд тосгоныхныг ойн талаар төлөвлөгөө хийх, бүртгэл тооллого явуулах талаар сургадаг ба улмаар баталсан төлөвлөгөөг тэд хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавьдаг байна. Ой эзэмших эрхийг тосгонд бүхлээр нь олгодог ба үйл ажиллагааг төлөвлөхдөө тосгоны бүх гишүүдийн зөвшөөрлийг авсан байх ёстой. Тосгоныхон ойн менежментийн бүх үйл ажиллагааг тухайлбал мод бэлтгэх, шаардлагатай бол ойжуулах, ойн арчилгаа зэрэг ажил хэрэгжүүлдэг байна. Зохион байгуулалтын арга хэмжээг тосгоны ойн комисс авч хэрэгжүүлдэг ба тус комисс нь тосгоны зөвлөлд ажлаа тайлагнадаг ажээ. Ойтой холбоотой арга хэмжээнд тосгоны бүх иргэд оролцох албагүй бөгөөд харин оролцсон нэг нь зохих хөлс авдаг. Орлогыг (татвар, хураамж төлсөний дараа) дараах байдлаар хуваарилдаг байна. Үүнд:

- 10 хувийг үндсэний ойн агентлаг;
- 10 хувийг бүс нутгийн ой мод хариуцсан байгууллага (= аймаг);
- 40 хувийг дүүргийн ой мод хариуцсан байгууллага (үүнээс менежментийн бүх зардал, түүний дотор тосгоныхны цалинг төлдөг); (= сум)
- 40 хувийг тосгоны зөвлөлөөс захиран зарцуулдаг "Тосгон хөгжүүлэх санд" тус тус хуваарилдаг байна.

112. Орон нутгийнхан (тосгоныхон) ийнхүү экологийн үйл ажиллагаанд оролцоноор дараах боломж бүрдэж байна:

- биологийн төрөл зүйлийг тухайн орчинд нь хэвээр нь хадгалах;
- одоо байгаа тусгай хамгаалалттай газрын эргэн тойронд болон тэднийг хооронд нь холбосон ойн орчны бүсийг зохих менежменттэй болгох;
- ургамал болон амьтны гаралтай ойн дагалт баялагийг тогтвортойгоор ашиглан нэмүү өртөг буй болгох менежментийг бага багаар нэвтрүүлэх;
- эмзэг уулархаг, налуу газар, горхи усны эх үүсвэр, намаг болон бусад нэн чухал газар нутгийг бүсчлэн хамгаалах;
- нөөц нь хомосдож буй ойн экосистемийг сэргээх.

113. Лаос улсад хэрэгжүүлсэн хөтөлбөрийн үр дүнд ойн менежментийг газар дээр нь хэрэгжүүлэх ажил эрс сайжирсан ба орон нутгийнхны эзэмшлийн ойн бүсэд хууль бус үйл ажиллагаа эрс буурсан байна. Харин Лаост хэрэгжүүлсэн энэ хөтөлбөрийн үед ажиглагдсан гол дутагдалд тосгоны эзэмшлийн газрын хил хязгаарыг тогтооход учирсан бэрхшээл, бичиг үсэгтэй хүмүүсийн тоо маш бага (35-аас доош хувь), зарим бүс нутагт сургалт явуулах хэлийг нутгийн хүн ам тэр бүр мэдэхгүй байх тохиолдол цөөнгүй байв. Орон нутгийнхан хоорондоо харилцан зохион байгуулалтад орж, хамтран ажиллахад уламжлалт дадал заншил зарим нэг бэрхшээл Монголд гарч болох боловч, яс үндсээр хэт их ялгардаггүй, бичиг үсэгт тайлагдсан, анхан шатны боловсрол эзэмшсэн түвшин өндөр байгаа зэрэг нь харьцангуй давуу тал юм.

#### **7.4 Үр ашиг өндөртэй зуух ба шахмал түлш**

114. Ойн нөөцөд учирч буй дарамтыг арилгахад нэн тэргүүний ээлжинд авах цорын ганц арга хэмжээ бол түлшний модны хэрэглээг багасгах явдал. Дэлхийн Банк өнөөгийн хэрэгжүүлж буй төслүүдийн туршлага дээрээ үндэслэн сайжруулсан зуухны хөтөлбөр, шахмал түлшний үйлдвэрлэлийг өргөжүүлэх талаар хийх техник, эдийн засгийн судалгаа, ийм үйлдвэрлэлд анхан шатны дэмжлэг үзүүлэхэд анхаарал хандуулах хэрэгтэй байна.

## Ашигласан материал

А. Албак, Монголын ой ба ойн аж ахуй, 2000

Ж. Г. Брэтэно, *Монгол дахь ойжуулалт*, Германы техник хамтын ажиллагааны агентлагаас хэрэгжүүлж буй "Байгалын онгон төрхийг хадгалах, тусгай бүсийн хөгжил" төсөлд зориулсан судалгаа, 2001 он

Бодлого судлалын төв, Монголын хөдөө орон нутгийг хөгжүүлэх стратеги, 2002 он

Чандрасехарань С. Эд, *Монголын Үндэсний ойн хөтөлбөрийн тухай* НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн SPPD төсөл МОН/00/304: Үндэсний ойн хөтөлбөрийн хөгжил. НҮБ-ын Хүнс. Хөдөө аж ахуйн байгууллага, Байгаль орчны яам, Улаанбаатар, Монгол Улс, 2001 он

Дарст, П Танилцуулга, НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага, Мод тайралтын үр нөлөөг багасгах асуудал эрхэлсэн төвийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар, 2002 он

А. Энхбат, Ж. Цогтбаатар, 1997 Монголын ой ба ойн менежмент, RAP хэвлэл, 1997/4, НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага, Бангкок, Тайланд, 1997

Монгол Улсын Засгийн газар, Ойн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, 2002 он

Монгол Улсын Засгийн газар, Ойн аж ахуйн талаар хэрэгжүүлэх Үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2001 оны 248 тоот тогтоолын хавсралтын албан бус орчуулга

Монгол Улсын Засгийн газар, Ойн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, 2002 он

Хилми Х. А., *Монгол Улсын ойн аж ахуйн салбарын байгууллага болон чадавхийг бэхжүүлэх асуудлаар бэлтгэсэн зөвлөмж тайлан*, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн SPPD төсөл МОН/00/304, Үндэсний ойн хөтөлбөрийн хөгжил, Улаанбаатар, 2001 он

Жаакко Поури, Монгол Улсын Худалдаа аж үйлдвэрийн яаманд зориулж Финляндын Гадаад харилцааны яамны захиалгаар хийлгэсэн *Монголын ойн аж ахуйн салбарын талаар баримтлах стратегийн хөгжлийн судалгаа*. 1995 он

Японы ойн техникийн холбоо (ЯОТХ), Монгол Улсын Сэлэнгэ аймгийн ойн нөөц баялгийн менежментийн судалгаа, Японы олон улсын хамтын ажиллагааны агентлаг, Ойн менежментийн төв, Байгаль орчны яам, 1998

LUSO Консалт Хан Хэнтийн онцгой хамгаалалттай газрын баруун бүсийн ойн нөөц баялгийн тогтвортой ашиглалт ба байгалын онгон төрхийг хадгалах нь, ХБНГУ-ын Техник хамтын ажиллагааны агентлагийн нэрийн өмнөөс бэлтгэсэн тайлан, 1998 он

Меарнс Робин, Олон нийт, хамтран хэрэгжүүлэх арга хэмжээ, нийтийн бэлчээр: Социализмын дараах үеийн Монголын жишээ, Хөгжлийн судалгааны сэтгүүл, 22-р боть, 3 дахь дугаар, 297-339-р хуудас, 1996

Санхүү эдийн засгийн яам, Эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, ядуурлыг бууруулах стратеги, 2002 он

Монгол Улсын Бйгаль орчны яам, Монгол Улсын Үндэсний ойн бодлогын тухай тайлан

Ус цаг уур, Очныг хянах Үндэсний агентлаг, Монгол Улсын 2000 оны байгаль орчны талаарх статистикийн гарын авлага, Улаанбаатар, Монгол Улс, 2000 он

Монгол Улсын Үндэсний Статистикийн газар, Монголын Статистикийн тойм, 2002 он

Руциска И, Монголын байгаль орчин, Азийн хөгжлийн банкны үйл ажиллагаанд үзүүлэх түүний нөлөө, 2001 он

Теусан С. М, Монголын ойн бүртгэл, ойн төлөвлөлт, Одоогийн практикт хийсэн дүн шинжилгээ, ойн хэтийн төлөвлөлтийн талаар өгөх зөвлөмж, Германы техник хамтын ажиллагааны агентлаг, 95.3515.4, төсөл, 2000 он

Монголын тогтвортой хөгжлийн үндэсний зөвлөл, Монгол Улсын мөрийн хөтөлбөр-21, Улаанбаатар, (Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 5-р сарын 82 тоот тогтоолоор батлагдсан)

Дэлхийн банк, Монголын байгаль орчны хяналт, Дэлхийн банкны байр, Улаанбаатар, 2002 он

Дэлхийн банк, Монголын төрийн секторын зардлын тойм, 2002 он

Т.Уламбаяр, Н.Гомбосүрэн, Э.Дүгэржав, Олон нийтэд түшиглэсэн ойн аж ахуйг хөгжүүлэх төсөл, Булган аймаг, Монгол Улс, (Монгол дахь Дэлхийн зөн байгууллагад зориулж бэлтгэв), 2002 он

НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, Монголын Байгаль орчны яам, Монголын байгаль орчны өнөөгийн байдал, 2002, НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөрийн Ази Номхон далайн бүс нутгийн нөөцийн төв, Пантхумтани, Тайланд, 2002 он

Ваггенер Т, Зах зээлийн эдийн засагт шилжих өөрчлөлтийн хүрээнд хийгдэж буй ойн бүтээгдхүүний үнэ тогтоолтын өнөөгийн нөхцөл байдал, Хятад, Монгол, Бирм, Вьетнам, 1998 он

Вингард Ж.Р, Пүрэвдолгорын Одгэрэл, Монголын Байгаль орчны тухай хууль тогтоомж, хэрэгжүүлж буй практикийн тухай гарын авлага, Германы техник хамтын ажиллагааны агентлагийн шугамаар хэгжүүлж буй Худалдааны болон иргэний хуулийн шинэчлэл төсөл, Улаанбаатар, Монгол Улс, 2001 он

Дэлхийн байгаль орчны сан, Монгол, Монгол дахь гуалингийн хууль ёсны болон хууль бус арилжааны талаарх тайла, 2002 он

Икханбай Х, Байгаль орчин, тогтвортой хөгжлийн эдийн засаг, 2000 он

## Тайланг бэлтгэх явцад уулзаж зөвлөлгөө авсан хүмүүс

И.Ариунзул, Байгаль орчныг хамгаалах агентлагийн дэд дарга, улсын ахлах байцаагч,

Д.Батболд, Дэлхийн байгаль орчны сангийн Монголын хөтөлбөрийн Байгалийн унаган төрхийг хамгаалах хэлтсийн дарга

Болд, Ой модны яамны сайд асан

Т. Дамдин, Байгаль орчны яамны Бодлогын хэрэгжүүлэлт, зохицуулалтын газрын дарга

Дашдаваа, БОЯ-ны Байгаль, ой, усны агентлагийн ахлах мэргэжилтэн

Л.Доржцэдэн, БОЯ-ны Ой модны аж ахуйн үндэсний хорооны нарийн бичгийн дарга

Финч К, Дэлхийн банкны Монгол дахь Суурин төлөөлөгчийн газар, зөвлөх

Д.Энхсайхан, (Докт), Ойн менежментийн төслийн захирал

Грэйсон Р, Эко Минекс Интернэйшнл ХХК-ийн ерөнхий захирал

Хоффман Х, Германы техник хамтын ажиллагааны нийгэмлэгийн Байгалийн нөөцийн тогтвортой менежмент төслийн Тэргүүн зөвлөх

Жонсон Ж, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Байгаль орчны асуудал хариуцсан ахлах зөвлөх

У.Хорлдаваа, БОЯ-ны Байгаль, ой, усны агентлагийн дарга

Ж. Лувсанцэрэн, Монголын ойчдын нэгдсэн холбооны ерөнхийлөгч

М. Мөнхзориг, БОЯ-ны Бодлого хэрэгжүүлэлт зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

Т.Ням-Осор, Булган аймгаас сонгогдсон Улсын их хурлын гишүүн

Д. Оюунцэцэг, Дэлхийн банкны "Өрхийн зуухыг сайжруулах" төслийн менежер

Н.Оюундарь, БОЯ-ны Хамтын ажиллагааны хэлтсийн дарга

Пүрэвraagчаа, Мод судлах төвийн захирал

Р.Сарангоо, БОЯ-ны Хамтын ажиллагааны хэлтсийн ахлах ажилтан

М.Саули, БОЯ-ны Санхүү эдийн засгийн хэлтсийн мэргэжилтэн

Шмидт С (Докт), ГТХАН-ийн Тусгай хамгаалалттай газрын менежмент, Байгаль хамгаалал, орчны бүсийн хөгжил төслийн зөвлөх

Стейнер Буркарт Б, (Докт), ГТХАН-ийн зөвлөх

Свенсон К, Алтай таван богд Үндэсний парк төслийн менежер, Шинэ Зеландын байгаль орчны хүрээлэн, Хүн төвтэй байгаль хамгаалал санаачлага

Ж. Цогтбаатар, Шинжлэх ухааны академийн Гео экологийн хүрээлэнгийн захирал

Т. Цогоо, Монголын ой модны аж үйлдвэрийн холбооны ерөнхийлөгч

У. Тунгалаг, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Ядуурлыг судлах, ажил олоход туслалцаа үзүүлэх үндэсний төслийн менежер